

**ЭМНЕСТИ**  
**ИНТЕРНЭШНЛ**



**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ТАЙЛАН 2016/17**  
**ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДАЛ**

16

# ГАРЧИГ

<b>НЭР ТОМЪЕОНЫ ТОВЧЛОЛ</b>	<b>2</b>
<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>4</b>
<b>АФРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>9</b>
ТАЙВАН ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ ХҮЧЭЭР ТАРААСАН НЬ	10
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД БА СЭТГҮҮЛЧДИЙН ЭСРЭГ ХАЛДЛАГА	11
УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ	13
ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН	14
ДҮРВЭЖ БУЙ ХҮМҮҮС	16
ГЭМТ ЭТГЭЭДҮҮД ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭЖ, ШУДАРГА ЁС АЛДАГДСААР БАЙНА	16
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА АД ШОО ҮЗЭХ	18
ЦААШДЫН ХАНДЛАГА	19
<b>АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>21</b>
ЭРСДЭЛ ДУНДАХ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	24
АМЕРИК ХООРОНДЫН ХҮНИЙ ЭРХИЙН СИСТЕМД ТУЛГАРЧ БУЙ АЮУЛ	25
ДҮРВЭГЧ, ЦАГААЧ, ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮМҮҮС	26
НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ	27
ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХ, ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ЗОГСООХЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ	28
ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ	30
УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ	31
ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНЖЕНДЭР, ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ	31
<b>АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>32</b>
ЗҮҮН АЗИ	35
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	35
ДҮРВЭЖ БУЙ ХҮМҮҮС	36
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ	36
ӨМНӨД АЗИ	37
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	37
ДҮРВЭЖ БУЙ ХҮМҮҮС	38
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ	39
ЗҮҮН ӨМНӨД АЗИ БА НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ	40
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД	40
ДҮРВЭЖ БУЙ ХҮМҮҮС	42
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ	43
<b>ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>44</b>
ДҮРВЭЖ БУЙ ХҮМҮҮС	45
ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ	48
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ	50
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ,	
ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ	52
ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭХ БА ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ	54
ЦААЗААР АВАХ ЯЛ	54
ХЯМРАЛ МӨРГӨЛДӨӨН БА ЗЭВСЭГТ ХҮЧИРХИЙЛЭЛ	54
<b>ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ</b>	<b>56</b>
ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН	56
ОЛОН УЛСЫН ОРОЛЦОО	59
ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ	60
ШҮҮХ ТОГТОЛЦОО	62
ДҮРВЭГСЭД, ДОТООДДОО ШИЛЖИН СУУРЬШИГСАД БОЛОН ЦАГААЧИД	63
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ	64
ЦӨӨНХИЙН ЭРХ	65
ЛЕСБИАН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНЖЕНДЕР БОЛОН ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ	65
ЯЛ ЗАВШИХ	66
ЦААЗААР АВАХ ЯЛ	67
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧИД	68

# НЭР ТОМЪЁНЫ ТОВЧЛОЛ

**ASEAN (ЗӨАОХ)** > Association of Southeast Asian Nations (Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо)

**AU (АХ)** > African Union (Африкийн Холбоо)

**CEDAW (ЭЭЯГБХУК)** > UN Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенци)

**CEDAW Committee (ЭЭЯГУХ)** > UN Committee on the Elimination of Discrimination against Women (Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах НҮБ-ын хороо)

**CERD (АҮАҮБХУТОУК)** > International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination (Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын Конвенци)

**CERD Committee (АҮАҮХ)** > UN Committee on the Elimination of Racial Discrimination (Арьс, үндсээр Алагчлахыг устгах НҮБ-ын хороо)

**CIA (ТТГ)** > US Central Intelligence Agency (АНУ-ын Тагнуулын Төв Газар)

**ECOWAS (БАОЭЭН)** > Economic Community of West African States (Баруун Африкийн Орнуудын Эдийн Засгийн Нийгэмлэг)

**EU (ЕХ)** > European Union (Европын Холбоо)

**European Committee for the Prevention of Torture (Эрүү шүүлтээс сэргийлэх Европын Хороо)** > European Committee

for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс сэргийлэх Европын хороо)

**European Convention on Human Rights (Хүний Эрхийн Асуудлаарх Европын Конвенц)** > (European) Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенц)

**ICC (ОУЭШ)** > International Criminal Court (Олон улсын эрүүгийн шүүх)

**ICCPR (ИУТЭТОУП)** > International Covenant on Civil and Political Rights (Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт)

**ICESCR (ЭЗНСЭОУП)** > International Covenant on Economic, Social and Cultural Rights (Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай Олон Улсын пакт)

**ICRC (ОУУЗХ)** > International Committee of the Red Cross (Олон Улсын Улаан Загалмайн Хороо)

**ILO (ОУХБ)** > International Labour Organization (Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага)

**International Convention against enforced disappearance (Хүчээр алга болгохоос хамгаалах Олон Улсын Конвенц)** > International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance (Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай Олон Улсын Конвенц)

**LGBTI (ЛГБТИ)** > lesbian, gay, bisexual, transgender and intersex (Лесбиян, Гей, Бисексуал,

Трансгендэр, Интерсекс)

**NATO (НАТО)** >North Atlantic Treaty Organization (Умард Атлантын Гэрээний Байгууллага)

**NGO (ТББ)** >non-governmental organization (Төрийн бус байгууллага)

**OAS (АОБ)** >Organization of American States (Америкийн Орнуудын Байгууллага)

**OSCE (ЕАБХАБ)** >Organization for Security and Co-operation in Europe (Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага)

**UK (НВУ)** >United Kingdom (Нэгдсэн Вант Улс)

**UN (НҮБ)** >United Nations (Нэгдсэн Үндэстний Байгууллага)

**UN Convention against Torture (НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц)** >Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц)

**UN Refugee Convention (НҮБ-ын дүрвэгсдийн конвенц)** >Convention relating to the Status of Refugees (Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенц)

**UN Special Rapporteur on freedom of expression (Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч)** >UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression (Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, дэмжих асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч)

**UN Special Rapporteur on racism (Ялгавар үзлийн асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч)** >Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance (Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх Тусгай Илтгэгч)

**UN Special Rapporteur on torture (Эрүү шүүлтийн асуудлаарх тусгай илтгэгч)** >Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment (Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх асуудлаарх Тусгай Илтгэгч)

**UN Special Rapporteur on violence against women (Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх тусгай илтгэгч)** >Special rapporteur on violence against women, its causes and consequences (Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дүнгийн талаарх Тусгай Илтгэгч)

**UNHCR, the UN refugee agency (НҮБ-ын дүрвэгсдийн газар, НҮБДАДКГ)** > Office of the United Nations High Commissioner for Refugees (Дүрвэгсдийн Асуудлаарх НҮБ-ын Дээд Комиссарын Газар)

**UNICEF (НҮБХС)** >United Nations Children's Fund (НҮБ-ын Хүүхдийн Сан)

**UPR (ЭДХ)** >UN Universal Periodic Review (НҮБ-ын Ээлжилт Дүгнэлт Хэлэлцүүлэг)

**USA (АНУ)** >United States of America (Америкийн Нэгдсэн Улс)

**WHO (ДЭМБ)** >World Health Organization (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага)

# ӨМНӨХ ҮГ

**“Ямар ч үнээр хамаагүй эрх мэдэлд хүрэх гэсэн, эрх мэдлээс зуурч үлдэх гэсэн хүмүүсийн айлгаж, яллаж, буруутгахаар зохиосон сурталчилгаа, сүртэй яриагаар хүний эрхэм чанар, тэгш эрх, хүн төрөлхтний гэр бүл гэсэн үзэл санаа руу хайр найргүй, хүчтэй дайрч, довтолж байгааг 2016 онд бид харлаа.”**

## **ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, САЛИЛ ШЕТТИ**

2016 онд төр засаг, зэвсэгт бүлэглэлүүд хүний эрхийг олон янзаар тоо томшгүй зөрчсөнөөс болж, сая сая хүний хувьд ёроолгүй зовлон, хэмжээлшгүй айдсаар дүүрэн жил болж өнгөрөв. Сири улсын хамгийн олон хүн амтай Алеппо хотын дийлэнх хэсэг агаарын довтолгоо, гудамжны тулаанд үнсэн товрог болсон бол Йемен улсад энгийн иргэд рүү балмадаар довтолсоор байна. Мьянмар улс дахь Рохингя хүмүүсийн хувь заяа улам дордож, Өмнөд Суданд хүмүүсийг хууль бусаар хоморголон хөнөөж, Турк, Бахрейн улсад өөрөөр сэтгэгчдийг нухчин дарж, Европ, АНУ-ын ихээхэн хэсэгт үзэн ядах хандлага өсч, 2016 онд дэлхий ертөнц улам бараан, улам тогтворгүй боллоо.

Түүний зэрэгцээ ам ажил хоёр, уран үг ба бодит байдал

хоорондоо тэнгэр газар шиг зөрж, заримдаа итгэхэд ч бэрх боллоо. 9 дүгээр сард дүрвэгчид ба цагаачдын асуудлаар чуулсан НҮБ-ын дээд хэмжээний уулзалтад оролцсон улсууд улам хүрээгээ тэлж, гамшгийн хэмжээнд хүрсэн дэлхий дахины дүрвэгсдийн асуудлыг шийдэх талаар олигтой тохиролцоонд хүрээгүй нь үүний тод жишээ юм. Дэлхийн удирдагчид өмнөө тулгарсан сорилтыг сөрөн зогсож чадахгүй байх хооронд 75000 дүрвэгч Сири ба Йордан улсын хоорондох эзэнгүй цөлд гацлаа. 2016 оныг Африкийн холбоо Хүний эрхийн жил болгон зарласан боловч гишүүн 3 улс нь Олон улсын эрүүгийн шүүхээс гарч байгаагаа мэдэгдсэн явдал гэмт хэрэгтэнд олон улсын эрх зүйгээр хариуцлага хүлээлгэх практикт ухралт гаргасан урагшгүй хэрэг боллоо. Түүнчлэн Засгийн газар нь Дарфурт ард түмнийхээ дээрээс химийн бөмбөг хаяж байхад Суданы Ерөнхийлөгч Омар аль-Башир ямар ч ял шийтгэл хүлээлгүйгээр Африк тивээр чөлөөтэй аялсаар байна.

Улс төрийн тавцанд гарсан магадгүй хамгийн донсолгоонтой үйл явдал бол Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон явдал юм. Тэрээр сонгуулийн кампанит ажлынхаа үеэр эмэгтэйчүүдийг үгүйсгэсэн, гадаадынхныг үзэн ядсан агуулгатай хүмүүсийг хооронд нь талцуулсан мэдэгдлийг олонтаа хийж байсны сацуу нэгэнт тогтсон иргэний эрх чөлөөг хязгаарлаж, хүний эрхэд халтай бодлого явуулна гэдгээ амалсан.

Дональд Трампын сонгуулийн кампанит ажлынхаа үеэр хэрэглэж байсан хорсол заналтай үг хэллэг

илүү их уур бухимдалтай, илүү их хоорондоо талцсан улс төр дэлхий нийтэд дэлгэрч байгаагийн тод жишээ юм. Дэлхий даяар удирдагчид, улс төрчид ирээдүйн хүч чадлаа айдас, зөрчлийг дэвэргэсэн үг ярианд үндэслэж, сонгогчдийнхоо гомдол, цөхрөлийн бурууг бусдад тохож байна.

Түүний өмнөх Ерөнхийлөгч Барак Обама хүний эрхийг хамгаалах талаар олон алдаа гаргасны дотор ТТГ-ын дроноор цохилт өгөх нууц кампанит ажлыг өргөжүүлсэн төдийгүй шүгэл үлээгч Эдвард Сноудений илрүүлсэн олон нийтийг мөрдөн хянах аварга механизмыг бий болгосон. Гэтэл Ерөнхийлөгчөөр сонгогдсон Дональд Трамп олон талт хамтын ажиллагааг үл тоомсорлосон, тогтворгүй байдал өдөөж, илтгэлцлийг сарниулсан гадаад бодлого явуулж магадгүй гэж харагдаж байна.

Өнгөрсөн жил дэлхийг донсолгосон олон үйл явдлыг нэгтгэн тайлбарлахыг хичээх нь зүйн хэрэг. Гэвч бид 2017 оныг үнэн хэрэгтээ айдас хүйдсээр дүүрсэн, туйлын тогтворгүй дэлхий ертөнц, тодорхойгүй ирээдүйгээр эхлүүлж байна.

Ийм нөхцөлд 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан үнэт зүйлс алдагдах аюулд өртөөд байна. Хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн их цус урсгасан цаг үеийн дараахан батлагдсан уг Тунхаглалын оршилд *"Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энхтайвны үндэс мөнийг иш үндэс болгон..."* хэмээн дурдсан байдаг.

Гэвч өнгөрсөн үеийн сургамжийг эс харгалзан 2016 онд хүний нэр төр, тэгш эрх зэрэг хүн төрөлхтний ам бүлийн үндсэн ойлголт ямар ч үнээр хамаагүй эрх мэдэл олж авахыг эсхүл эрх мэдлээ хадгалж үлдэхийг хүссэн этгээдүүдийн бусдыг буруутгаж, айдас хүйдсийг дэвэргэж, хэн нэгийг золигт гаргах гэсэн эцэж цуцашгүй дайралтад нэрвэгдлээ.

Үүний илрэл нь Сири, Йеменд эмнэлгүүдийг зориудаар удаа дараа бөмбөгдөж, дүрвэгсдийг хямрал мөргөлдөөний бүс рүү буцаан хөөж, 1994 онд Руандад, 1995 онд Сребреникад хийсэн алдааг давтаж, Алеппогийн талаар бараг юу ч хийлгүй, дэлхийн бараг бүх бүс нутгийн улс орны Засгийн газрууд өөрөөр сэтгэгчдийн дуу хоолойг хорих томоохон ажиллагааг авч хэрэгжүүлсэн явдал юм.

Байдал ийм байхад дэлхий ертөнцийн дүр зургийг хар бараанаар дүрслэхэд дэндүү амархан болоод байна. Тиймээс хүн төрөлхтний цаашдын ирээдүй шалтгаалах үнэт зүйлсийг бадраах хойшлууулшгүй бөгөөд төвөгтэй зорилт бидний өмнө ирээд байна.

2016 онд гарсан санаа зовоох зүйлсийн нэг бол оролцооны эрх, иргэний эрх чөлөөг нь барьцаалан аюулгүй байдал ба эдийн засгийн нөхцлийг дээшлүүлэх амлалтыг Засгийн газрууд ард түмэндээ өгөх болсон явдал юм. Өөрөөр сэтгэгчдийг нэг бол ил тодоор, хүч хэрэглэж, эсхүл аядуугаар, шударга ёс гэсэн нэрээр халхавчлан хоморголон нухчин дараагүй улс орон нэг ч үлдсэнгүй. Шүүмжлэлт дуу хоолойг хаах гэсэн оролдлого дэлхийн дийлэнх хэсэгт нэмэгдэн, эрчимжлээ.

3 дугаар сарын 2-нд Гондурасын

уугуул иргэдийн удирдагч Берта Касерасыг хөнөөсөн явдал төр засгийн ба бизнесийн хүчирхэг ашиг сонирхлын эсрэг зоригтойгоор сөрөн зогсогч хувь хүмүүст ямар их аюул ирдгийн томоохон жишээ болсон. Америк тив болон бусад газарт байгаа хүний эрхийн зоригт хамгаалагчдыг Засгийн газрууд эдийн засгийн хөгжилд аюул занал учруулагчид гэж үздэг. Учир нь нөөц баялгийг ашиглах болоод дэд бүтцийн төслүүдийн хүний эрх болон хүрээлэн буй орчинд учрах үр дагаврыг онцлон анхаарах ёстой гэж хүний эрхийн хамгаалагчид үздэг. Нутгийн иргэд болон газар шороогоо хамгаалах Берта Касерасын ажил, тэр дундаа хамгийн сүүлд далан барихыг эсэргүүцсэн нь дэлхийн олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн. Түүнийг гэртээ байхад амь насыг нь хөнөөсөн зэвсэгт этгээдүүд бусад идэвхтэн, ялангуяа түүн шиг олон улсын түвшинд танигдаж амжаагүй хүмүүсийг сүрдүүлэхийг хүссэн.

Аюулгүй байдлыг хангах нэрээр жагсаал, цуглааныг дарах арга дэлхий даяар өргөн хэрэглэгдэх боллоо. Этиоп улсад Оромиа мужид газар эзэмших эрхийг шударга бусаар булаан авсныг эсэргүүцсэн тайван жагсаал, цуглааныг тараахдаа хүчний байгууллагынхан хэдэн зуун хүнийг хөнөөж, эрх баригчид хэдэн мянган хүнийг дур зоргоороо баривчилсан. Этиопын Засгийн газар өөрсдийн баталсан Терроризмын эсрэг тунхагыг хүний эрхийн идэвхтэн, сэтгүүлчид болон сөрөг хүчний гишүүдийг нухчин дарахдаа ашигласаар байна.

Турк улс 7 дугаар сард төрийн эргэлт хийх гэсэн оролдлогын улмаас зарласан онц байдлын үеэр

өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах ажлаа идэвхжүүлсэн. 90 000 гаруй төрийн албан хаагчдыг “террорист байгууллагатай холбоотой буюу үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулсан” гэх үндэслэлээр ажлаас нь халж, 118 сэтгүүлчийг баривчлан хорьж, 184 хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоов.

Ойрх Дорнод, Хойд Африк даяар өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах явдал тахал мэт тархав. Египет улсад хуулиар хориглосон Исламын ахан дүүс байгууллагыг дэмжигч гэгдсэн хүмүүсийг болон Засгийн газрыг шүүмжлэгч, эсэргүүцэгч бусад хүнийг дур зоргоор баривчилж, хүчээр сураггүй болгож, эрүү шүүлт тулгаж байна. Бахрейний эрх баригчид өөрсдийг нь шүүмжлэгчдийг үндэсний аюулгүй байдалд аюул учруулсан хэмээх өргөн үндэслэлээр ял тулгаж байна. Ираны эрх баригчид өөрсдийг нь шүүмжлэгчдийг шоронд хорьж, хэвлэл мэдээллийг хатуу хянаж, Засгийн газар болоод Засгийн газрын явуулж буй бодлогыг шүүмжилсэн хэнд ч болов эрүүгийн ял тулгах боломжтой шинэ хууль баталсан.

Хойд Солонгосын Засгийн газар харилцаа холбооны технологид тавих хяналтаа чангатгах замаар залхаан цээрлүүлэлтийн тогтолцоогоо улам гүнзгийрүүлэв. Засгийн газруудын авч хэрэгжүүлсэн хатуу арга хэмжээ ихэвчлэн өөрсдийнхөө алдаа дутагдлыг нуух зорилготой байв.

Тухайлбал, Венесуэл улсын Засгийн газар даамжирч байгаа хүмүүнлэгийн хямралын эсрэг арга хэмжээ авахын оронд эрх баригчдыг шүүмжлэгчдийг дуугүй болгохыг хичээсэн.

Шууд аюул занал, халдлагаас гадна аюулгүй байдлыг хамгаалах нэрээр иргэний болон улс төрийн эрхийг далдуур хумисаар байна. Тухайлбал, Их Британи улс Мөрдөн шалгах эрхийн тухай хэмээх шинэ хууль баталсан бөгөөд уг хуулиар хувь хүний эсрэг үндэслэл бүхий сэжиг байгааг нотлох шаардлагагүйгээр тухайн хүний цахим харилцаа холбоо, өгөгдлийг саатуулах, тэдгээрт нэвтрэх, хадгалах буюу хакердах эрх баригчдын эрх мэдлийг ихээхэн өсгөсөн. Их Британи улс дэлхийн өөр ямар ч улсад байхгүй өргөн хүрээтэй мөшгин хяналтын тогтолцоог нэвтрүүлснээрээ хувийн нууцаа хадгалах эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх явдлыг ихээхэн өөгшүүлсэн.

Түүнчлэн хүний эрхийн үнэт зүйлийг сүйтгэж буй хамгийн том жишээ бол эрх баригчид өөрсдийн түрэмгий ажиллагааг зөвтгөхийн тулд “өөр бусад” хүмүүсийг нийгмийн бэрхшээлтэй асуудалд буруутгах болсон явдал юм. Бусдыг үзэн ядсан, хагалж бутаргасан, хүн биш гэж доромжилсон үг яриа хүний хамгийн хар бараан зөн совинг сул тавих болсон. Европ, АНУ-д эрх баригчид нийгэм, эдийн засгийн бэрхшээлтэй асуудлын бурууг хэсэг бүлэг хүмүүс, тэр дундаа угсаатны буюу үндэстний цөөнхөд нийтэд нь тохож байгаа нь ялангуяа ялгаварлан гадуурхалт, үзэн ядах гэмт хэргийг чөлөөтэй үйлдэх боломж олгосон.

Үүний нэг жишээ нь Филиппин улсын Ерөнхийлөгч Родриго Дутертегийн зарласан “хар тамхины эсрэг дайн”-ы улмаас олон хүн амь насаа алдсан явдал юм. Тэрээр хар тамхины хэрэгт холбогдсон этгээдүүдийг хороох

хэрэгтэй хэмээн дахин давтан олон нийтэд мэдэгдсэний улмаас төрийн дэмжлэгтэйгээр сайн дурын эргүүлийнхний үйлдсэн хүчирхийлэл, хоморголон хядалтаас үүдэн 6000 гаруй хүн амиа алдаад байна.

“Тогтсон дэглэмийн эсэргүүцэгч” хэмээн өөрсдийгөө өргөмжилсөн этгээдүүд нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээлд элитүүд, олон улсын байгууллага болон “өөр бусад” хүмүүсийг буруутгаж байгаа нь зохисгүй хэрэг юм. Ажилгүйдэл, ажлын байрны баталгаа алдагдсан, тэгш бус байдал өсөн нэмэгдэж, нийтийн үйлчилгээ алдагдаж байгаагаас үүдэн аюулгүй байдал алдагдаж, хүний эрх хумигдаж байгаа нь Засгийн газраас хүчин чармайлт, нөөц бололцоо, бодлогоо өөрчлөхийг шаардаж байгаа бөгөөд хэн нэгнийг золигт гаргах хялбар аргыг сонгох ёсгүй.

Дэлхий даяар урам зориг нь мохсон олон хүн хүний эрхийн асуудалд хариулт олохыг чармайдаггүй. Гэвч Засгийн газрууд иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлж чадахгүй байгаагаас шалтгаалан тэгш бус байдал, шоовдорлолоос үүдэлтэй олон нийтийн уур хилэн улам өсч байна.

2016 оны түүх бол асар их сорилт, аюул заналыг хүмүүс эр зориг, тэсвэр тэвчээр, бүтээлч сэтгэлгээ, тууштай байдлаараа даван туулсан түүх юм.

Дэлхийн бүх бүс нутагт төр нь иргэнээ дарангуйлдаг газарт хүмүүс түүнийг эсэргүүцэн босож, дуу хоолойгоо өргөх арга замыг олж чаддаг нь харагдлаа. Хятадад үргэлж айлган сүрдүүлж, заналхийлдэгийг эс хайхран 1989 онд Тяньаньмэний бослогыг дарсны



ойг онлайнгаар тэмдэглэх арга замыг идэвхтнүүд олж чадсан. Риогийн Олимпын тоглолтын үеэр Этиопын марафоны тамирчин Фейса Лилеса мөнгөн медаль хүртэх барианы шугамыг давахдаа тус улсын Засгийн газар Оромо хүмүүсийг хавчин хяхаж буйг дэлхийн хэвлэл мэдээллийн анхааралд аваачсан. Түүнчлэн Европ тивд Газрын дундад тэнгисийн эргээр сайн дурынхан усанд живж буй хүмүүсийг аварснаараа Засгийн газрууд дүрвэгсдийг хамгаалж чадахгүй байгааг эсэргүүцсэн. Африк тив даяар, зарим нь жилийн өмнө огт төсөөлж байгаагүй ард түмний хөдөлгөөн өрнөж, хүний эрх хийгээд шударга ёсыг шаардлаа.

Эцэст нь, хүний эрх гэдэг бол элитүүдийн санаа тавих зүйл хэмээх үзэл хоосон зүйл болох нь харагдсан. Эрх чөлөө, шударга ёсны төлөөх хүн ардын зөн совин зүгээр нэг алга болчихгүй. Хагарал бутрал, бусдыг хүн гэж үзэхгүй байх явдлаар дүүрэн өнгөрсөн 2016 онд хүн бүрийн хүмүүнлэг, хүний ёсоор амьдрах эрхийн төлөөх хүмүүсийн үйл ажиллагаа өмнө нь байгаагүй тодоор гэрэлтлээ. Тухайлбал, “Алеппогийн алиалагч” гэгддэг 24 настай Анас аль-Баша Засгийн газрын зэвсэгт хүчин Алеппо хотыг өршөөлгүйгээр бөмбөгдөж эхлэсний дараа ч гэсэн хүүхдүүдэд баяр баясгалан бэлэглэхээр үлдсэн юм. 11 дүгээр сарын 29-нд түүнийг агаарын цохилтод өртөн нас барсны дараа түүний дүү “хамгийн хар бараан, хамгийн аюултай газар”-т хүүхдүүдэд аз жаргал бэлэглэж байсныг нь хүндэтгэн дурссан.

2017 он гарч байгаатай зэрэгцээд ирээдүйд юу тохиолдох

талаар дэлхий ертөнц эмээж байна. Гэвч ийм цаг үед эрэлхэг зоригтой дуу хоолой хэрэгтэй бөгөөд эгэл жирийн баатрууд шударга бус байдал хэлмэгдүүлэлтийн эсрэг сөрөн зогсох болно. Хэн ч бүх дэлхийг аварч чадахгүй боловч хүн болгон өөрийнхөө ертөнцийг өөрчилж чадна. Бусдыг хүн биш гэж үздэг үзлийн эсрэг бүх хүн зогсож, хүн бүрийн нэр төр, эрх тэгш байдал, заяагдмал эрхийг хүлээн зөвшөөрч, дэлхий дээр эрх чөлөө, шударга ёсны үндэс суурийг тавих ёстой. 2017 онд хүний эрхийн зүтгэлтнүүд, идэвхтнүүд, тэмцэгчид хэрэгтэй байна.

# АФРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2016 онд Африк тив ихэвчлэн нийгмийн сүлжээгээр зохион байгуулагдсан нийтийг хамарсан эсэргүүцэл, хөдөлгөөнөөр дүүрэн байлаа. Жагсагчид ба хүний эрхийг хамгаалагчид дарангуйллыг сөрөн зогсох гайхалтай арга замуудыг нээсээр байгаа бөгөөд Этиоп улс дахь #oromoprotest болон #amaharaprotest, Кени улс дахь #EnforcedDisappearancesKE, Зимбабве улс дахь #ThisFlag болон Өмнөд Африк дахь #FeesMustFall зэрэг кампанит ажил өнгөрсөн жилийн өнгийг тодорхойлсон юм.

Бүхнийг хамарсан дарангуйлал хэлмэгдүүлэлт он удсан учраас Этиоп, Гамби улсад эсэргүүцэл гарна гэж ганц жилийн өмнө төсөөлөх ч аргагүй байв. Өөрчлөлт, оролцоо, эрх чөлөөг шаардах явдал ихэнх тохиолдолд жирийн иргэд, ялангуяа ажилгүйдэл, ядуурал, тэгш бус байдлын гурвалсан дөнгөнд хүлүүлсэн залуу хүмүүсийн оролцоотойгоор аяндаа гарч, түргэн хугацаанд газар авч байв. Анхлан тайван замаар явагдаж байсан зарим кампанит ажил яваандаа хүчирхийллийн элемент агуулах болсон нь гол төлөв эрх баригчдын зүгээс жагсаал цуглааныг хүч хэрэглэн нухчин дарж, ард иргэдэд үзэл бодлоо илэрхийлэх, зохион байгуулалтад орох бололцоо хомс байсантай холбоотой.

Энэхүү нугарашгүй сэтгэл, айлган сүрдүүлэх бодлогыг эсэргүүцэх хандлага итгэл найдвар төрүүлсэн. Хүмүүс жагсаал цуглаан хийхийг хориглосон

хориг, заналхийллийг эс хайхран, харгисаар нухчин дарахаас айж эмээлгүйгээр олон тоогоор гудамжинд гарч, эв нэгдлээ илэрхийлэх, хориг тавих, нийгмийн сүлжээг бүтээлчээр, өргөнөөр ашиглах зэргээр үзэл бодлоо илэрхийлж, эрхээ эдлэхийг шаардсан.

Эр зориг, нугарашгүй сэтгэлийн түүхийг эс харгалзан тайван жагсаал цуглааныг нухчин дарах явдал урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн бөгөөд олон нийтийн сэтгэл дундуур байгаагийн цаад шалтгааныг арилгах талаар бараг ямар ч алхам хийгдсэнгүй.

Өөрөөр сэтгэгчдийн харгисаар нухчин дарж байгаа бөгөөд тайван жагсаал цуглаан болон үзэл бодлоо илэрхийлэх эрхэд олонтаа халдсан явдал боллоо. Хүний эрхийг хамгаалагч, сэтгүүлч болон улс төрийн сөрөг хүчнийхэн мөрдөн мөшгилт, халдлагад өртсөөр байна. Энгийн номхон иргэд зэвсэгт мөргөлдөөний хохирлоор олон улсын эрх зүйг хөсөрдүүлсэн, хүний эрхийн байнгын зөрчлийн золиос болсоор байна. Гэмт хэргүүд ял шийтгэлгүй өнгөрч, хүний эрхийн ноцтой зөрчлийг таслан зогсоох хангалттай арга хэмжээ авахгүй байна. Хамгийн эмзэг хүмүүс буюу эмэгтэйчүүд, хүүхдүүд болон лесбиян, гей, бисексуал, трансгендер ба интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн эсрэг ялгаварлах, гадуурхах, явдлыг арилгахын тулд хийх зүйл маш их байна.

## **ТАЙВАН ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ ХҮЧЭЭР ТАРААСАН НЬ**

2016 онд жагсаал цуглааныг зоргоороо хүч хэрэглэн тараах явдал ердийн үзэгдэл болсон бөгөөд жагсаал цуглааныг хориглох, хүмүүсийг хавтгайруулан баривчлах, хорих, занчих, хороох явдал Ангол, Бенин, Бурунди, Камерун, Чад, Зааны ясан эрэг, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКоУ), Экваторын Гвиней, Этиоп, Гамби, Гвиней, Мали, Нигериа, Сьерра Леон, Өмнөд Африк, Судан, Того, Зимбабве зэрэг олон оронд гарлаа.

Тухайлбал, Оромиа мужид 2015 оны 11 дүгээр сард эхлэж бусад бүс нутаг, түүний дотор Амхара мужийг хамран тэлсэн тайван жагсаал цуглааныг тараахдаа Этиопын аюулгүй хүчнийхэн хүч хэтрүүлэн хэрэглэсэн. Жагсаал цуглааныг аюулгүйн хүчнийхэн харгислан дарсан бөгөөд байлдааны сум хэрэглэж олон зуун хүн алагдаж, олон мянган хүнийг баривчилсан байна. Засгийн газар онц байдал зарласны дараа бүх төрлийн жагсаал цуглааныг хориглосон бөгөөд жагсаал цуглааны үеэр интернет болон нийгмийн сүлжээг хааж, тэр шийдвэрээ сунгасаар байна.

Нигериа улсад арми болон аюулгүйн хүчнийхэн Биафраг дэмжигч тайван замаар жагсагчдын эсрэг хүч хэрэглэсэн кампанит ажил явуулсны улмаас жилийн турш дор хаяж 100 жагсагч алагджээ. Цэргийнхэн цугларсан хүмүүсийг тараахын тулд бараг сануулга өгөлгүйгээр байлдааны сум хэрэглэж байсан бөгөөд шүүхээс гадуур хүмүүсийг хоморголон цаазалсан болох нь тогтоогдоод байна. Тухайлбал 5 дугаар

сарын 30-нд болсон Биафрагийн дурсгалын өдрийг тэмдэглэх үйл ажиллагааны үеэр хоёр өдрийн дотор 60 хүнийг буудан хороожээ. Энэ нь 2015 оны 12 дугаар сард Зариа болон Кадуна мужид цэргийнхэн Нигериагийн Исламын хөдөлгөөний гишүүдтэй тулгарах үедээ хүч хэтрүүлэн хэрэглэж, тэнд цуглаад байсан олон зуун эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хороосон үйл явдалтай төстэй юм.

8 дугаар сард Өмнөд Африкт #FeesMustFall (Сургалтын төлбөрийг бууруул) уриатайгаар их дээд сургуулийг хамарсан оюутнуудын жагсаал цуглаан өрнөсөн бөгөөд хүчирхийллээр төгсөх нь элбэг байв. Хэдийгээр оюутнууд хүчирхийлэл үйлдсэн зарим нэг тохиолдол гарсан боловч Эмнести Интернэшнл цагдаагийн байгууллага хүч хэтрүүлэн хэрэглэсэн олон тохиолдол, түүний дотор оюутнуудын болон тэднийг дэмжигчдийн эсрэг богино зайнд резинэн сумаар буудаж байсныг баримтжуулсан. 10 дугаар сарын 20-нд Йоханнесбург хотод нэгэн оюутан манлайлагчийг ар нуруунд нь 13 удаа резинэн сумаар буудаж хороосон.

Зимбабве улсын цагдаагийн байгууллага Хараре хот дахь жагсаал цуглаан, ажил хаялтыг тараахын тулд хүч хэтрүүлэн хэрэглэсээр байна. Тус улс даяар олон зуун хүнийг тайван жагсаал цуглаанд оролцсоных нь төлөө баривчилсаны дотор #ThisFlagscampaign кампанит ажлын удирдагч Номлогч Эван Маварирег нэмэгдэн байгаа өөрөөр сэтгэх явдлыг таслан зогсоохын тулд богино хугацаанд баривчилсан бөгөөд тэрээр амь насаа аврахын тулд эх орноосоо дүрвэсэн.

Эдгээр жагсаал цуглааны дийлэнх хувьд, түүний дотор Чад, Бүгд Найрамдах Конго Улс (Конго), БНАКоУ, Этиоп, Габон, Гамби, Лесото, Уганда улсад нийгмийн сүлжээг хаах явдал өссөнөөс гадна интернетэд нэвтрэх эрхийг хязгаарлах буюу хаах явдал түгээмэл болсон.

### **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД БА СЭТГҮҮЛЧДИЙН ЭСРЭГ ХАЛДЛАГА**

Хүний эрхийн хамгаалагчид ба сэтгүүлчид хамгийн түрүүнд хүний эрхийн зөрчилд өртдөг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх улам бүр хэврэгшиж, шинэ шинэ аюул заналд өртөх болсон. Өөрөөр сэтгэх явдлыг нухчин дарж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг боомилох оролдлого бүс нутаг даяар тархсан ба тэр дундаа Ботсвана, Бурунди, Камерун, Чад, Зааны ясан эрэг, Гамби, Кени, Мавритани, Нигериа, Сомали, Өмнөд Судан, Судан, Танзани, Того, Замби зэрэг улсад тод илэрч байна.

Зарим хүмүүс амь насаараа хохирч байна. Кени улсын цагдаагийн байгууллага олонд нэртэй хүний эрхийн хуульч, түүний үйлчлүүлэгч болон тэдний сууж явсан таксины жолооч нарыг хүчээр сураггүй болгож, шүүхээс гадуур цаазалсан. Тэд 1 дүгээр сараас хойш аюулгүй байдлын агентлагуудын гарт шүүхээс гадуур цаазлагдсан 177 хүмүүсийн нэг юм. Судан улсад 18 настай оюутан Абукабар Хассан Мохамад Таха болон 20 настай оюутан Мохамад Аль Садик Ёёо нарыг тагнуулын агентууд хороосон нь өөрөөр сэтгэдэг оюутнуудыг эрчимтэй нухчин дарах болсны харамсалтай уршиг байв. Сомали улсад үл таних этгээдүүд хоёр

сэтгүүлчийг хөнөөсөн бөгөөд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг дарамтлах, айлган сүрдүүлэх, халдах явдал өссөөр байна.

Олон хүнийг хийж буй ажлынх нь төлөө дур зоргоор баривчилж, мөрдөн мөшгиж, цагдан хорьж байна. Ангол улсад гарсан зарим нэг эерэг алхам, түүний дотор хүний эрхийг хамгаалагчид болон үзэл санааны хоригдлуудыг сулласан боловч улс төрийн зорилготой шүүх хурал, нэр төр гутаасан хэргээр ял оноох явдал үргэлжилсээр байгаа бөгөөд үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хүний эрхийг хамгаалагчдыг номхотгох, бусад шүүмжлэлт дуу хоолойг хаахын тулд ашигласаар байна. БНАКоУ-д залуучуудын хөдөлгөөнийг босогчдын бүлэглэл гэсэн ангилалд оруулах болсон. Түүнчлэн Эритрей улсад дур зоргоор баривчилж, хүчээр алга болгосон улс төрчид ба сэтгүүлчдийн хаана байгаа нь 2001 оноос хойш тодорхойгүй байгаа бөгөөд тус улсын засгийн газар тэднийг амьд байгаа гэж мэдэгдсэн.

Мавритани улсын Дээд шүүх боолчлолын эсрэг тэмцдэг 12 идэвхтнийг суллах шийдвэр гаргасан боловч 3 нь хоригдсон хэвээр байгаа бөгөөд эрх баригчдын зүгээс боолчлолын эсрэг тэмцдэг байгууллага болон идэвхтнүүдийг мөрдөж мөшгисөн хэвээр байна.

Олон оронд, түүний дотор Чад, Гамби, Кени, Сомали, Өмнөд Судан зэрэг улсад хүний эрхийн хамгаалагчид ба сэтгүүлчид шоронд хоригдохоос гадна бие махбодын халдлага, айлган сүрдүүлэлт, дайралтад өртсөөр байна.

4 дүгээр сарын 18-нд Зимбабве

улсын Тусгаар тогтнолын өдрөөр сураггүй алга болсон сэтгүүлч бөгөөд ардчиллын төлөөх идэвхтэн Итай Замарагийн дүү рүү Хараре хотод ерөнхийлөгч Роберт Мугабегийн оролцсон нэгэн арга хэмжээн дээр эсэргүүцлийн пайз өргөсөн хэмээн аюулгүй байдлын ажилтнууд хүч хэрэглэн халдсан. Уганда улсад ТББ-дын оффис болон хүний эрхийн хамгаалагчдын эсрэг хэд хэдэн халдлага гарсан. Эдгээр гэмт хэрэгтэнд зохих хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа нь эрх баригчид тэднийг дэмжих буюу хүлцээр байна гэж ойлгогдохоор байна. Нэгэн халдлагын үеэр гэмт этгээд харуулыг үхтэл нь зодсон.

Олон оронд хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид болон нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн өмнө илүү их сорилт тулгарсаар байна. Замби улсын эрх баригчид сонгуулиас өмнө шүүмжлэлт хэвлэл мэдээллийг боомилох зорилгоор хараат бус *The Post* сонинг хаасан бөгөөд ахлах ажилтнуудыг гэр бүлийнх нь хамт баривчилсан.

Бурунди улсад аль хэдийнэ сулраад байгаа иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын эсрэг дайралт нэмэгдсэн бөгөөд сэтгүүлчид, нийгмийн сүлжээний бүлгийн гишүүд болон тэр байтугай сургуулийн хүүхдүүд зөвхөн үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө баривчлагдсаар байна. Камерун улсад Боко Харамын тухай текст мэссэж явуулсных нь төлөө Фомузо Иво Фехд 10 жил хорих ял оноожээ.

Зарим улс оронд шинээр батлагдаж байгаа хууль тогтоомж сэтгэл түгшээж байна. Тухайлбал, Мавритани улсын парламент тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх,

тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах хуулийн төслийг хэлэлцэж байгаа юм.

Конго улсад иргэний нийгмийн байгууллагуудыг хянах засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлсэн хууль батлагдсан. Ангол улсын Үндэсний Ассемблей үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ихээхэн хумих 5 хуулийн төслийг баталсан. Түүнчлэн терроризмын эсрэг болон онц байдлын тухай хууль тогтоомжийг тайван замаар өөр үзэл бодол илэрхийлэгчдийг гэмт хэрэгт буруутгах зорилгоор ашиглаж байна. Этиопын засгийн газар сөрөг хүчний дуу хоолойг үл хүлцэх болсон бөгөөд Терроризмын эсрэг тунхаглалыг хэрэглэн сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчид болон бусад өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах явдлаа эрчимжүүлсэн.

Эерэг зүйл гэвэл засгийн газрын зүгээс өөрөөр сэтгэгчдийг дарах зорилгоор хууль тогтоомжийг хэрэглэж байгааг эсэргүүцэх явдал хамгийн их дарангуйлалтай оронд ч гарах болсон нь итгэл найдвар төрүүлж байна. БНАКОУ-д үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ихээхэн ухралт гарсан 2016 онд ардчиллыг дэмжигч 4 идэвхтнийг сулласан нь ховор тохиолдох эерэг алхам юм. 9 дүгээр сард Свазиланд улсад харгис хуулийг хэрэглэхийн эсрэг шүүхээс түүхэн шийдвэр гарсан нь хүний эрхийн бас нэгэн ялалт юм. Зимбабве улсын Дээд шүүх жагсаал цуглааныг хориглосон хоригийг хүчингүй болгосон. Хэдийгээр Дээд шүүхийн өөр нэг шийдвэр уг шийдвэрийг хүчингүй болгосон ч ерөнхийлөгч Мугабегийн заналхийллийг эс хайхран гаргасан тэрхүү зоригтой шийдвэр хүний эрхийг хамгаалах үйл хэргийн ялалт болсон бөгөөд

жагсаал цуглаан хийх эрхийг зүгээр л нэг хориглочихож болохгүй гэдгийг тодорхой харуулсан. Гамби улсад хоригдож байсан 40 гаруй үзэл санааны хоригдлыг сонгуулийн дараа нэн даруй батлан даалтаар сулласан бөгөөд тэдний зарим нь 8 сар хүртэл хугацаагаар хоригдоод байсан юм.

### **УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ**

2016 онд Африк тив даяар хэд хэдэн сонгууль маргаантай болж, энэ үеэр хэлмэгдүүлэлт өссөн онцлогтой байв. Бурунди, Чад, Конго, Зааны Ясан Эрэг, БНАКоУ, Габон, Гамби, Сомали, Уганда зэрэг хэд хэдэн улсад сөрөг хүчний удирдагчид, сөрөг хүчний дуу хоолой ихээхэн дайралтад өртсөн.

Огт хүлээж байгаагүй нэг өөрчлөлт нь олон мянган Гамбичууд ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө тайван жагсаал хийж, мөн жилийн эцэст сонгуулийн үр дүн маргаантай үлдсэн.

Сонгууль болохоос өмнөх хэдэн сард иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх ноцтой зөрчигдсөн тохиолдол олон гарсан. Сөрөг хүчний олон арван гишүүн баривчилагдснаас гадна тайван жагсаалд оролцсоных нь төлөө саатуулагдсан үедээ 2 хүн нас барсан байна. Түүнчлэн тайван жагсаал цуглаанд оролцсоных нь төлөө 30 хүнд 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оноосон бөгөөд 14 хүн шүүх хурлаа хүлээж байв. Тэднийг 12 дугаар сарын 1-нд болсон сонгуулийн дараа нэн даруй батлан даалтаар сулласан.

Ерөнхийлөгч Яхя Жаммех эхэндээ сөрөг хүчний удирдагч Адама Барроуд ялагдсанаа хүлээн зөвшөөрсөн байснаа дараа нь сонгуулийн үр дүнг хүчингүй

болгож, эрх мэдлээ хүлээлгэн өгөхийг шаардсан дотоодын болон олон улсын шаардлагыг үл тоомсорлосон байна.

Уганда улсын Засгийн газар 2 дугаар сард болж өнгөрсөн сонгуулийн үр дүнгийн талаар сөрөг хүчний зүгээс шүүхэд зарга мэдүүлэх боломжийг нь хязгаарласан. Аюулгүйн хүчнийхэн ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Др. Кизза Бесигие болон түүний намын нөхөд, дэмжигчдийг дахин дахин баривчилж, орон гэрийг нь бүсэлснээс гадна Кампала дахь намын байрыг нь нэгжсэн.

БНАКоУ-д 12 дугаар сард дуусгавар болсон үндсэн хуулиар олгогдсон хоёр дахь бүрэн эрхийн хугацаа өнгөрсөн ч эрх мэдлээ хадгалан үлдэх зорилгоор ерөнхийлөгч Жозеф Кабилаг эсэргүүцэгч сөрөг хүчнийхэн болон сонгуулийг хойшлуулж байгааг эсэргүүцэгчдийг системтэйгээр нухчин дарсан. Аюулгүй байдлын ажилтнууд үндсэн хуулийн маргаанд хүчтэй байр суурь илэрхийлж байгаа болон хүний эрхийн зөрчлийг буруушааж байгаа хүмүүсийг баривчлах буюу дарамталж, эх орноосоо урвасан хэмээн буруутгасан.

Сомали улсын хүмүүнлэгийн ужгирсан хямрал парламент ерөнхийлөгчийн сонгуулийн коллегийг бүрдүүлэх маргаан улс төрийн хямрал болон дэвэрч, улмаар Аль-Шабааб гэх зэвсэглэсэн бүлэг сонгуулийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэж, санал хураах байрууд руу довтолж, овгийн ахлагч, засгийн газрын албан тушаалтан сонгуульд оролцож байгаа парламентын гишүүдийг ал гэж дэмжигчиддээ уриалсан.

Конго улсын эрх баригчид тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэснийх нь төлөө "Unis pour le Конго" (UPC) хөдөлгөөний ерөнхийлөгч Полин Макаяг цагдан хорьсоор байна. Сөрөг хүчин 3 дугаар сард болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэний дараа эрх баригчид сөрөг хүчний томоохон удирдагчдыг баривчилж, тайван замаар жагсаал цуглаан хийх эрхэд нь халдсан.

Зааны ясан эрэг улсын эрх баригчид 10 дугаар сард болсон үндсэн хуулийн өөрчлөлтийн талаарх санал асуулгын өмнө сөрөг хүчний гишүүдийг онилж, тэдний үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг шударга бусаар хязгаарласан. Чингэхдээ тайван замаар жагсаал цуглаан хийж байсан олон арван сөрөг хүчний гишүүдийг дур зоргоор баривчилж, цагдан хорьсон юм. Заримыг нь эдийн засгийн нийслэл Абиджаны орчимд, заримыг нь гэр орноос нь зуу гаруй км хол газар тарааж хаясан бөгөөд тэднийг буцаад явган алхахаас өөр аргагүй болгожээ. 10 дугаар сард санал асуулгын эсрэг жагсагчид цугларч эхлэх үед цагдаа нулимс асгаруулагч хий ашиглаж удирдагчдыг болон дор хаяж 50 хүнийг баривчилжээ.

### **ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН**

Африк тивд өрнөж буй зэвсэгт мөргөлдөөн, тэр дундаа Камерун, Төв Африкийн БНУ (ТАБНУ), Чад, БНАКоУ, Мали, Нигер, Нигериа, Сомали, Өмнөд Судан, Судан улсад энгийн номхон иргэд хүний эрхийн ноцтой зөрчилд өртсөөр байна. Хүйст суурилсан болон бэлгийн

хүчирхийлэл түгээмэл тархсан бөгөөд хүүхдүүдийг байлдагч-хүүхэд болгон ашиглаж байна.

Баруун, төв, зүүн Африкт Аль-Шабааб, Боко Харам зэрэг зэвсэгт бүлэглэлүүд харгис хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил үйлдсээр байгаа бөгөөд олон зуун энгийн номхон иргэд алагдаж, хулгайлагдаж, сая сая хүмүүс улс орондоо болон улс орноосоо гадна айдас хүйдэс, аюул заналаар дүүрэн нөхцөлд амьдрахаас аргагүйд хүрээд байна. Камерунд 170 000 гаруй хүн, түүний дотор дийлэнх нь хүүхэд эмэгтэйчүүд Боко Харамын харгислалын улмаас алслагдсан хойд зүгийн мужууд руу дотооддоо шилжин суурьшжээ. Нигер улсад ихэнх хадлагыг Боко Харамд үйлддэг Диффа мужид зарласан онц байдлын үеэр 300 000 хүнд хүмүүнлэгийн тусламж хэрэгтэй байна. Олон засгийн газар эдгээр аюул заналын эсрэг арга хэмжээ авахдаа олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийг хүндэтгэн сахихгүй байгаа бөгөөд хүмүүсийг дур зоргоор баривчилж, нэр усгүйгээр цагдан хорьж, эрүү шүүлт тулгаж, шүүхээс гадуур цаазалж байна.

Нигериа улсад 240 гаруй хүн түүний дотор 6 хүртэлх насны 29 хүүхэд Майдигури дахь Гива хэмээх муу нэрээрээ алдартай хорих газарт хүний ёсноос гадуур хэцүү нөхцөлд амиа алдав. Зүүн хойд бүс нутагт нийтийг хамарсан баривчилгаа явуулж, олон мянган хүнийг баривчилсан бөгөөд тэднийг ихэнх тохиолдолд ямар ч нотолгоогүйгээр даац нь хэтэрсэн, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд шүүх хурал хийлгүйгээр, гадаад ертөнцтэй харьцах эрхгүйгээр хорьж байна.

Түүнчлэн Камерун улсад 1000 гаруй хүнийг дур зоргоор баривчилж, ой гутмаар нөхцөлд хорьсон бөгөөд олон арван хүн эрүү шүүлт, өвчин, өлсгөлөнгөөс болж амиа алдлаа. Боко Харамыг дэмжсэн гэж сэжиглэгдсэн хүмүүсийг цэргийн шүүхээр оруулан шударга бусаар шүүж, дийлэнх хувьд нь цаазаар авах ял оноож байна.

Аюулгүй байдал ба хүмүүнлэгийн нөхцөл байдал Суданы Дарфур, Хөх Нил, Өмнөд Кордофан муж улсад ихээхэн хүнд байна. Дарфурын Жабел Марра мужид засгийн газрын зэвсэгт хүчин химийн зэвсэг хэрэглэснээс харахад тэд олон улсын эрх зүйг зөрчсөн хэрэгтээ хариуцлага хүлээнэ гэж эмээлгүйгээр энгийн номхон хүн амын эсрэг халдлага үргэлжлүүлэн үйлдэх нь тодорхой байна.

Өмнөд Суданы засгийн газар босогчидтой энхийн гэрээ байгуулсан боловч тус улсын олон газарт тулалдаан үргэлжилж, 7 дугаар сард нийслэл Жубад эхэлсэн ширүүн байлдаан Өмнөд Экватор мужийг хүртэл хамарсан. Тулалдааны үеэр зэвсэгт хүчин, ялангуяа засгийн газрын цэргүүд хүний эрхийг зөрчсөн бөгөөд онилсон аллага, халдлага үйлдэж байсны дотор хүмүүнлэгийн ажилтнуудыг онилж байв. Өмнөд Судан дахь НҮБ-ын хүчин (UNMISS) байлдааны үеэр энгийн ард иргэдийг хамгаалж чадаагүй гэсэн шүүмжлэлд өртсөн. Бүс нутгийн хамгаалалтын хүчин байгуулах тухай НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол хэрэгжээгүй. НҮБ-ын Геноцидээс сэргийлэх Тусгай зөвлөх болон НҮБ-ын Өмнөд Судан дахь Хүний эрхийн Комисс геноцид явагдах суурь тавигдлаа хэмээн

түгшүүрийн харанга дэлдсэн.

ТАБНУ-д 2015 оны 12 дугаар сар, 2016 оны 2 дугаар сард тайван замаар сонгууль явагдсан хэдий ч оны төгсгөлөөр аюулгүй байдлын нөхцөл байдал доройтож, тус улс зэвсэгт хүчирхийлэл рүү хальтран орох аюул тулгараад байна. Зэвсэгт бүлэглэлүүд олон тооны халдлага үйлдсэний дотор 10 дугаар сарын 12-нд Каго Бандоро хотод Селека бүлэглэлд хамаардаг байсан 2 фракцийн дайчид дор хаяж 37 энгийн номхон иргэдийг алж, 60 хүнийг шархдуулж, дотооддоо дүрвэгсдийн хуаранг галдан шатаажээ.

Ийнхүү хүмүүсийн цус урсаж, зовлон шаналалд автсаар байгаа боловч дэлхий нийт Африк тивийн хямрал мөргөлдөөн рүү анхаарал хандуулахаа больсон. Олон улсын хамтын нийгэмлэгийн авч буй арга хэмжээ маш хангалтгүй байгааг НҮБ-ын Аюулгүй зөвлөл Өмнөд Суданы эсрэг хориг арга хэмжээ авч чадаагүй, ТАБНУ, Өмнөд Судан, Судан улсад энгийн номхон иргэдийг хамгаалах энхийг сахиулах ажиллагааны чадавх хангалтгүй байгаагаас харж болно. НҮБ-ын Аюулгүйн зөвлөл болон Африкийн холбооны Энх тайван, Аюулгүй байдлын зөвлөл Суданы засгийн газарт хүмүүнлэгийн тусламжийг саадгүй нэвтрүүлэх, хүний эрхийн ноцтой зөрчлийг мөрдөн шалгах талаар шахалт үзүүлэх талаар бараг ямар ч арга хэмжээ аваагүй.

Африкийн холбооноос хямрал мөргөдөөний үед үйлдсэн олон улсын эрх зүйн гэмт хэргүүд болон хүний эрхийн ноцтой зөрчлийн талаар авч байгаа арга хэмжээ дийлэнхдээ удаан, зөрчилдөөнтэй байгаа бөгөөд цогц стратегийн



хүрээнд бус хэрэг тохиолдол бүрийн эсрэг сөрөг арга хэмжээ авч байна.

### **ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС**

Африк тивд өрнөж байгаа хямрал мөргөлдөөн, түүний дотор Камерун, ТАБНУ, Чад, Мали, Нигер, Нигериа, Сомали, Өмнөд Судан, Судан улс дахь хямрал мөргөлдөөн дэлхий нийтийн дүрвэгсдийн хямрал болон улс орны дотоод дахь дүрвэгсдийн тоог нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. Сая сая хүмүүс орон гэртээ эргэн очиж чадахгүй байсаар байгаа бөгөөд шинэ аюул заналын улмаас үл мэдэх аюул, тодорхой бус ирээдүй рүү дүрвэхээс аргагүйд хүрээд байна.

Африкийн Сахарын бүс нутгаас гаралтай хүмүүс дайн, мөрдлөгө хавчлага, туйлын ядуурлаас зугтан Ливи улс руу дүрвэж байгаа зуу зуун мянган дүрвэгсдийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тэд ихэнхдээ тус улсаар дамжин Европ руу шилжин суурьших найдвар тээж ирдэг. Эмнести Интернэшнлийн хийсэн судалгаагаар Ливи улс руу чиглэсэн болон тус улсын нутаг дэвсгэрээр өнгөрч байгаа дүрвэгсдийн замд хүний эрхийн ноцтой зөрчил, түүний дотор бэлгийн хүчирхийлэл аллага, эрүү шүүлт, шашны хавчлага тохиолдсоор байгааг илрүүлсэн.

Нигериагийн хойд нутаг дор хаяж 2 сая хүн дотооддоо дүрвэж, өөр тосгон сууринд, зарим нь ачааллаа даахаа больсон, хүнс, усаар хомс, эрүүл ахуйн шаардлага хангахгүй хуарангуудад амьдарч байна. Олон арван мянган дотооддоо дүрвэгсэд арми болон иргэний хамтарсан зэвсэгт харуулын хараа хяналтын дор

хуарангуудад амьдарч байгаа бөгөөд тэдгээр зэвсэгт харуулууд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт оруулсан тохиолдол гарсан.

Эдгээр хуарангуудад хагас өлсгөлөн байдлаас болж олон мянган хүн нас барсан.

ТАБНУ, Ливи, Нигериа, Судан улсын олон зуун мянган дүрвэгсэд Чад улс дахь хүнд нөхцөлтэй дүрвэгсдийн хуаранд амьдарсаар байна. НҮБ-ын мэдээлснээр 300 000 гаруй хүн Бурунди улсаас дүрвэсний олонх нь хөрш Руанда болон Танзани улсын дүрвэгсдийн хуарангуудад байгаа юм. 1,1 сая Сомаличууд дотооддоо дүрвээд байгаагаас гадна 1,1 сая Сомали дүрвэгсэд хөрш орнууд болон бусад улсад байна.

Өмнөд Суданд хямрал мөргөлдөөн эхэлснээс хойш 3 жилийн дотор хөрш орнууд дахь дүрвэгсдийн тоо 1 саяд хүрсэн бөгөөд нийтдээ 1,7 сая хүн дотооддоо дүрвэж, 4,8 сая хүн хоол тэжээлийн дутагдалд нэрвэгдээд байна.

Кени улсын засгийн газар 280 000 дүрвэгсэд амьдардаг Дадааб хуаранг хаахаар төлөвлөж байгаага мэдэгдсэн. Тэдний 260 000 орчим нь Сомали улсаас ирсэн буюу тус улсаас гаралтай хүмүүс бөгөөд Кени улсын дүрвэгсдийн бодлогод гарсан бусад өөрчлөлтийн улмаас тэднийг олон улсын эрх зүйг зөрчин хүчээр нутаг руу нь буцаах эрсдэл тулгараад байна.

### **ГЭМТ ЭТГЭЭДҮҮД ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭЖ, ШУДАРГА ЁС АЛДАГДСААР БАЙНА**

Африк тивд өрнөж байгаа хямрал мөргөлдөөнүүдийн онцлог бол гэмт этгээдүүд ял шийтгэлгүй үлдэх

явдал бөгөөд олон улсын эрх зүйн гэмт хэрэг үйлдсэн, хүний эрхийг ноцтой зөрчсөн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх явдал өдрийн од шиг байна.

Африкийн холбоо өөрт нь байгаа бүрэн эрхийг үл хайхран Өмнөд Суданы асуудлаарх тус улсын энх тайвны гэрээнд заасан холимог шүүхийг байгуулах тодорхой алхам хийхгүй байна. Тийм шүүх нь хямрал мөргөлдөөний үед үйлдэгдсэн дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хариуцлага тооцох, цаашид хүний эрхийн зөрчил гарахаас сэргийлэх хамгийн тохиромжтой хувилбар юм.

ТАБНУ-д Эрүүгийн тусгай шүүх байгуулах талаар зарим нэг ахиц гарсан боловч онц хүнд гэмт хэрэг болон хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн хэмээн сэжиглэгдэж байгаа хүмүүсийн олонх нь сул чөлөөтэй явсаар байгаа бөгөөд тэднийг баривчлах, мөрдөн байцаах ажил хийгдэхгүй байна. Түүнчлэн НҮБ-ын ТАБНУ дахь энхийг сахиулах ажиллагаа ихээхэн сул байгаагийн зэрэгцээ гэмт этгээдүүд ял шийтгэлгүй өнгөрсөөр байгаа нь хямрал мөргөлдөөнийг улам гааруулж, энгийн номхон иргэд хүчирхийлэл, тогтворгүй байдлын золиос болох гол шалтгааны нэг болж байна.

Нигериа улсад олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн гэрээ конвенцийг системтэйгээр зөрчиж байгааг нотлох олон баримт байгаа бөгөөд 7000 орчим залуус армийн хориход байхдаа амь насаа алдсанаас гадна 1200 хүнийг шүүхээс гадуур цаазалжээ. Гэвч тус улсын засгийн газар гэмт хэргийг мөрдөн шалгах талаар ямар ч алхам хийгээгүй. Гэм

буруутай нэг ч хүнийг шүүхээр шийтгээгүй бөгөөд зөрчил үргэлжилсээр байна.

Олон улсын Эрүүгийн шүүх (ОУЭШ) Кени улсын Дэд ерөнхийлөгч Вильям Руто болон радио нэвтрүүлэгч Жошуа Арап Сан нарын эсрэг үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож буйгаа зарласнаар 2007-2008 оны сонгуулийн дараа Кени улсад гарсан хүчирхийлэлтэй холбоотой бүх хэрэг хаагдлаа. Уг шийдвэр нь шударга ёсыг хүлээж буй мянга мянган хохирогчдын хувьд томоохон ухралт болов.

Африкийн Бурунди, Гамби, Өмнөд Африк зэрэг улс Ромын дүрмээс гарах хүсэлтэй байгаагаа мэдэгдсэн нь дэлхий даяар олон улсын гэмт хэргийн золиос болсон сая сая хохирогчдоос урвасан хэрэг билээ.

Түүнчлэн Африкийн холбоо ОУЭШ-ээс геноцидийн хэргээр эрэн сурвалжилж буй Суданы ерөнхийлөгч Омар аль-Баширийг баривчлах олон улсын үүргээ биелүүлэхгүй байхыг гишүүн орнууддаа уриалсаар байна. 5 дугаар сард Уганда улс тус улсад айлчилсан ерөнхийлөгч Омар аль-Баширийг баривчилж, ОУЭШ-д хүлээлгэн өгч чадаагүй нь Дарфурын хямралын улмаас амь насаа алдсан буюу дүрвэхээс аргагүйд хүрсэн олон зуун мянган хүний итгэлийг хөсөрдүүлсэн.

Гэвч олон улсын шударга ёс, хариуцлагыг дээшлүүлэх талаар зарим нэг нааштай алхам хийгдлээ. ОУЭШ-ийн гишүүн Африкийн орнууд 11 дүгээр сард болсон Ромын дүрмийн Гишүүн улсуудын Ассемблейн 15-р чуулганы үеэр уг дүрмийн тогтолцоог дэмжиж байгаа болон гишүүнээр нь хэвээр

үлдэх эрмэлзэлтэй байгаагаа нотолсон. Энэхүү байр суурийг өмнө нь 7 дугаар сард Кигали хотноо болсон Африкийн холбооны Дээд хэмжээний уулзалтын үеэр Ботсвана, Зааны ясан эрэг, Нигериа, Сенегал, Тунис гэх мэт олон улс баримталж, Ромын дүрмээс бөөнөөрөө гарах явдлыг эсэргүүцэж байсан юм. 12 дугаар сард Гамби улсын ерөнхийлөгч засгийн газрынхаа гаргасан Ромын дүрмээс гарах шийдвэрийг цуцлах болно хэмээн мэдэгдсэн.

Нааштай алхмуудын дотор 5 дугаар сард Чад улсын ерөнхийлөгч асан Хиссен Хабрег 1982-1990 онд үйлдэгдсэн хүн төрөлхтний эсрэг болон дайны гэмт хэрэг, эрүүдэн шүүх гэмт хэрэгт буруутай хэмээн үзэж шийтгэсэн явдал юм. Дакар хот дахь Африкийн Онцгой Шүүх танхимаас түүнд бүх насаар нь хорих ял оноож, Африк тивд гэмт этгээдүүд ял шийтгэлгүй үлдэх явдлыг таслан зогсоох үйл хэрэгт шинэ жишиг тогтоосон. Энэ нь Африк тивийн анхны нийтлэг шүүхийн хэрэг байсан төдийгүй Хабре олон улсын эрх зүйн гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө өөр улсын шүүхээр хэргээ шийдүүлсэн Африкийн анхны хуучин удирдагч юм.

3 дугаар сард ОУЭШ БНАКоУ-ын дэд ерөнхийлөгч асан Жан-Пьер Бембаг ТАБНУ-д дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял оноосон. ОУЭШ түүнд 19 жилийн хорих ял оноосон нь хүчингийн гэмт хэргийг дайны гэмт хэрэг хэмээн үзсэн анхны тохиолдол төдийгүй цэргийн тушаалтны хариуцлагад үндэслэн ял оноосон анхны тохиолдол байв. Түүнийг шүүхээс гэм буруутай гэж үзсэн нь ТАБНУ болон

дэлхийн бусад улс дахь бэлгийн хүчирхийллийн хохирогсдод шударга ёсыг тогтоох тэмцэлд чухал мөч болсон. Түүнчлэн ОУЭШ Зааны ясан эрэг улсын ерөнхийлөгч асан Лорен Гбагбо болон түүний Залуучуудын асуудал эрхэлсэн сайд асан Шарль Бле Гүде нарыг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүх хурал эхлүүлсэн. ОУЭШ Ансар Эддине зэвсэгт бүлэглэлийн ахмад гишүүн Ахмад Аль-Факи Аль-Махдиг 2012 онд Мали улсын Тимбукту хотод исламын сүм, мавзолейд халдлага үйлдэж, олон улсын эрх зүйн гэмт хэрэг үйлдсэн хэрэгт ял оноосон.

Өмнөд Африкийн Дээд шүүх засгийн газраа 2015 онд тус улсад айлчлал хийж байхад нь Аль-Баширыг баривчилж, дотоодын болон олон улсын үүрэг хариуцлагаа биелүүлээгүй хэмээн буруушаасан. Энэ нь олон улсын гэмт хэрэг үйлдэгчдийг ямар албан тушаал хашиж байгаагаас үл хамааран дархан эрхийг нь хэрэгсэхгүй байх олон улсын хэм хэмжээг нотолсон юм.

## **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА АД ШОО ҮЗЭХ**

Соёлын уламжлал, хэм хэмжээнээс шалтгаалан охид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, ад шоо үзэх, дээрэлхэх явдал түгээмэл оршсоор байгаа бөгөөд ялгаварлан гадуурхалтыг шударга бус хуулиар баталгаажуулсан байдаг. Охид эмэгтэйчүүд хямрал мөргөлдөөнтэй болон олон тооны шилжин суурьшигсад, дүрвэгсэдтэй улс орнуудад бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байна. Мадагаскар, Намиби, Сьерра Леон зэрэг хэд хэдэн улсад охид эмэгтэйчүүдийн эсрэг хүйст суурилсан

хүчирхийллийн түвшин өндөр байна.

Сьерра Леон улсын засгийн газар жирэмсэн охидыг сургуульд явах буюу шалгалт өгөхийг хориглосоор байна. Түүнчлэн тус улсын ерөнхийлөгч парламентаас хоёр удаа баталснаас гадна Сьерра Леонд эхчүүдийн эндэгдэл өндөр байгааг эс харгалзан үр хөндөлтийг хуульчлах хуулинд гарын үсэг зурж ёсчлохоос татгалзсаар байна. Мөн тус улс НҮБ-аас өгсөн эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг зэрэмдэглэхийг хориглох зөвлөмжийг хүлээн авахаас татгалзсан юм.

Буркина Фасо улсад эрт гэрлэлт болон хүчээр гэрлүүлэх явдлаас үүдсэн 13 болон түүнээс дээш насны мянга мянган охид хүүхэд наснаасаа хагацаж байгаа бөгөөд жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн өндөр үнэ болон бусад шалтгааны улмаас хүүхэдтэй болох эсэх, хэзээ хүүхэдтэй болохоо өөрсдөө шийдэж чадахгүй байна. Гэвч иргэний нийгмийн эрчимтэй кампанит ажлын үр дүнд засгийн газар хуулиар гэрлэх насны хязгаарыг 18 болгож өөрчилнө хэмээн мэдэгдсэн.

ЛГБТИ хүмүүс болон ЛГБТИ гэж ойлгогддог хүмүүс Ботсвана, Камерун, Кени, Нигериа, Сенегал, Танзани, Того, Уганда дээрэлхэлт болон ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Кени улсад хоёр эр Момбаса дахь дээд шүүхэд тэднийг 2015 онд хүчээр шулуун гэдэсний үзлэг, ХДОХВ болон гепатит В-гийн оношилгоонд хүчээр оруулсан нь үндсэн хууль зөрчсөн хэмээн зарга мэдүүлсэн. Гэвч шүүхээс эрчүүд эрчүүдтэйгээ бэлгийн харьцаанд орсон хэмээн сэжиглэж байгаа тохиолдолд шулуун гэдэсний үзлэг хийх нь хууль ёсны зүйл гэсэн

шийдвэр гаргасан. Хүчээр шулуун гэдэсний үзлэг хийх нь хувь хүний эрхэд халдсан зүйл бөгөөд олон улсын эрх зүйгээр эрүү шүүл тулгах болон бусад хэлбэрээр хүнлэг бус харьцах явдлыг хориглосныг зөрчиж байгаа хэрэг юм.

Малави улсад альбинизмтай хүмүүсийн эсрэг хүч хэрэглэсэн халдлага урьд хожид байгаагүй ихээр гарах болсон нь цагдаагийн байгууллагын алдааны үр дагавар юм. Хувь хүмүүс болон гэмт хэргийн бүлэглэлүүд ид шидийн хүчтэй хэмээн итгэдэг биеийн хэсгийг нь олж авахын тулд тэднийг хулгайлж, алж, дээрэмдсээр байна. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд аллагад өртөх нь их бөгөөд зарим тохиолдолд хамаатан садныхаа гарт үрэгдсээр байна.

Судан улсад шашны эрх чөлөөг хуулийн тогтолцоогоороо боомилдог бөгөөд исламын шашнаас өөр шашин шүтлэгт орсон бол цаазаар авдаг.

Компаниудад хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил гарах нэг шалтгаан болж байна. БНАКоУ-д бичил уурхайчид, түүний дотор мянга мянган хүүхдүүд хортой нөхцөлд кобальтын уурхайд ажиллаж байна. Кобальт нь эрчим хүчний хэрэгсэл, түүний дотор гар утас, зөөврийн компьютерт хэрэглэгддэг бөгөөд Apple, Samsung Sony зэрэг электроникийн томоохон компаниуд тэдний бүтээгдэхүүнд хэрэглэгдэж буй кобальтыг олборлоход хүүхдийн хөдөлмөр ашиглагдаж байгаа эсэхийг тогтоох наад захын шалгалт хийхгүй байна.

## **ЦААШДЫН ХАНДЛАГА**

Африкийн холбоо 2016 оныг Хүний

эрхийн жил болгон зарласан хэдий ч олон гишүүн орон хүний эрхийн талаарх үг яриагаа үйл хэрэг болгож чадсангүй. 2016 онд тохиосон цорын ганц тэмдэглүүштэй зүйл нь хүмүүсийн нугарашгүй сэтгэл, эр зориг байсан бөгөөд тэд дарангуйлал, айлган сүрдүүлэх бодлого тэднийг дахин дуугүй байлгаж чадахгүй гэдгийг тодорхой илэрхийлсэн.

Хүмүүст үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зайг нээж өгөх улс төрийн хүсэл эрмэлзэл, эр зориг байсан бол Бурунди, Этиоп, Гамби, Зимбабве зэрэг улсад даамжирсаар буй хямрал мөргөлдөөнөөс урьдчилсан сэргийлж, тогтоон барих боломжтой байлаа.

Зарим салбарт ахиц гарсныг эс тооцвол Африкийн холбоо хүний эрхийн зөрчлийг хямрал мөргөлдөөний үндсэн шалтгаан эсхүл хямрал мөргөлдөөнөөс үүдсэн зүйл хэмээн үзэж хариу арга хэмжээ авах явдал удаан, туйлбаргүй бөгөөд шийдмэг бус байв. Үнэн хэрэгтээ Африкийн холбоо анхаарал хандууллаа ч гэсэн тухайн зөрчлийн эсрэг арга хэмжээ авах чин хүсэл, улс төрийн зориг ерөнхийдөө дутмаг байв. Түүнчлэн Африкийн холбоо Энх тайван, ба Аюулгүй байдлын зөвлөл, Тивийн эрт сэрэмжлүүлэх систем зэрэг энх тайван ба аюулгүй байдлын байгууллагууд болон хүний эрхийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаагүй байгаа нь хямрал мөргөлдөөнөөс үүдэн гарч буй хүний эрхийн зөрчлийн эсрэг цогц арга хэмжээ авах боломжийг хязгаарлаж байна.

Африкийн холбоонд 2020 он гэхэд “буун дууг зогсоох” зорилтоо хэрэгжүүлэхэд 4 хүрэхгүй жил үлдээд байна. Хямрал

мөргөлдөөний үндсэн шалтгаан, түүний дотор хүний эрхийн ужгирсан зөрчлийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах замаар энэхүү үүрэг амлалтаа ажил хэрэг болгох цаг ирээд байна.

Гэмт этгээдүүд ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх илүү үр дүнтэй арга хэмжээ авах, ингэхдээ ОУЭШ рүү улс төрийн зорилгоор дайрч давшлахаа зогсоох, Өмнөд Судан болон бусад улсад гарсан онц хүнд гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчлийн хохирогчдод шударга ёсыг тогтоох, гэм буруутнуудад хариуцлага тооцох хэрэгтэй байна.

Африкийн холбоо Африк тив дэх Хүний эрхийг хангах хөтөлбөр боловсруулах ажлаа эхэлсэн нь тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх бас нэг боломж юм. Уг хөтөлбөрийн эхлэх цэг нь Африкчууд дарангуйлал, шоовдорлолыг эс хайхран босч, эрхээ шаарддаг болсныг хүлээн зөвшөөрөх явдал юм.

# АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ардчилал, эдийн засагт гарч буй дэвшилийн талаар хэлэлцүүлэг өрнөж, Колумбад шийдвэрлэгдээгүй үлдсэн зэвсэгт мөргөлдөөнийг эцэслэх найдлага төрснийг эс тооцвол Америк тив дэлхийн хамгийн их хүчирхийлэлтэй, харилцан адилгүй нөхцөлтэй бүс нутагт тооцогдож байна.

Бүс нутаг даяар улс төрийн кампанит ажил, төрийн зүтгэлтнүүдийн үг ярианд хүний эрхийг хязгаарлах, арьс өнгөөр болон бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхах хандлага давамгайлсан жил болж өнгөрлөө. Ялгаварлах, эмэгтэйчүүдийг дорд үзэх, гадныхныг үзэн ядах өнгө аястай мэдэгдлээр дамжуулан айлгах кампанит ажил явуулсны дүнд Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдож, үүнээс шалтгаалан ирээдүйд дотооддоо болон дэлхий дахинд явуулах тус улсын хүний эрхийн бодлогын тухайд ноцтой санаа зовоосон асуудал үүсэв.

Шударга ёс, суурь эрх чөлөөг хязгаарлах хандлага нэмэгдсэн нь энэ бүс нутаг дахь хүний эрхийн хямралыг улам даамжруулав. Өөрөөр сэтгэгчдийг хайр найргүй нухчин дарах, улам бүр нэмэгдэж буй олон нийтийн бухимдлыг нухчин дарахын тулд шударга ёс тогтоох, аюулгүй байдал хангах зорилготой байгууллагуудыг улс орнууд буруугаар ашиглаж хавчлага, дарлал улам бүр илэрхий, хүч хэрэглэсэн хэлбэртэй болов.

Энэ бүс нутагт ялгаварлан

гадуурхалт, аюулгүй байдал хангагдахгүй байх, ядуурал, байгаль орчны доройтол газар авсан. Мөн авлига, хариуцлагагүй байдлаас шалтгаалан эд баялаг, нийгмийн сайн сайхныг хүртэх, шүүхэд хандах боломж зэрэгт тэгш бус байдал гүнзгийрснээс олон улсын хүний эрхийн хэм хэмжээг мөрдсөнгүй.

Шүүхэд хандахад хүндрэлтэй, эрх зүйт ёс суларч буй явдал бүс нутгийн олон оронд түгээмэл байна. Хүний эрхийн зөрчилд ял завших нь өндөр байгаагийн дээр зарим тохиолдолд хараат бус, шударга шүүхийн тогтолцоогүйгээс улс төрийн болон эдийн засгийн ашиг сонирхолд үйлчилж байна.

Энэ нь хүний эрхийн зөрчил арилахгүй байхад нөлөөлж байна. Ялангуяа, Бразил, Мексик, Венесуэл зэрэг улсад эрүүдэн шүүхийн эсрэг хууль тогтоомж байгаа ч эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал түгээмэл хэвээр байна.

Шүүх зохих ёсоор ажиллахгүйн дээр хүний эрхийг хамгаалсан нийтийн аюулгүй байдлын бодлого хэрэгжихгүй байгаагаас хүчирхийлэл гаарсан. Бразил, Эль Сальвадор, Ямайка, Мексик, Венесуэл зэрэг улсад дэлхий дээр хамгийн их аллага үйлдэгддэг.

Газар авсан хүчирхийлэл, аюултай байдал ихэвчлэн хууль бага оврын зэр зэвсэг, заримдаа цагдаа, цэргийн оролцоотойгоор газар нутгийг бүхэлд нь хяналтандаа авсан болон эсхүл зохион байгуулалттай гэмт хэрэгтэй

холбогдож, нөхцөлдөн оршиж байна.

Дэлхийн хамгийн их зөрчил, мөргөлдөөнтэй бүсүүдээс илүү олон хүн амь насаа алдаж байгаагаас үзэхэд Төв Америкийн “Умардын гурвалжин” гэгддэг Эль Сальвадор, Гватемал, Гондурас улс дэлхийн хамгийн их хүчирхийлэлтэй газруудад тооцогддог. Эль Сальвадор улсад 100 мянган хүнд 108 санаатай аллага бүртгэгдсэн нь дэлхийн хамгийн өндөр үзүүлэлт юм. Гэмт бүлэглэлүүдийн бараан сүүдэр дор олон хүний өдөр тутмын амьдрал өнгөрч байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл өргөн тархсан нь Америк тивийн орнуудын хамгийн аймшигт байдал юм. Латин Америк болон Карибын Эдийн засгийн комиссын 10 дугаар сард гаргасан тайланд дурдсанаар энэ бүс нутагт өдөр бүр 12 эмэгтэй жендэрийн улмаас алагдаж, амь насаа алдаж байна (ийм гэмт хэргийг “фемцид” гэж зүйлчилдэг). АНУ-ын Төрийн Департаментын судалгаагаар АНУ-д 5 эмэгтэй тутмын 1 нь коллежид байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртдөг ч 10 тохиолдлын зөвхөн 1 нь бүртгэгддэг.

Энэ бүс нутаг даяар лесбиян, гей, бисексуал, транжендэр, интерсекс /ЛГБТИ/хүмүүс хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөх явдал өндөр байгаагийн зэрэгцээ шүүхэд хандахад улам бүр их саад тотгортой тулгарч байна. АНУ-д ЛГБТИ хүмүүс үзэн ядах гэмт хэргийн бай болох магадлал өндөр гэдгийг Флорида мужийн Орландо хотын шөнийн клубт болсон зэвсэгт халдлага харууллаа. Үүний зэрэгцээ Бразил улс транжендэр хүмүүсийн хувьд дэлхийд хамгийн

их амь насаа алддаг газруудын нэг байсаар байна.

Энэ бүс нутагт “огцом” тархаж буйг нь илрүүлснийхээ дараа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Зика вирусыг дэлхий нийтийн эрүүл мэндэд нүүрлэсэн аюул гэж үзэн, онцгой байдал зарлав. Хүүхэд хэвийн хэмжээнээс хэт жижиг толгойтой төрөх шалтгаан болдог уг вирус эхээс хүүхдэд, цаашлаад бэлгийн замаар халдварлаж болзошгүй гэх айдсаас үүдэн энэ бүс нутагт бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг үр дүнтэйгээр хангахад саад учирсан.

Чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөх эрхийг нь хүндэтгэлгүйгээр уугуул иргэд, үндэстний цөөнх, тариачдын газар нутаг, байгалийн баялагийг ашиглахын тулд олборлох болон бусад аж үйлдвэрийн салбарт нөлөө бүхий үндэстэн дамнансан корпорацууд хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа улс орнуудын эрх мэдлийн хоосон орон зайг эзлэн авч байна. Ингэснээр эдгээр нийгмийн бүлгүүд эрүүл мэнд, байгаль орчин, амьжиргаа, соёлын хувьд аюул заналд өртөхийн зэрэгцээ тэднийг хүчээр нүүлгэн суурьшуулж байгаагаас шалтгаалан устан үгүй болоход хүрч байна.

Улс төрийн хавчлага, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, ядуурал өөр нэг мартагдаж, ужгирсан хүмүүнлэгийн хямрал үүсгэж байна. Гол төлөв Төв Америкаас дүрвэн гарсан олон зуун мянган иргэн өмгөөлөл, хамгаалал эрэн, орон гэрээсээ дайжин явахаас өөр аргагүйд хүрч байгаа нь хүний эрх зөрчигдөх эрсдэлд оруулах, амь насаараа дэнчин тавих нөхцөл болж байна.

Олон орны засгийн газар

шүүмжлэлийг үл тэвчих нь гүнзгийрч байгаагаас өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах, үг хэлэх эрх чөлөөг хааж боогдуулж байна.

Мексикийн засаг захиргаа шүүмжлэлийг хүлээн авах тун дургүй байгаа нь тус улсад үүссэн хүний эрхийн хямралыг үгүйсгэснээс нь харагдав. Наад зах нь 30000 хүн сураггүй алга болсон баримт, мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх аюулгүй байдлын ажиллагааны улмаас олон мянган хүн амь насаа алдаж, хүчирхийлэл газар сайгүй байгаагаас олон зуун иргэд орон гэрээ хүчээр орхин нүүж байгааг үл харгалзан Мексикийн засаг захиргаа иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагууд, түүний дотор НҮБ-ын шүүмжлэлийг үл тоомсорлож байна.

Хүмүүнлэгийн болон эдийн засгийн хямрал үүссэнийг үгүйсгэж, олон улсын тусламж хүсэхээс татгалзсаны улмаас засгийн газар олон сая хүний амь амьдрал, эрхийг эрсдэлд оруулж буйгаас үзэхэд үл зөвшөөрөх явдал Венесуэл улс дахь хүний эрхийн төлөвийг тодорхойлж байна. Хоол хүнс, эм тарианы ноцтой хомсдол үүсч, үзэн ядах гэмт хэргийн түвшин хурдтай өсч, цагдаагийн хүчирхийллийн түвшин өсч байгаа зэрэг хүний эрхийн зөрчил гарсаар байгааг үл харгалзан засгийн газраас ард иргэдийнхээ тусламж хүссэн дуудлагад хариулахын оронд шүүмжлэлийг дуугүй өнгөрүүлж байна.

АНУ цагаачидтай зүй бусаар харьцдаг, Кубын хүний эрхийн нөхцөл байдалд АНУ-ын зүгээс тавьсан хориг арга хэмжээний нөлөө, Кубад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хангагдаагүй, нийгмийн идэвхтнүүдийг нухчин

дардаг зэрэг энэ хоёр улс дахь хүний эрхийн сорилт бэрхшээлийг олон улсын анхаарлын төвд оруулснаараа 2016 оны анхаарал татсан үйл явдалд АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн Куба улсад хийсэн төрийн айлчлал багтаж байна.

Дөрвөн жил гаруй үргэлжилсэн яриа хэлэлцээний дүнд Колумбын хувьсгалт зэвсэгт хүчин (ФАРК)-тэй байгуулсан энхийн гэрээг Колумбын Конгресс соёрхон баталснаар олон сая хүний амь насыг авсан 50 жил үргэлжилсэн энэ бүлэглэлтэй хийсэн тэмцлийг эцэслэв. Колумбын хоёрдахь том зэвсэгт бүлэглэл болох Үндэсний чөлөөлөх армитай энхийн яриа хэлэлцээ эхлүүлэх тухай зарласан боловч тус бүлэглэл барьцаалсан чухал албан тушаалтны нэгийг суллаагүйн улмаас яриа хэлэлцээ оны эцсийн байдлаар эхлээгүй байна.

Гайтид үхлийн аюултай хар шуурга дэгдэн хүмүүнлэгийн ноцтой хямрал үүсгэж, байгалийн гамшгаас үүссэн хохирол, гарзыг гэтлэн давахад нэрмээс болов. Санхүүжилт, улс төрийн хүсэл эрмэлзэлгүй байх зэрэг уягирсан бүтцийн асуудлуудаас шалтгаалан 2010 оны газар хөдлөлтийн дараа үүссэн гамшгийн улмаас хуарангуудад амьдарч буй 60 мянган хүнийг хүрэлцэхүйц байр, орон сууцаар хангах боломжгүй байдалд Гайти улс оров. Цагдаагийн зүгээс хүч хэтрүүлэн хэрэглэснийг эсэргүүцсэн бослого, тэмцэл өрнөсний улмаас ерөнхийлөгчийн болон хууль тогтоох байгууллагын сонгууль 2 удаа хойшилсон. 11 дүгээр сард Жовенел Мойсе ерөнхийлөгчөөр сонгогдлоо.



## **ЭРСДЭЛ ДУНДАХ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД**

Америк тивийн олон оронд хүний эрхийг хамгаалах явдал туйлын аюултай ажил хэвээр байна. Сэтгүүлч, хуульч, шүүгч, улс төрийн сөрөг хүчнийхэн, гэрчүүд аюул занал, халдлага, эрүү шүүлт, хүчээр алга болгох үйлдлийн бай болдог төдийгүй зарим тохиолдолд төрийн болон төрийн бус тоглогчид тэднийг дуугүй болгохын тулд амь насыг нь хөнөөдөг. Мөн хүний эрхийн идэвхтнүүд гүтгэлэг, доромжлолд өртдөг. Гэсэн ч эдгээр халдлагыг мөрдөн шалгах, гэмт буруутнуудыг шүүхийн өмнө аваачих талаар тун бага ахиц дэвшил гарч байна.

Нэн ялангуяа томоохон хөгжлийн төсөл болон үндэстэн дамнасан корпорацуудыг эсэргүүцсэн хүний эрхийн хамгаалагчид, нийгмийн хөдөлгөөнүүд өс хонзон авах үйлдэлд өртөх эрсдэл байна. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчид, нийгмээсээ тусгаарлагдсан хүмүүс хүчирхийллийн золиос болж байна.

Бразилд хүний эрхийг хамгаалагчид халдлага, аюул занал, аллагад өртөх нь нэмэгдэж байна. Никарагуа улсын засгийн газар хүний эрхийн зөрчлийг нүдээ анин өнгөрөөж, нийгмийн идэвхтнүүдийг мөрдөн шалгаж байна. Хүнд өвчтэй сөрөг хүчний удирдагч Росмит Мантиллад хагалгаа хийлгэхийг зөвшөөрөхийн оронд торны цаана суулгаснаар Венесуэлд хоригдлуудыг хүлээж байдаг таагүй нөхцөл, өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах гэсэн засгийн газрын эрмэлзлийг илэрхий харуулав. Дотоод болон олон улсын зүгээс хүчтэй дарамт шахалт үзүүлсний

дараа тэрээр шаардлагатай эмнэлэгийн тусламж авч, 11 дүгээр сард суллагдсан.

Байгаль орчин, газар нутгаа хамгаалах зорилготой идэвхтнүүдийг заналхийлэх, хилс ял тулгах, нэр төрийг нь гутаах, биед нь халдах, амь насыг хохироох явдал ихэсч байгаагаас Гондурас, Гватемал улс газар нутаг, байгаль орчноо хамгаалан тэмцэгчдийн хувьд хамгийн аюултай орнууд болов. Гондурасын уугуул иргэдийн нэрт удирдагч Бертс Касересыг зэвсэгт этгээдүүд гэрт нь 3 дугаар сард буудан хөнөөсөн явдал газар нутаг, байгаль орчныг хамгаалахын төлөө ажиллаж буй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл газар авсныг харууллаа.

Гватемал улсад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зөрчих, буруугаар ашиглах замаар байгалийн баялгийг ашиглах төслийг эсэргүүцсэн хүний эрхийн хамгаалагчдад гэмт хэрэг тулгах, “нийгэм доторх дайсан” гэж үзэх нь түгээмэл байна. Колумб улсад хүний эрхийн хамгаалагчид, ялангуяа нутгийн удирдагчид, байгаль орчны идэвхтнүүдийг заналхийлэх, амь насыг хохироох явдал айдас төрүүлэм ихээр гарч байна.

Аргентинд нийгмийн удирдагч Милагро Салагаг Жужуй мужид тайван жагсаал хийснийх нь төлөө баривчилж, ял оноов. Хэдийгээр түүнийг суллах шийдвэр гарсан ч хорьж саатуулсан хэвээр байна. 10 дугаар сард НҮБ-ын дур мэдэн хорьж саатуулах асуудал эрхэлсэн ажлын хэсгийн зүгээс түүнийг хорьж саатуулсан явдал дур мэдэн хийсэн үйлдэл гэсэн дүгнэлтийг гаргаж, даруй суллахыг зөвлөмж болгов.

Перугийн умард хэсэгт, бүс нутгийн хамгийн том алт, зэсийн

уурхайнуудын нэг болох Янакочатай газрын эзэмшлийн асуудлаар эрх зүйн тэмцэл явуулсан тариачин эмэгтэй Максима Акуна байгаль орчны нэр хүнд бүхий шагнал болох Гольдманы шагналыг 2016 онд хүртэв. Хамгаалалтын албаны ажилтнууд өөрийнх нь болон гэр бүлийнх нь биед халдах замаар айлган сүрдүүлж, заналхийлсэн боловч тэрээр орон нутгийн нуур усаа хамгаалах, газраа өөртөө авч үлдэх тэмцэлдээ эцсээ хүртэл бат зогсож, эсэргүүцэж чадсан юм.

Эквадор улсад хязгаарласан хууль тогтоомж болон асуудалд дуугүй өнгөрдөг байдлаас үүдэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ихээхэн хумигдсан. Өөрөөр сэтгэсэн, ялангуяа уугуул иргэдийн газар нутагт хэрэгжүүлэх олборлолтын төслүүдийг эсэргүүцсэн хүмүүст эрүүгийн хэрэг тулгах явдал байсаар байна.

Кубад улс төрийн нээлттэй байдал бий болж, АНУ-тай дипломат харилцаагаа сэргээсэн боловч иргэний нийгэм, эсэргүүцлийн бүлгүүд засгийн газрыг шүүмжилснийхээ төлөө сүрдүүлэг, заналхийлэлд өртөх нь нэмэгдсэн. Хүний эрхийн хамгаалагчид, улс төрийн идэвхтнүүдийг “хорлон сүйтгэгч”, “Кубын эсрэг хөлсний цэргүүд” гэж цоллох болов. Зарим хүнийг нэг сард хэд хэдэн удаа үндэслэлгүйгээр хорьж, ял тулгахгүйгээр сулласан явдал гарсан.

### **АМЕРИК ХООРОНДЫН ХҮНИЙ ЭРХИЙН СИСТЕМД ТУЛГАРЧ БҮЙ АЮУЛ**

Хүний эрхийг хамгаалж, дэмжих, эрх орондоо эрхээ хамгаалж чадаагүй хохирогчдыг шударга шүүхээр шүүлгэх нөхцөлийг

хангахад чухал үүрэгтэй Хүний эрхийн асуудлаарх Америк хоорондын комисс /ХЭАХК/ жилийн туршид санхүүгийн хямралтай нүүр тулгарсан. Америкийн улсуудын байгууллагын гишүүн орнууд хангалттай нөөц хуваарилахгүй байсан нь үүнд нөлөөлсөн. Ингэснээр тэд өөрийн улсын нутаг дэвсгэртээ болон түүнээс гадна хүний эрхийг дэмжин, хамгаалах улс төрийн хүсэл зориг дутмаг гэдгээ харуулав.

ХЭАХК нь түүхэндээ байгаагүй хүнд хэцүү санхүүгийн хямралтай нүүр тулсан гэдгээ 5 дугаар сард мэдэгдсэн. Улс орнуудыг олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу үүргээ биелүүлэхэд илүү чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай үед энэ нь ХЭАХК -ын хүний эрхийн нийт зөрчил, ялгаварлан гадуурхалтай тэмцэхэд гаргасан ахиц дэвшлийг сулруулах бодитой аюул болов.

Жилд 8 сая ам.долларын төсөвтэй ХЭАХК нь Африк (13 сая ам.доллар), Европ (104.5 сая орчим ам.доллар)-ын ижил төстэй байгууллагуудтай харьцуулахад дэлхийн хамгийн бага төсөвтэй хүний эрхийн байгууллага болж хоцров.

Хүний эрхийн асуудлаарх Америк хоорондын комисс төсвийн орлогоо бүрдүүлэхээр нэмэлт санхүүжилт авсан ч улс орнуудын хүний эрхийн нөхцөлд ямар ноцтой байдал үүссэнээс үл хамааран хангалттай санхүүжилт хийж, хамтран ажиллахгүй бол улс төрийн хямрал үргэлжилсээр байх вий гэсэн санаа зовоосон асуудал үүссэн юм.

ХЭАХК-ын үйл ажиллагааг дэмжээгүй тодорхой тохиолдлууд гарав. 2014 онд цагдаагийнханд баривчлагдсныхаа дараа 43

оюутныг хүчээр алга болгосон Аёзинафагийн хэрэг дээр тус байгууллага ажиллахад Мексикийн засгийн газар саад учруулахыг оролдсон. Засаг захиргааны зүгээс гэмт хэргийн бүлэглэлүүд эдгээр оюутныг барьцаалж, шатааж, хогийн саванд хаясан гэсэн бол Америк хоорондын хүний эрхийн асуудлаарх комиссоос томилсон шинжээчдийн бүлэг ийм олон хүнийг дээр дурдсан нөхцөлд шатаах боломжгүй гэдэг дүгнэлт гаргасан. 11 дүгээр сард ХЭАХК шинжээчдийн санал зөвлөмжийн дагуу тусгай механизм байгуулсан засаг захиргааны зүгээс зохих дэмжлэг авна гэх баталгаа хомс байна.

### **ДҮРВЭГЧ, ЦАГААЧ, ХАРЪЯАЛАЛГҮЙ ХҮМҮҮС**

Төв Америк нь хурдацтай гүнзгийрч буй цагаачлалын хямралын эх үүсвэр болоод байна. Дэлхийн мартагдсан энэ хэсэгт харгис хүчирхийлэл гаарсаар байгаа нь Төв Америкийн иргэдийг Мексик, АНУ болон бусад орноос орогнол ихээр эрэхэд хүргэж, цаашлаад энэ нь олон арван жилийн өмнө эцэс болсон бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөнөөс хойших үзэгдээгүй өндөр түвшинд хүргэв.

Орогнол эрэх, АНУ-д очих зорилгоор олон зуун мянган хүн Мексикээр дамжин ирж байна. Тэдний олонх нь хүнд нөхцөлд саатуулагдах, алагдах, хулгайлагдах аюул, нутгийн засаг захиргаатай үгсэн хуйвалдсан гэмт хэргийн бүлэглэлүүдийн мөнгө нэхсэн сүрдүүлэгтэй нүүр тулж байна. Ялангуяа, харж хандах хүнгүй олон тооны хүүхэд, өсвөр насныхан хүний эрхийн зөрчилд өртөж, эмэгтэйчүүд, охид бэлгийн

хүчирхийлэл, хүний наймаанд өртөх ноцтой эрсдэлтэй тулгардаг.

Орогнол эрэгсдийн олонх нь ноцтой хүчирхийлэлд өртөх эрсдэлтэйг үл харгалзан орогнол аваагүй тохиолдолд тэднийг Мексик, АНУ-аас албадан гаргах явдал байсаар байна. Хүмүүсийн олонх нь дайжин явсан амь насанд нь ноцтой аюул учруулахуйц нөхцөлдөө хүчээр эргэн очдог. Албадан гаргагдсан тэдний зарим нь дээрмийн бүлгүүдийн гарт амь насаа алдаж байна.

Хүчирхийллээс иргэдээ хамгаалж, Мексик, АНУ зэрэг орнуудаас албадан гаргагдсан хүмүүст чиглэсэн иж бүрэн хамгааллын төлөвлөгөө боловсруулж чадаагүйгээс Гондурас, Гватемал, Эль Салвадор улс энэ хямралыг улам их даамжруулж байна.

Улс орнууд хямралд хариуцлага хүлээхээсээ илүү Мексикээс АНУ хүрэх замдаа хүмүүсийн өртөж буй хүний эрхийн зөрчилд л анхаарал хандуулж байна. Гэмт хэргийн бүлэглэлүүдээс нутаг дэвсгэрээ салган авч, хяналтандаа оруулах гэсэн тэмцлээс үүдэн хүн амын ихэнхид өдөр тутам учирч буй аюул занал, айлган сүрдүүлэлтийн талаар дурдалгүйгээр эдийн засгийн хэрэгцээ шаардлагын улмаас ихэнх иргэд орон гэрээ орхин дүрвэж байна гэж засгийн газрууд нөхцөл байдлыг буруугаар тайлбарлаж байна.

Оны туршид, харж хандах хүнгүй олон арван мянган хүүхэд, гэр бүлтэйгээ явж буй иргэдийг өмнөд хилийг нь давах гэж оролдох үед нь АНУ-д баривчлан саатуулсан. Эрүүл мэндийн зохих халамж үйлчилгээ, эрх зүйн туслалцаа үзүүлэлгүйгээр гэр бүлийн хүмүүсийг олон сараар

хорьж саатуулжээ. НҮБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн комиссар хорьж саатуулах нөхцөл байдлыг “хүмүүнлэгийн болон хамгааллын хямрал” гэж тодорхойлов.

АНУ-д очихоор оролдсон Кубын болон Гайтигийн цагаачдын талаар санаа зовниж буйгаа Хүний эрхийн асуудлаарх Америк хоорондын комисс оны туршид илэрхийлэв.

Газар сайгүй цагаачид, тэдний гэр бүл өргөн хүрээг хамарсан ялгаварлан гадуурхалт, нийгмийн гадна үлдэх, зүй бусаар харьцах асуудалтай нүүр тулгардаг. Багама улсад Гайти, Куба зэрэг орноос ирсэн бичиг баримтгүй цагаачдад зүй бусаар хандах нь түгээмэл болж байна. Ихэнхдээ албадан гаргах тухай олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэн мөрдөхгүй атлаа Доминикан улс Гайти гаралтай, түүний дотор Доминиканд төрсөн харъяалалгүй олон мянган хүнийг албадан гаргасан. Гайтид ирэхэд нь албадан гаргагдсан олон хүнийг хиртхийлгэм нөхцөлтэй түр хорогдох хуарангууд хүлээж байв.

Доминикан улсын шинээр сонгогдсон засаг захиргаа харъяалалгүй иргэдийн байдлыг шийдвэрлэхэд хүчин чармайлт гаргасан ч тус улсын Үндсэн хуулийн шүүхээс шийдвэр хэрэгжих өдрөөс эхлэн болон дур мэдэн олон мянган хүнийг иргэний харъяаллаас хасах шийдвэрийг 2013 онд гаргаснаар тэд өнөөг хүртэл харъяалалгүй байсаар байна. 2 дугаар сард Хүний эрхийн асуудлаарх Америк хоорондын комиссоос “харъяалалгүй хүмүүсийн тухайд бий болсон нөхцөл байдлыг Америк тивд урьд өмнө нь байгаагүй түвшинд хүрсэн” гэж тодорхойлов.

Сирийн 30000 гаруй дүрвэгч Канадад суурьшсан бол АНУ-д 12000 дүрвэгч суурьшсан.

## **НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ**

Корпорацууд, гэмт хэргийн сүлжээ зэрэг төрийн бус тоглогчид ихээхэн хүч нөлөөтэй болж, хүчирхийлэл, хүний эрхийн зөрчлийн түвшин нэмэгдэхэд нөлөөлж байна. Харин бүхэлд нь авч үзвэл улс орнууд олон улсын стандартад нийцсэн байдлаар үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэж чадахгүй байгаагийн зэрэгцээ нийтийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах хандлагаас үүдэн хүний эрхийн ноцтой зөрчлүүд гарч байна.

Зарим улс орон үймээн самуун, ялангуяа тайван эсэргүүцэл хөдөлгөөнийг намжаахдаа нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд цэрэг, армийг ашиглах явдал нэмэгдсэний зэрэгцээ цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагуудын хэрэглэдэг цэргийн арга техник, сургалт, техник хэрэгслийг ашиглаж байна. Цэргийн хүч хэрэглэсэн явдлыг зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд гэж зөвтгөдөг боловч бодит байдал дээр энэ нь хүчирхийллийн үндсэн шалтгааныг арилгахаасаа илүү улс орнууд хүний эрхийг улам их зөрчих нөхцлийг бүрдүүлдэг. Тухайлбал, Венесуэл зэрэг улсад эсэргүүцэл хөдөлгөөнийг цэргийн аргаар шийдвэрлэж байснаас эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцогчдод эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий хандсан явдал гарав.

Миннесотад Филандо Кастилег 7 дугаар сард, Луизианад Алтон Стерлингийг буудан хөнөөсний

дараа болсон АНУ-ыг хамарсан эсэргүүцлийн жагсаалыг намжаах зорилгоор цагдаагийн ажилтнууд үймээн самууныг дарахад хэрэглэдэг хүнд тоноглол, цэргийн зориулалтай зэвсэг хэрэглэсэн нь ноцтой сэтгэл түгшээсэн асуудал үүсгэв. Умард Дакота мужийн *Standing Rock Sioux Reservation* тусгай хамгаалалтай газрын ойролцоо Дакотад хоолой барихыг эсэргүүцсэн тайван жагсаалыг тараахад цагдаагийн хүч хэрэглэсэн нь санаа зовоосон асуудал боллоо. Үүний зэрэгцээ АНУ-ын засаг захиргаа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын гарт яг хэдэн хүн амь насаа алдсан талаар нарийн мэдээллийг дахиад л гаргаж чадсангүй. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын тооцоогоор 2016 онд 1000 орчим хүн амь насаа алдснаас цахилгаан цохиулах зэвсэг хэрэглэсний улмаас наад зах нь 21 хүн амь насаа алджээ.

Бразил улс 8 дугаар сард зохион байгуулсан Олимпийн наадмын үеэр аюулгүйн хүчнийхэн хүний эрхийн зөрчил гаргасны зэрэгцээ засаг захиргаа, зохион байгуулагчдын зүгээс хүчирхийлэл, зөрчлөөс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэнгүй. Рио Де Жанеро хот олимпийн наадамд бэлтгэх үед цагдаа энгийн иргэний амь насыг хөнөөх явдал нэмэгдэв. Олимпийн наамдын туршид цагдаагийн хүч хэрэглэсэн ажиллагаа явагдсаны зэрэгцээ шаардлагагүй тохиолдолд болон хэтрүүлэн хүч хэрэглэх зэргээр эсэргүүцлийн хөдөлгөөнийг хатуу чангаар нухчин дарсан. Оны туршид тус улсын зүгээс явуулсан мансууруулах бодистой тэмцэх, аюулгүй байдлын ажиллагаанд зэвсгийг ихээр хэрэглэсэн нь хүний эрхийн зөрчлийг даамжруулж,

цагдаагийн ажилтнуудыг эрсдэлд оруулав.

Түүнчлэн Багама, Чили, Доминикан, Эквадор, Эль Салвадор, Ямаик, Мексик, Перу, Венесуэл зэрэг улсад цагдаа болон аюулгүй байдлын бусад байгууллага хүчийг хэтрүүлэн, шаардлагагүй тохиолдолд хэрэглэсэн байна.

Ямаик улсад хууль бусаар хүний амь насыг хөнөөх явдал 20 жилийн туршид бараг өөрчлөгдөлгүйгээр цагдаагийн ажиллагааны нэг хэлбэр байсаар байгаа бол Доминиканы аюулгүйн хүчнийхний хүний амь насыг хохироосон үйлдлүүдийн олонх нь хууль бус гэж бүртгэгдсэн байна. Эдгээр хоёр орны аль алинд нь аюулгүй байдлын хүчнийхэн шинэчлэл, өөрчлөлтийн гадна үлдэж, барагтай бол хариуцлага хүлээдэггүй.

## **ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХ, ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ЗОГСООХЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ**

Ял завшуулдагаас хүний эрхийг зөрчигчид үр дагавраас нь айлгүй үйл ажиллагаа явуулах боломжтой болж, эрх зүйт ёсыг сулруулж, олон сая хүнд шударга үнэн үйчлэхгүй байна.

Хангалттай нөөцгүй, сул, ихэнхдээ авлигад идэгдсэн шүүх, аюулгүй байдлын тогтолцоо нь алагчлалгүй шударга, бие даасан байдлыг хангах улс төрийн хүсэл байхгүйтэй нэгдэн ял завших явдал арилгахгүй байна.

Хүний эрхийг зөрчигчдийг шүүхийн өмнө аваачиж чадахгүй байгаагаас үүдэн зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль сахиулах бурангуй практик тогтох, өргөжин тэлэх бололцоог олгож байна.

Бразил, Колумб, Гватемал, Мексик, Гондурас, Ямаик, Парагвай, Перу, Венесуэл зэрэг улсад шүүхэд хандах боломж хаагдмал байдгаас олон арван хүн эрхээ хамгаалах боломжгүй болов.

Ямаик улсад хууль сахиулах ажилтнууд аллага үйлдэж, шүүхийн шийдвэргүйгээр цаазаар авах ялыг гүйцэтгэсэн ч ял шийтгэлгүй үлдэж байна. 2000 оноос хойш хууль сахиулах байгууллагын ажилтнуудын гарт 3000 гаруй хүн амь насаа алдсан байхад үүнээс маш цөөнд нь хариуцлага тооцжээ. 2010 онд зарласан онц байдлын үеэр хүний эрх зөрчсөн асуудлыг мөрдөн шалгах комисс цагдаагийн шинэчлэлийн талаар зөвлөмж гаргасан. Оны эцсийн байдлаар Ямаик улс дээр дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гаргаагүй байв.

Чили улсад тайван замаар жагссан иргэдийг зодож, хүнлэг бусаар харьцсан, зарим тохиолдолд амь насыг нь бүрэлгэсэн аюулгүй байдлын хүчний ажилтнуудын олонх нь ял шийтгэл хүлээсэнгүй. Аюулгүйн хүчний ажилтнуудын үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдийг шийдвэрлэдэг цэргийн шүүх нь бие даасан, алагчлалгүй шударга байх наад захын шаардлагыг хангаагүйгээс гэмт хэрэгт сэжиглэгдэж буй ажилтнуудыг хангалттай байцааж, мөрдөн шалгаж чаддаггүй.

7 дугаар сард Парагвай улсын шүүхээс 2012 онд болсон Куругуати дүүрэгт болсон газрын маргааны үеэр цагдаагийн 6 ажилтны амь насыг хөнөөсөн болон бусад холбогдох гэмт хэргийг үйлдсэнийх нь төлөө бүлэг тариачдыг 30 хүртэлх жилийн ялаар шийтгэсэн. Гэсэн хэдий ч яг энэ хэрэг явдлын үеэр 11 тариачны амь

насыг хөнөөсөн хэргийг мөрдөн шалгаагүй. Ерөнхий прокурор эдгээр тариачдын үхлийн талаар хангалттай мөрдлөг явуулгүйн улмаас үнэмшилтэй тайлбар өгөөгүйн дээр хэргийн газрын эд мөрийн баримтыг хөдөлгөж, хоригдож байхад нь тариачдад эрүү шүүлт тулгасан зэрэг асуудалд хариу өгч чадаагүй.

АНУ-ын Сенатын тайлан гарснаас 2 жилийн дараа буюу оны эцсийн байдлаар, 2001 оны 9 дүгээр сарын 11-ний дараа Тагнуулын төв газраас явуулсан нууцаар хорих, байцаах хөтөлбөрүүдийн үеэр хүний эрхийг зөрчсөн асуудлыг АНУ-д хэн ч сөхөн, шүүхээр шийдвэрлүүлсэнгүй.

2013 онд баривчлагдаад хэдэн долоо хоногийн дараа амь насаа алдсан байдалтай олдсон хүнийг хүчээр алга болгох үйлдэлд буруутгагдсан Мексикийн 5 тэнгисийн явган цэргийг мөрдөн шалгасан явдал хүчээр алга болгох асуудалтай шинэ байдлаар тэмцэх нь гэсэн итгэл найдварыг төрүүлэв. Мексик улс даяар олон арван мянганы хүний хувь заяа хэрхсэн нь тодорхойгүй хэвээр үлдлээ.

Аргентин, Болив, Чили, Перу зэрэг улсад ял завших явдал арилгахгүй байгаа болон өнгөрсөн жилүүдэд цэргийн дэглэмийн үед үйлдэгдсэн шүүхийн шийдвэргүйгээр олон мянган хүнийг цаазаар авах, хүчээр алга болгох зэрэг олон улсын эрх зүйн дагуу хүний эрхийн зөрчил, гэмт хэрэгт тооцогдох үйлдлийг мөрдөн шалгах улс төрийн хүсэл зориг байхгүй байгаа нь хохирогчид болон тэдний гэр болгоонож олж, шударга ёсыг тогтоож өгч, нөхөн төлбөр олгох нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Гэвч бүс нутгийг хамарсан

тагнуулын ажиллагааны үеэр олон зуун хүнийг хүчээр алга болгох үйлдэлд гүйцэтгэсэн үүргийнх нь төлөө Аргентины де-факто Ерөнхийлөгч асан Рейналдо Бигнонод 20 жилийн ял ногдуулж, бусад 14 цэргийн офицерыг шоронд хорих ялаар шийтгэв. Ийм шийдвэр гарч байгаа нь шударга ёсыг тогтооход эерэг алхам болж, дараа дараагийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүд хаалгыг нээж өгөх байх гэсэн итгэлийг төрүүлж байна.

Гватемалд ял завших явдлыг арилгахад явц удаан байгаа ч уугуул Маяа Кюэчи эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн боолчлол, хүчирхийлэл үйлдснийх нь төлөө цэргийн 2 албан хаагчийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутай болохыг тогтоосон.

7 дугаар сард Эль Сальвадорын Дээд шүүх өршөөлийн хуулийг Үндсэн хуульд нийцэхгүй гэж зарласан. Энэ нь 1980-1992 онд болсон зэвсэгт мөргөлдөөний үед үйлдэгдсэн олон улсын эрх зүйн гэмт хэрэг, хүний эрхийн бусад зөрчлийг шүүхээр шүүхэд чухал алхам болов.

Гайтигийн Ерөнхийлөгч асан Жан Клауд Дувалиер болон түүний хуучин хамсаатнуудын үйлдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн мөрдлөгөд ахиц дэвшил гарсангүй.

### **ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ**

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд улс орнууд хангалттай ахиц дэвшил гаргасангүй. Үүнд, хүчирхийлэл, аллагаас хамгаалж, гэм буруутнуудад хариуцлага хүлээлгэж чадахгүй байна. Бразил, Канад, Доминикан, Эль Сальвадор, Ямайка, Никарагуа, АНУ, Венесуэл зэрэг улсаас жендэрт суурилсан

хүчирхийллийн талаарх мэдээлэл их ирдэг.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн зөрчил охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлж байна. Америк тивд үр хөндөлтийг бүрэн хориглосон хамгийн олон улс байдаг. Зарим улсад үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийг шоронд хорьсон бол бүр үр зулбасан эмэгтэйг үр хөндүүлсэн гэж хорьсон тохиолдол гарав.

Никарагуа улсад ядуу, зүдүү нөхцөлд амьдарч буй эмэгтэйчүүд эхийн эндэгдэлд голдуу өртдөг бөгөөд бүс нутагтаа өсвөр насны охидын жирэмслэлт хамгийн өндөр байдаг орнуудын нэгд тооцогдож байна. Мөн тус улсын эмэгтэйчүүдэд дэлхийн хамгийн хатуу үр хөндөлтийн хууль үйлчилдэг. Хэдийгээр эмэгтэйн амь насыг аврахтай холбогдсон байсан ч бүх тохиолдолд үр хөндөлтийг хориглосоор байна. Доминикан улсад зарим тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар эрүүгийн хуулийг шинэчлэх ажил дахин хойшлов. Чили улсад үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх хууль, эрх зүйн шинэчлэлийн асуудлыг хэлэлцсэн хэвээр байна.

Гэсэн хэдий ч итгэл найдварын бага ч гэсэн шинж тэмдэг ажиглагдаж байна. Үр зулбасных нь дараа 40 жил шоронд хоригдох ялаар шийтгүүлснийхээ 4 жилийг нь эдэлсэн Тереза Ривераг суллах шийдвэрийг шүүхээс гаргасан нь эмэгтэйчүүдэд хэрцгий ханддаг энэ оронд шударга ёсыг тогтоох нэг алхам боллоо. Хүний эрхийн асуудлаар гарсан өөр нэг ялалтыг дурдвал, Аргентинд Дээд шүүхээс хорих хангалттай үндэслэл байхгүй гэж үзсэнээр үр зулбасныхаа дараа 8 жил хоригдох ялаар шийтгүүлсэн

эмэгтэйг урьдчилсан хорих газраас суллав.

### **УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ**

17 жил үргэлжилсэн яриа хэлэлцээний дүнд Америкийн улсуудын байгууллага Америкийн уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалыг батлав.

Гэсэн хэдий ч Америк тивд амьдарч буй уугуул иргэдийн газар, байгалийн баялаг, соёлын талаарх эрх олонтаа зөрчигдөхийн зэрэгцээ тэд хүчирхийлэл, аллага, цагдаагийн хүчийг хэтрүүлэн хэрэглэх үйлдлийн золиос болсоор байна. Аргентин, Бразил, Чили, Колумб, Эквадор, Мексик, Перу, Парагвай зэрэг улсад олон мянган хүний өдөр тутмын амьдрал нийгмийн гадна үлдэх, ядуурал, тэгш бус байдал, системчилсэн ялгаварлан гадуурхалтын сүүдэрт өнгөрч байна.

Эдийн засгийн ашиг олох зорилгоор төр болон газрын эзэд, бизнес эрхлэгчид зэрэг төрийн бус тоглогчид уугуул иргэдийг оршин сууж ирсэн газраас нь хүчээр нүүлгэн шилжүүлж байна.

Хөгжлийн төслүүд, түүний дотор олборлох салбарын хэрэгжүүлдэг төслүүд уугуул иргэдийн соёлд заналхийлж, зарим тохиолдолд тэднийг нийтээр нь хүчээр нүүлгэн суурьшуулж байна. Гэвч үр дүнтэй зөвлөлдөж, чөлөөтэй, урьдчилан мэдээлэл авч зөвшилцөх эрхээ уугуул иргэд эдэлж чадахгүй байх нь түгээмэл байна. Америк тив даяар уугуул тариачин эмэгтэйчүүд байгалийн баялагийг олборлох төслүүдийн эмэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөнд ихээхэн анхаарал тавьж, тэдний газар, эзэмшил нутагт нөлөөлөх хөгжлийн төслүүдийн шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоогоо нэмэгдүүлж байна.

Үр дүнтэй зөвлөлдөлгүйгээр Grand Inter-oceanic Canal сувгийг барих ажлын гэрээнд гарын үсэг зурсан гэж уугуул иргэд, африк гаралтай хүмүүсийн Рама-Криол омгийн удирдагчид 5 дугаар сард мэдэгдэв. Уугуул мискиту иргэд уугуул бус суурьшигчдаас үзүүлэх аюул занал, халдлагад өртөж, бэлгийн хүчирхийлэл, аллага, хүчээр нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны золиос болдог Никарагуагийн Умард Атлантын автономит бүсэд хүчирхийлэл гаарч байна.

Эерэг хандлага гарч байгаагийн дотор Канадын засгийн газрын зүгээс сураггүй алга болсон, алагдсан уугуул эмэгтэйчүүд, охидын талаар үндэсний хэмжээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулах болсноо зарласныг дурдаж болно.

### **ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕСКУАЛ, ТРАНЖЕНДЭР, ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ**

Ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрөх зэргээр зарим оронд эрх зүйн болон тогтолцооны хувьд ахиц дэвшил гарч байгаа нь лесбиян, гей, бисескуал, транжендер, интерсекс /ЛГБТИ/ хүмүүсийг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах хэмжээнд хүрсэнгүй.

Америк тив даяар, түүний дотор Аргентин, Багама, Доминикан, Эль Сальвадор, Гайти, Гондурас, Ямаик, АНУ, Венесуэл улсад ЛГБТИ хүмүүсийг үзэн ядах, хорсон зэвүүцэх, амь насыг нь хөнөөх, мөрдөн хавчих зэрэг гэмт хэргийн гаралт өндөр хэвээр байна. Харин Домикан улсад өнгөрсөн жилийн сонгуулийн үйл явцаас үзэхэд ЛГБТИ гэдгээ ил зарласан нэр дэвшигчид улс төрийн үүрэг, оролцоогоо нэмэгдүүлэхээр сонгуульд өрсөлдлөө.



# АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Дэлхийн хүн амын 60 хувь нь амьдардаг Ази Номхон далайн бүс нутгийн олон Засгийн газар иргэдийнхээ эрхийг зөрчих нь нэмэгдсэн ч, зарим улсад эерэг өөрчлөлт ч мөн гарлаа.

Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, шударга ёсыг байнга, хүчтэй шаардахаас гадна хүний эрхийн зөрчлийн эсрэг үйл ажиллагаа, эсэргүүцэл нэмэгдсэн. Залуус өөрсдийн болон бусдын эрхийн төлөө эрс шийдэмгий дуугарах явдал өслөө. Онлайн технологи, нийгмийн сүлжээ нь мэдээллийг хуваалцах, шударга бус явдлыг илчлэх, зохион байгуулалтад орох, нөлөөллийн ажил хийх өргөн боломж олгосон. Хамгийн хэцүү нөхцөлд, хязгаарлагдмал нөөцтэй ажилладаг хүний эрхийн хамгаалагчид төрийн дарангуйллыг сөрөн зогсож, бусдыг араасаа дагуулсан, эр зоригтой алхмуудыг хийсээр байна.

Гэвч төлөөс нь өндөр байх нь элбэг. Олон засгийн газар эрх чөлөө, шударга ёс болон хүний нэр төр, нандин чанарыг уландаа гишгэх болсон. Тэд хуучин, шинэ хуулийг гуйвуулан ашиглах замаар сөрөг хүчний дуу хоолойг боож, эсэргүүцэл, хөдөлгөөн, түүний дотор өөрөөр сэтгэгчдийг хүч хэрэглэх буюу нухчин дарж байна.

Зүүн Азид Засгийн газруудын ил тод байдал буурч, төр ба иргэдийн хоорондоо зай улам холдож байна. Хятад, БНАСАУ(Хойд Солонгос) зэрэг оронд хэлмэгдүүлэлт үргэлжилсээр

байна. Өмнөд Азид шүүмжлэл ба нээлттэй хэлэлцүүлгийг үл тэвчих нь ихэслээ. Бангладеш улсад блогчдийг хороож, Пакистанд хэвлэл мэдээллийн ажилтнуудад халдаж, Энэтхэг зэрэг оронд иргэний нийгмийн орон зайг хумисаар байна. Тухайлбал, Тайландын цэргийн дэглэм өөрөөр сэтгэгчдийг нухчин дарж, Малайзад улс төрийн дуу хоолойг чимээгүй болгохыг санаархах зэргээр Зүүн өмнөд Азид итгэл үнэмшил, ухамсар, шашин шүтлэг, үзэл бодолтой байх, тэдгээрийг илэрхийлэх, эвлэлдэн нэгдэн эрх чөлөө зэрэг үндсэн эрхэд халдах болсон.

Олон оронд иргэний нийгмийн орон зай хумигдаж, ялангуяа, арьс өнгөөр болон угсаатны цөөнх, охид эмэгтэйчүүдийг ялгаварлахыг өөгшүүлдэг улс орнууд, цар хүрээ нэмэгдсэн.

Хятад, Малайз, Мальдив, Балба, Хойд Солонгос, Филиппин, Сингапур, Тайланд, Зүүн Тимор, Вьетнам зэрэг олон улсад эрүү шүүлт болон бусад хүнлэг бус хандлагыг хүний эрхийг хамгаалагчид, шоовдорлогдсон бүлгийнхэн болон бусад хүмүүсийг онилохдоо хэрэглэх болсон.

Эрүүдэн шүүгчид болон хүний эрхийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа нь хүний эрхийн зөрчлийг гааруулж байна. Олон улсад гэмт этгээд ял завших явдал түгээмэл болжээ. Хохирогчдод шударга ёс, үнэн мөнийг тогтоож өгдөггүй, бусад

хэлбэрийн нөхөн төлбөр олгохоос татгалзсаар байна. Гэхдээ энэ чиглэлд зарим нэг ахиц гарсныг бас дурдах ёстой. Тухайлбал, хэдийгээр ял завших явдал түгээмэл ч Шри Ланка улсад олон арван жилийн турш ужгирсан гэмт хэргийн буруутанд олон улсын эрх зүйгээр хариуцлага хүлээлгэх талаар анхны алхам хийгдсэн. Япон ба БНСУ (Өмнөд Солонгос) Дэлхийн 2 дугаар дайнаас өмнө болон дайны үед байсан цэргийн секс боолчлолын тогтолцооны талаар хоёр талын гэрээ байгуулж чадсан. Гэвч яриа хэлэлцээнд амьд байгаа гэрчүүдийг оролцуулаагүй нь шүүмжлэл дагуулсан юм. Филиппин улсын шүүх түүхэн шийдвэр гаргаж, 2009 онд батлагдсан Эрүүдэн шүүхийн эсрэг хуулиар нэгэн цагдаагийн ажилтныг эрүүдэн шүүсэн гэм буруутай хэмээн үзэж анх удаа ял оноолоо. Олон улсын эрүүгийн шүүхийн Прокурорын газар Афганистанд талибанчууд, Афганистаны Засгийн газар болон АНУ-ын зэвсэгт хүчний үйлдсэн хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааг удахгүй эхэлж магадгүй хэмээн мэдэгдлээ.

Мьянмар улсын Качин муж дахь мөргөлдөөн эрчимжиж, Ракин мужид Рохингя ба Ракине хүмүүс аюулгүй байдлын ажиллагааны улмаас орон гэрээ орхин дүрвэхээс аргагүйд хүрч, хүчирхийлэл даамжирсан бөгөөд сүүлийн жилүүдэд олон арван мянган хүн хүчирхийллийн улмаас дүрвэсэн хүний эрхийн болон хүмүүнлэгийн нөхцөл байдлыг дордуулсан. Эдгээр мужид Засгийн газрын хязгаарлалтын улмаас хүмүүнлэгийн тусламж очиж чадахгүй байна. Афганистан дахь зэвсэгт мөргөлдөөн Талибанчууд дахин

толгойгоо өндийлгөсний улмаас үргэлжилж, энгийн номхон иргэдэд асар их гарз хохирол авчирлаа.

Зүүн хойд Энэтхэгийн Жамму ба Кашмир мужид хүмүүсийг хулгайлах, хууль бусаар амь насыг нь бүрэлгэх зэргээр зэвсэгт бүлэглэлүүд бүс нутгийн хэд хэдэн улсад аюулгүй байдлыг алдагдуулж, зовлон шаналлыг ноцоож байна. Индонези улсад өөрсдийгөө Исламын улс гэж нэрлэсэн зэвсэгт бүлэглэл хүний амьд явах эрхийг уландаа гишгэн бөмбөг дэлбэлж, буудалцаар байна. Афганистанд зэвсэгт бүлэглэлүүд нийслэл хот Кабулд энгийн номхон иргэд, түүний дотор CARE Интернэшнл тусламжийн байгууллагыг онилсон харгис довтолгоо үйлдсээр байгаа нь дайны гэмт хэрэг юм.

Бүс нутагт хямрал мөргөлдөөн гүнзгийрч, аюулгүй байдал алдагдаж байгаа нь дэлхий нийтийн дүрвэгсдийн хямралыг даамжрууллаа. Сая сая хүн орон гэрээ орхихоос аргагүйд хүрч, амь насанд аюултай нөхцөл байдалд дүрвэгч, орогнол эрэгч болон хувирч байна. Олон хүн аюултай нөхцөлд гарах гарцгүй хашигдаж, хүний эрхийн бусад зөрчилд өртөх эрсдэлд ороод байна. Австрали, Тайланд зэрэг улсын Засгийн газрууд хүмүүсийг хүний эрхийн зөрчилд өртөх эрсдэлтэй улсууд руу буцаан илгээж, байдлыг улам хүндрүүлжээ.

Корпорациуд хүний эрхийг өөрсдөө зөрчих буюу хамтран үйлдэгч болох нь элбэг юм. Өмнөд Солонгосын Засгийн газар хувийн компаниудад үйлдвэрчний эвлэлүүдийг хориглохыг зөвшөөрсөн бөгөөд хортой бодисын улмаас эрүүл мэнд, амь нас хохирсон асуудлын талаар

хожимдож арга хэмжээ авсан. Энэтхэг улсад АНУ-д төвтэй Dow Chemical компани түүний салбар болох Union Carbide корпораци 1984 онд хорт хий алдагдсанаас учирсан гамшигтай холбоотой эрүүгийн хэргийг хэлэлцэхээр Бопал хотод болсон шүүх хуралд ирж оролцоогүй.

Ази Номхон далайн бүс нутаг цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн чиг хандлагаас хоцорсон хэвээр байна. Хэдийгээр бодит тоо баримтыг төрийн нууц хэмээн нууцалдаг ч Хятад улс дэлхий дээр хамгийн олон хүн цаазалдаг орон юм. Пакистан улс 2014 онд цаазаар авах ялын гүйцэтгэлд тавьсан мораторийг цуцалснаас хойш 400 хүнийг цаазаар аваад байна. Тэдгээр хүмүүсийн зарим нь гэмт хэрэг үйлдэх үедээ насанд хүрээгүй, оюуны хомсдолтой байсан бөгөөд заримыг нь шударга бус шүүх хурлаар ял оноож, цаазаар аваачсан байна. Япон улсад цаазын ялын гүйцэтгэл нууц хэвээр байна. Мальдив улсын эрх баригчид 60 жил түдгэлзүүлээд байсан цаазаар авах ялын гүйцэтгэлийг сэргээхээр заналхийлэв. Филиппин улсад цаазаар авах ялыг сэргээх хуулийн төслийг парламентад өргөн бариад байна. Эерэг мэдээ гэвэл Науру улс бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан 103 дахь улс боллоо.

Энэ бүс нутагт гарсан томоохон өөрчлөлтийн нэг нь 2015 онд Ардчиллын төлөөх Үндэсний Лиг нам сонгуульд ялсны дараа Мьянмарын хагас иргэний Засгийн газарт Аун Сан Су Чи өөрт нь зориулан бий болгосон де факто удирдагчийн үүргийг гүйцэтгэх болсон явдал юм. Шинэ Засгийн газар хүний эрхийг сайжруулах арга хэмжээ

авч байгаа боловч хагас зуун жилийн турш цэргийн дарангуйлал тогтож байснаас үүдэлтэй ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Цэргийн эрхтнүүдийн нөлөө хүчтэй хэвээр байгаа бөгөөд гол яамд болон парламентын суудлын 25 хувийг хяналтдаа байлгаж байна. Мьянмарт болж байгаа хямрал үргэлжилсээр байгаа бөгөөд рохингя иргэдийн хувь тавилан, шилжин нүүсэн иргэдэд үзүүлэх хүмүүнлэгийн тусламж, хүний эрх зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх болон бурангуй хуулийг өөрчлөн шинэчлэх чиглэлээр ахиц гарсан зүйл бага байна.

Филиппин улсын ерөнхийлөгч Родриго Дутертегийн засаглалын үед төрийн дэмжлэгтэй хүчирхийлэл, хууль бус аллага өргөн хүрээнд үйлдэгдэх болсон. Хар тамхины хэрэгт холбогдсон хүмүүсийг зэрлэгээр нухчин дарж, “Хар тамхины эсрэг дайн” нэрийн дор 6000 гаруй хүн амь насаа алдаад байна.

2 дугаар сард Фижи улсад болсон хөнөөлт Уинстон циклон салхи тус улсын дэд бүтэц чанарын шаардлага хангахгүй байгааг харуулсан бөгөөд орон гэр нь нурсны улмаас 62000 хүн шилжин суурьшсан. Тусламж түгээхдээ зарим нэг бүлгийг ялгаварлан гадуурхаж, барилгын материал дутагдалтай байсан нь тусламж хамгийн их шаардлагатай хүмүүст хүндээр тусав.

5 дугаар сард Шри Ланка улс Хүчээр сураггүй болгохын эсрэг олон улсын конвенцийг соёрхон батлав. Тус улс үндэсний хууль тогтоомждоо хүчээр сураггүй болгохыг гэмт хэрэг гэж оруулах эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Фижи улс Эрүүдэн шүүхийн

эсрэг НҮБ-ын конвенцид тайлбар хийж, соёрхон баталсан боловч эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр зүй бус харьцах явдалд хариуцлага хүлээлгэхэд үндсэн хуулийн халдашгүй байдал болон улс төрийн хүсэл зориг дутмаг байдал саад болж байна.

## **ЗҮҮН АЗИ**

### **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД**

Зүүн Азид хүний эрхийн хамгаалагчид зохион байгуулалттай халдлагад өртөн, эрх баригчидтай сөргөлдсөн асуудлыг иргэний нийгэм гаргаж тавих орон зай хумигдлаа.

Хятад улсад Ши Жинпиний удирдлага дор хүний эрхийн хамгаалагч, хуульч, сэтгүүлч, идэвхтнүүдийг байнга айлган сүрдүүлэх, дарамтлах, түүний дотор дур зоргоор баривчлах, эрүүдэн шүүх болон зүй бусаар харьцах явдал үргэлжилсээр байна. Баривчлагдсан хүмүүсийн гэр бүлийн гишүүд ч гэсэн цагдаагийн хяналт, айлган сүрдүүлэлтэд өртөж, чөлөөтэй зорчих эрх чөлөөгөө хязгаарлуулдаг. Эрх баригчид “тогтоосон байршилд оршин суугчдыг мөшгин хянах” явдлыг нэмэгдүүлснээр цагдаагийн байгууллагад хувь хүмүүсийг албан ёсны цагдан хорих тогтолцооноос гадуур, өмгөөлөгчөө өөрөө сонгож авах буюу гэр бүлтэйгээ уулзах эрхгүйгээр 6 сар хүртэл хорих эрх олгосон. Тэрчлэн хоригдлуудыг хүчээр “буруугаа хүлээсэн мэдэгдэл” телевизээр хийлгэх явдал өссөн. Эрх баригчид мянга мянган цахим хуудсыг хаасан хэвээр байна. Хятад улсын Гуандон муж ажилчид, хөдөлмөрийн эрхийн идэвхтнүүдийг нухчин дарж, “үндэсний аюулгүй

байдал” гэдгээр шалтаглан өмгөөлөгч авах боломжийг нь хаах нь түгээмэл байна.

Хятадын Засгийн газар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нэрийдлээр хууль тогтоомж батлан гаргаад “хорлон сүйтгэх ажиллагаанд турхирсан”, “төрийн нууц задруулсан” зэрэг маш бүрхэг тодорхойлсон гэмт хэргийг өөрөөр сэтгэгчдийг дуугүй болгох, хүний эрхийн хамгаалагчдыг нухчин дарахад ашиглаж байна. Гадаадын ТББ-ын менежментийн тухай шинэ хуулийг хүний эрхийн хамгаалагчид ба ТББ-уудыг айлган сүрдүүлэх, мөрдөн шалгахад, Цахим аюулгүй байдлын тухай шинэ хууль нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууцтай байх эрхэд халтайгаар ашиглагдах вий гэсэн айдас байна.

Гэхдээ идэвхтнүүд шинийг эрэлхийлсээр байна. 1989 оны 6 дугаар сарын 4-нд Тяньанмэний бослогыг дарсны 27 жилийн ойг тэмдэглэсэн хэмээн 4 хүний эрхийн хамгаалагчийг баривчилсан. Тэд олны дуртай нэг архины сурталчилгааг “Бүү март. Найм Архи Зургаа Дөрөв” гэсэн гарчигтайгаар “танктай эр”-ийн зурагны хамтаар тавьсан нь хятад хэлний төстэй дуудлагатай үгийг ашиглан алдарт үйл явдлыг сануулсан хэрэг байв. Хаах хүртэл энэ нь нийгмийн сүлжээнд нэлээд түгжээ.

10 дугаар сард уйгур ба хан үндэстний хэлцлийг дэмжигч Уйгурын нэрт сэхээтэн Илхам Тохти эрсдлийг эс хайхран тууштай зүтгэснийхээ төлөө 2016 оны Мартин Энналсын Хүний эрхийн хамгаалагчдын шагнал хүртсэн. Одоогоор тэрээр “салан тусгаарлах” хэргээр бүх насаараа хорих ял эдлэж байгаа юм.

Хонконгт оюутан Жошуа Вон, Алекс Чоу, Натан Ло нарт 2014 онд ардчиллыг дэмжигчдийн Шүхэр хөдөлгөөнийг эхлүүлсэнтэй нь холбогдуулан “хууль бус жагсаал цуглаанд” оролцсон хэргээр ял сонгосон.

Хойд Солонгост харгис хэлмэгдүүлэлт үргэлжилж, хүний эрхийг бүхий л талаар зөрчиж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд туйлын хатуу хязгаарлалт тавьдаг бөгөөд хараат бус хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд гэж байхгүй. 120000 гаруй хүнийг лагерьт хорьж байгаа ба тэднийг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцаж, албадан хөдөлмөр эрхлүүлж байна. Ким Жон-ун 2011 онд засгийн эрхэнд гарснаас хойш төрийн хяналт, дарангуйлал, сүрдүүлэлт эрчимжсэн. Харилцаа холбооны технологийг хатуу хянаж байгаа нь ард иргэдийг тусгаарлах, хүний эрхийн ноцтой зөрчлийг нуух зорилготой. Гадаадад байгаа хайртай хүмүүстэйгээ гар утсаар ярьж байгаад баригдсан хүмүүсийг улс төрийн хорих лагерь буюу шоронд хорьсоор байна.

Хөрш Өмнөд Солонгос улсад тайван замаар жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж, хэрэг үүсгэх болсон нь хүний эрхийн чиглэлд гарсан ухралт юм. Эрх баригчид нийгмийн хэв журмыг хамгаалах нэрийдлээр мэдээ сурвалжлага түгээхэд хөндлөнгөөс оролцох, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах зэргээр хэвлэлийн эрх чөлөөг боомилох болсон.

Өмнөд Солонгосын Үндэсний Ассемблей терроризмтой холбоотой гэж сэжиглэгдсэн хүмүүсийн харилцаа холбоог

мөшгин хянах, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг цуглуулах эрхийг өргөжүүлсэн Терроризмын эсрэг хуулийг батлан гаргав.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд ихэвчлэн хувь тоглогчдын зүгээс сүрдүүлэг, дарамт, заналхийлэлд байнга өртсөөр байна.

Тайвань улсын шинэ Засгийн газар 2014 онд Тайвань-Хятад улсын хоорондох худалдааны гэрээг эсэргүүцсэн “Наран цэцгийн хөдөлгөөн” хэмээх оюутнуудын удирдсан жагсаал цуглаанд оролцсон 100 гаруй жагсагчдын эсрэг үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгосон нь нааштай алхам юм. Ерөнхий сайд Лин Чуан өмнөх Засгийн газар жагсагчдын эсрэг хэрэг үүсгэсэн нь “улс төрийн шалтгаантай байсан” хэмээн мэдэгдсэн.

## **ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС**

Япон улс орогнол эрсэн өргөдлийн дийлэнх хувьд татгалзсан хариу өгсөөр байна. Өмнөд Солонгосын цагаачлалын алба 100 гаруй орогнол эрэгчийг олон сарын турш Инчөоны олон улсын нисэх буудалд саатуулсан бөгөөд шүүхээс тэдний дунд байсан 28 Сири эрсийг суллаж, орогнол хүсэх эрхтэй хэмээн шийдвэрлэсэн. Египет зэрэг бусад орноос ирсэн олон арван орогнол эрэгчид нисэх буудалд, хүнд нөхцөлд саатуулагдсаар байна.

## **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

Япон улсын парламент ялгаварлан гадуурхалтыг дэмжсэн жагсаал, цуглаан нэмэгдсэнтэй холбогдуулан анх удаа гадаад улсын гаралтай оршин суугчид болон тэдний үр удмын эсрэг үзэн ядалт буюу үзэн ядах үг яриаг дэвэргэхийн

эсрэг хууль батлан гаргасан. Уг хуулийг хэтэрхий явцуу бөгөөд ял шийтгэлийн талаар тусгаагүй гэж шүүмжилдэг. Тус улсад бэлгийн болон үндэстний цөөнхийн эсрэг ялгаварлан гадуурхалт түгээмэл байдаг.

Хятад улсад шашин шүтэх эрх чөлөөг байнга зөрчиж байна. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, экстермизмийг таслан зогсоох нэрийдлээр шашны зарим зан үйлийг хянах, хязгаарлах төрийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулахаар санал болгоод байна. Хэрэв уг нэмэлт, өөрчлөлт батлагдвал төрөөс хүлээн зөвшөөрөөгүй Христийн шүтлэгтнүүд, Төвдийн буддын шашинтнууд болон Уйгурын мусульманчуудын шашин шүтэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдах болно. Хятадын Засгийн газар Шинжан Уйгурын ӨЗО-нд уйгур үндэстний зохиолчид болон уйгар хэл дээрх цахим хуудасны редакторуудыг баривчилсан.

Төвд үндэстнүүд байнгын ялгаварлан гадуурхалтад өртөж, үзэл бодол, ухамсартай байх, шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх нь хязгаарлагдсаар байна. Төвдийн блогч Друкло “салан тусгаарлах явдлыг өөгшүүлсэн”, түүнчлэн шашны эрх чөлөө, Далай ламын тухай онлайн пост бичсэн хэргээр 3 жил хорих ял сонссон. Хятадын Засгийн газар Шинжан Уйгурын ӨЗО-нд шашин шүтэх эрх чөлөөг зөрчиж, зөвшөөрөлгүй шашны цуглаануудыг хүчээр тараасаар байна.

## ӨМНӨД АЗИ

### ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Өмнөд Ази даяар хүний эрхийн хамгаалагчид хэд хэдэн хэлбэрээр хүний эрхийн зөрчлийн бай болсоор байна. Засгийн газрууд онлайнар үзэл бодлоо илэрхийлэх явдлыг хяналтдаа байлгах зорилгоор хууль тогтоомжийг чангатгаж байна.

Энэтхэг улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах, шүүмжлэгчдийг дуугүй болгохын тулд дарангуй хууль тогтоомжийг ашигласаар байна. Гадаадын хандивыг зохицуулах тухай хуулийг иргэний нийгмийн байгууллагууд гадаадаас санхүүжилт авах явдлыг хязгаарлах, ТББ-уудыг дарамтлах зорилгоор ашиглах болсон. Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн үед үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зорилгоор Британичуудын ашиглаж байсан үймээн самуунд турхирах тухай хуулийг Засгийн газрыг шүүмжлэгчдийг дарамтлах зорилгоор хэрэглэв. Хүний эрхийн хамгаалагчид сүрдүүлэг, халдлагад өртсөөр байна. Уттар Прадеш мужид хууль бус хөрс олборлолтын талаар бичсэнийх нь төлөө сэтгүүлч Карун Мишрагийн амь насыг зэвсэгт этгээдүүд хөнөөсөн. Бичсэн зүйлсийнхээ төлөө улс төрч лидерүүдийн заналхийлэлд өртөөд байсан сэтгүүлч Раждео Ранжан мөн буудуулан нас баржээ.

Жамму ба Кашмирт аюулгүйн хүчнийхэн жагсагчдын эсрэг шаардлагагүй байхад хүч хэтрүүлэн хэрэглэлээ. Жамму ба Кашмирт Засгийн газар 2 сарын турш хөл хорио тогтоосон. Энэ хугацаанд суурин утас, гар утас, интернетийн үйлчилгээг зогсоосон нь хүний

эрхийг өргөн хүрээнд зөрчсөн хэрэг бөгөөд оршин суугчид яаралтай эмнэлгийн тусламж авч чадахгүйд хүрсэн юм.

Пакистанд төрийн ба төрийн бус тоглогчдын зүгээс хэвлэл мэдээллийн ажилтныг хулгайлах, дур зоргоор баривчлах, хорих, айлган сүрдүүлэх, амь насыг нь хөнөөх зэргээр, дарамтлаж байна. Нийслэл Исламабад хот дахь АРИ телевизийн байранд тэсрэх бөмбөгтэй халдлага үйлдсэн нь хэвлэл мэдээллийн ажилтнууд болоод үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг өгч буй олон цохилтын нэг жишээ юм. Хэргийн газарт уг халдлагыг Исламын улсын хамсаатан зэвсэгт бүлэглэл үйлдсэн гэсэн зурагт хуудас үлдээсэн байжээ.

Шри Ланка улсад сураггүй алга болсон шог зураач Прагит Экналигодагийн эхнэр Сандхя Экналигода цагдаагийн байгууллага түүний нөхрийн сураггүй алга болсон хэрэгт холбогдуулан 7 сэжигтэн, түүний дотор цэргийн тагнуулын ажилтнуудыг тогтоосноос хойш байнгын заналхийлэл, сүрдүүлгийн дор амьдарч байна. Тийнхүү сүрдүүлэхдээ нөхрийнх нь хэргийг шүүж буй шүүхийн гадаа жагсаал цуглаан хийх, түүнийг Тамил Иламыг чөлөөлөх барс бүлэглэлийг дэмжигч гэсэн зурагт хуудсыг тарааж байна.

Бангладеш улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хумигдсаар байгаа бөгөөд эрх баригчид хараат бус хэвлэл мэдээлэл болон шүүмжлэлт дуу хоолойг үл хүлцэх нь нэмэгдлээ. Хүний эрхийн нөхцөл байдал дордохын зэрэгцээ хэд хэдэн сэтгүүлчийг дур зоргоор баривчлан хорьж, нийгмийн сүлжээн дэх шүүмжлэлийг таслан

зогсоох зорилгоор баталсан хуулиар тайван замаар өөр үзэл илэрхийлэгчдийг нухчин дарж байна. Ерөнхий сайдыг фэйсбүүкээр шүүмжилсэн хэргээр оюутан идэвхтэн Дилип Ройг хорьсон бөгөөд эрх баригчид үзэл бодлоо тайван замаар илэрхийлсэн өөрсдөд нь таалагдахгүй байгаа хүмүүсийг сүрдүүлэх, шийтгэх зорилгоор ашигладаг, маш бүрхэг томъёололтой Мэдээлэл ба харилцаа холбооны технологийн тухай хуулийн дагуу 14 жилийн ял авч магадгүй байгаа юм.

Мальдив улсад сүүлийн жилүүдэд хүний эрхэд халдах явдал өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд тус улсын Засгийн газар жагсаал, цуглаан хийхийг дур зоргоороо хязгаарлах замаар үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд халдах нь эрчимжсэн. Эрх баригчид “нэр төр гутаасан” үг яриа, бусад үйлдлийг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомжийг улс төрийн өрсөлдөгчид, хүний эрхийн хамгаалагчид болон сэтгүүлчдийг дуугүй болгоход ашиглаж байна.

### **ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС**

Хямрал мөргөлдөөн үргэжилж байгаагийн улмаас Афганистан улсаас дүрвэсэн хүмүүсийн тоо дэлхийд 2-р байр эзэлж байна. Зөвхөн Пакистан ба Иранд 2 сая гаруй афган дүрвэгч байгаа бөгөөд олон тооны дүрвэгч Европын холбоонд хүрэхийг чармайж байна. ЕХ ба Афганистаны хооронд байгуулсан тохиролцоогоор Афганистан улс ЕХ-нд орогнох эрх олж авч чадаагүй афган иргэдийг буцаан авах үүрэг хүлээдэг. Гэвч тогтворгүй байдал үргэлжилсээр байгаагийн улмаас олон дүрвэгч, орогнол эрэгчид орон гэртээ сайн

дураараа, аюулгүй буцан ирэх боломжгүй байна.

Хэдийгээр Афганчууд Европ руу амь өрсөн дүрвэхээр явж байгаа талаар хэвлэл мэдээллээр шуугидаг ч дийлэнх хүмүүст тийнхүү дүрвэх санхүүгийн боломж байдаггүй. 2016 онд орон гэрээсээ дүрвэн дотооддоо шилжин суурьшсан хүний тоо 1,4 сая болсон нь өмнөх 3 жилтэй харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Мөнхүү 3 жилийн хугацаанд Афганистан улсад үзүүлэх олон улсын тусламж хоёр дахин багассан бөгөөд олон улсын зэвсэгт хүчин тус улсаас гарснаар хандивлагчдын анхаарал өөр зүгт хандах болсон. Толгой хоргодох газар, хоол хүнс, ус, эмнэлгийн үйлчилгээгээр дутмаг, ачаалал нь хэтэрсэн дүрвэгсдийн хуаранд аймшигтай нөхцөлд зовж зүдэрч байгаа хүмүүсийн хувь тавилан мартагдахад хүрээд байна.

Пакистан дахь афган дүрвэгсдийн хувьд байдал ихээхэн бүүдгэр бөгөөд тус улсын Засгийн газар оны сүүлээр бүртгэлийн хугацаа нь дуусах 1,4 сая дүрвэгсдийг хүчээр буцаахаар төлөвлөж байгаа нь орчин үеийн түүхэн дэх хамгийн их тоо юм. Эрх баригчид дүрвэгсдийг Афганистан руу буцаах биелэгдэх боломжгүй хэд хэдэн эцсийн хугацааг тогтоосон бөгөөд түүнийгээ дуртай дургүй сунгасан. Энэ нь цагдаа болон албан хаагчдын зүгээс ирэх дарамт шахалтыг нэмэгдүүлсэн бөгөөд дүрвэгсэд хуарандаа тодорхойгүй нөхцөлд гарах гарцгүй үлдсэн.

Түүнчлэн, Пакистан улс олон улсын буцаан шилжүүлэхгүй байх зарчмыг зөрчин олон афган дүрвэгчийн эрх нь ноцтой зөрчигдөх эрсдэлд оруулсан. Тухайлбал, шүүхээс Шарбат Гулаг олон арван

жил очоогүй, хүүхдүүд нь хэзээ ч очиж үзээгүй улс руу буцаахаар шийдвэрлэсэн нь Пакистан улс Афган дүрвэгсдэд хэрхэн хандаж байгаагийн тод жишээ юм. Тэрээр 1985 оны Нэшнл Географик сэтгүүлийн хавтсанд зураг нь тавигдсан алдарт “Афган охин” бөгөөд олон арван жилийн турш дэлхийн хамгийн алдартай дүрвэгч, Пакистан улсын өгөөмөр сэтгэлийн бэлгэ тэмдэг болж байсан билээ.

### **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

Энэтхэгт мянган мянган хүн Далит үндэстний цөөнхийг ялгаварлан гадуурхаж, хүчирхийлж байгаагийн эсрэг жагслаа. Засгийн газар эдийн засгийн өсөлтийг хурдасгах ажиллагаа явуулахдаа эмзэг бүлгийн иргэдийн эрхийг үл тоомсорлох нь олонтаа байна. Олон сая хүн хөдөлмөрийн хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцэж жагсав. Олон хотод хар арьстнууд дайралт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртсөөр байна. Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэг өссөөр байгаа бөгөөд гэмт хэрэгтнүүд ял шийтгэлгүй хоцорч, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд системтэй ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Тус улсад олон нийтийн газар үйлчлүүлэгчид олохыг гэмт хэрэгт тооцох болсон нь секс ажилчдын эрх өргөн хүрээнд зөрчигдөхөд хүргэлээ.

Энэтхэгийн Эрүүгийн хуулийн 377-р зүйлээр Дээд шүүхэд зарга үүсгээд байгааг эс харгалзан ижил хүйстний харилцан тохиролцсон бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон хэвээр байна. Тус улсын Засгийн газар трансгендер хүмүүсийн эрхийн талаар цоорхойтой хуулийн төслийг



дэмжсэн бөгөөд идэвхтнүүд уг хуулийн төсөлд трансжендер хүмүүсийн тухай алдаа мадагтай тодорхойлолт оруулснаас гадна ялгаварлан гадуурхалтын эсрэг зүйл заалт дутуу дулимаг байгааг шүүмжилж байгаа юм.

Бангладеш улсын эрх баригчид блогчид, шашингүйн үзэлтнүүд, гадаадын иргэд болон лесбиян, гей, бисексуал, трансжендер, интерсекс (ЛГБТИ) хүмүүсийн эсрэг гарсан халдлагуудын эсрэг оройтсон ч гэсэн арга хэмжээ авч, 15000 хүнийг баривчилсан ч тийм төрлийн халдлага, аллага ар араасаа цуварсаар байна. Тус улсын Засгийн газар хариуцлага хүлээх ёстой хүмүүсийг дур зоргоороо баривчлах буюу нууцаар хорьж байгаа үүргээ бүрэн дүүрэн биелүүлэхгүй байгаа хэрэг юм. Тайван замаар тэмцдэг идэвхтнүүдийг хангалттай хамгаалж чадахгүй байгаа нь ЛГБТИ сэтгүүлийн редактор Ксулхаз Маннан болон түүний найз Танай Мажумдар нарын амь насыг зэрлэгээр хөнөөсөн гэмт хэрэгтнийг нь тогтоож чадаагүй зэрэг олон халдлагаар илэрч байна. Ижил төрлийн аюул заналд өртөөд байгаа хүний эрхийн идэвхтнүүд цагдаагийн байгууллага хангалттай хамгаалалт үзүүлж чадахгүй талаар өгүүлсэн бол зарим хүмүүс хэрэгт холбогдох, дарамтад өртөнө хэмээн эмээж цагдаад хандахыг хүсдэггүй.

Шри Ланка улсад ЛГБТИ хүмүүс халдлага, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртсөөр байна. Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний дотор цэргийн албан хаагчдын үйлдсэн хүчингийн гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэх нь олон байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг дорвитой

арга хэмжээ авч чадахгүй байна. Тамилчууд цагдаагийн байгууллага тэднийг Тамил Иламыг чөлөөлөх барс бүлэглэлтэй холбоотой хэмээн үндэс угсаагаар нь сэжиглэж, мөшгин хянаж, дарамталж байгаа талаар гомдол гаргасаар байна. НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хороо Шри Ланка улсын Терроризмээс сэргийлэх тухай хуулийг тамилчуудын эсрэг хэт түлхүү хэрэглэж байгааг тогтоосон. Христийн болон Исламын шашинтнуудын эсрэг хатуу чиг шугам баримталдаг Синхала Буддын шашны улс төрийн бүлэг болон бусад этгээдүүдийн зүгээс дарамт шахалт, заналхийлэл, халдлага үйлдсээр байгаа бөгөөд цагдаагийн байгууллага арга хэмжээ авахгүй байх буюу шашны цөөнхийг өрсөлдөгчдөө хүчирхийлэлд турхирсан хэмээн буруутгадаг.

## **ЗҮҮН ӨМНӨД АЗИ БА НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ**

**ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД**  
Камбож, Малайз, Тайланд, Вьетнам зэрэг олон оронд тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг гэмт хэрэгт тооцох хуучин, шинэ хуулийг ашиглан хүний эрхийн хамгаалагчдыг заналхийлэх нь ихэслээ.

Тайландад 2014 онд цэргийн эргэлт гарснаас хойш тайван замаар өөр үзэл бодол илэрхийлэгчдийг нухчин дарсаар байгаагийн улмаас эрх баригчдыг шүүмжлэх зоригтон улам цөөрч. Хүний эрхийн зөрчлийн талаар ярьсныхаа төлөө буюу эмзэг

бүлгийнхнийг дэмжсэнийхээ төлөө хүний эрхийн хамгаалагчид нэр төр гутаасан хэргээр эрүүгийн хэрэгт татагдаж байна. Засгийн газар үндсэн хуулийн төслийн тухай хэлэлцүүлгийг хаан, Фэйсбүүкээр төслийн талаар санал бодлоо илэрхийлсэн арав гаруй хүнийг баривчлан, заримд нь эрүүгийн хэрэг тулгасан. Тэд Засгийн газрын баталсан шинэ захирамжийн дагуу 10 жил хүртэлх ял сонсох магадлалтай юм.

Камбож улсад 2017/2018 онд явагдах сонгуулийн өмнө үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд халдах явдал эрчимжсэн бөгөөд эрх баригчид эрүүгийн шүүхийн тогтолцоог гуйвуулан ашиглах нь ихэссэн. Шүүмжлэгчдийг дуугүй болгох зорилгоор аюулгүйн хүчнийхэн иргэний нийгмийн байгууллагуудыг дарамталж, шийтгэж байна. Хүний эрхийн хамгаалагчдыг тайван замаар ажлаа хийснийх нь төлөө заналхийлж, баривчилж, хорьж байгаагийн зэрэгцээ улс төрийн сөрөг хүчнийг онилон, идэвхтнүүд ба албан тушаалтнуудыг нь шударга бус шүүхээр оруулан ял оноож байна. Эрх баригчид тайван жагсаал цуглаанд саад учруулсан хэвээр байна.

Малайз улсад тайван замаар өөр үзэл бодол илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг боогдуулахын тулд үндэсний аюулгүй байдлын тухай болон бусад хууль тогтоомжийг өргөн хэрэглэж байна. Томоохон авлигын талаарх мэдээллийг ил болгосон шүгэл үлээгч парламентын гишүүн Рафизы Рамлид 18 сар хорих ял оноосон. Malaysiakini хэмээх мэдээллийн сайтын сэтгүүлчид сайн дурын эргүүлийнхний сүрдүүлэгт өртсөн.

Вьетнам улсад хүний эрхийн

хамгаалагчид мөн л заналхийлэл, халдлагад өртсөөр байна. Улс төрийн хоригдлуудыг шорон, хорих газруудад хорьсоор байгаа бөгөөд тэднийг сураггүй алга болгох, эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр зүй бус харьцах, түүний дотор цахилгаан ашиглан эрүүдэх, зодох, удаан хугацаагаар, зарим тохиолдолд тас харанхуй бөгөөд чив чимээгүй орчинд ганцаарчлан хорих буюу эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж байна.

Түүнчлэн Вьетнамын эрх баригчид тайван замаар жагсагчдыг нухчин дарах даалгавар өгсөн. 5 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама тус улсад айлчлах үеэр эрх баригчид тайван замаар үзэл бодлоо илэрхийлсэн идэвхтнүүдийг баривчилж, айлган сүрдүүлсэн байна.

Мьянмар улсын Ардчиллын төлөө Үндэсний Лиг намын удирдсан шинэ Засгийн газар идэвхтнүүд ба хэвлэл мэдээллийн ажилтнуудыг онилсон бурангуй хууль тогтоомжийг өөрчлөх анхны алхмыг хийсэн. Гэвч 11 дүгээр сард хэвлэл мэдээллийн хоёр ажилтныг Засгийн газрын авлигын тухай нийтлэл бичсэнийх нь төлөө “онлайнгаар нэр төр гутаасан” хэрэгт сэжиглэн баривчилсан нь энэ талаар хийх зүйл их байгааг харуулсан явдал болов.

Зүүн Тимор дахь аюулгүйн хүчнийхэн хууль бусаар хүмүүсийг хөнөөж, эрүү шүүлт тулгах буюу бусад хэлбэрээр зүй бус харьцаж, дур зоргоороо баривчилж, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг дур зоргоороо хязгаарласаар байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дур зоргоор хязгаарлалт тогтоож, сэтгүүлчдийг торгож, шоронд хорих зэрэг таагүй зүйлст Фижи улсын хэвлэл мэдээлэл өртөөд байна.

Сингапур улсын блогчид, өөр үзэл бодолтнууд дарамт шахалт, мөрдлөг мөшгилтөд өртсөөр байна.

Үл мэдэгдэх зэвсэглэсэн этгээдүүд, зэвсэгт бүлэглэлийнхэн Филиппин улсын хүний эрхийн хамгаалагчид болон сэтгүүлчдийг онилж, амь насыг нь хөнөөсөн.

## **ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС**

Австрали улс Науру болон Папуа Шинэ Гвинейн Манус арал дээрх цагаачлалын өргөдлийг шийдвэрлэх хүний эрхийг зөрчсөн тогтолцоогоо ашигласан хэвээр байна. Австрали улсын Наурутай хийсэн дүрвэгсдийг шилжүүлэн өгөх гэрээ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж байгаагаас гадна дүрвэгсэд ба орогнол эрэгчид үнэн хэрэгтээ задгай шоронд түгжигдээд байгаа юм. Хэдийгээр эдгээр хүмүүс шоронд хоригдоогүй албан ёсоор дүрвэгсэд хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн ч гэсэн Номхон далайн алслагдсан Науру арлыг орхин явах боломжгүй, бусдаас тусгаарлагдаад байна.

Австралийн засгийн газрын дүрвэгсэд ба орогнол эрэгчдийн өргөдлийг Науру аралд шийдвэрлэх бодлого нь хүмүүсийг зовоож шаналгах зорилгоор зориудаар үл хайхарсан, харгис тогтолцоо бөгөөд олон улсын эрх зүйгээр эрүү шүүлт гэж тооцогдохуйц байна. Уг тогтолцоо нь хамгаалалтыг хамгийн бага түвшинд, хор хохирлыг хамгийн их түвшинд байлгахгаар хийгдсэн нь дэлхийн хамгийн эмзэг хүмүүсийг аюулаас зугтан Австрали улсад ирэхээс сэргийлэх зорилготой юм.

Науру дахь дүрвэгсэд ба орогнол эрэгчдийн дунд сэтгэцийн өвчин болон өөрсдийгөө гэмтээх явдал түгээмэл байна. Ираны дүрвэгч Омид Масумали өөрийгөө шатаасны улмаас нас барсан. Бусад хүн, түүний дотор хүүхдүүд эрүүл

мэндийн хангалтгүй үйлчилгээ, байнгын сэтгэл санааны болон бие махбодын доромжлол, дайсагнал, баривчлах болон хорих явдалд өртсөөр байгаа бөгөөд ийм төрлийн зөрчил үйлдэгчдэд ял шийтгэл хүлээлгэхгүй өнгөрүүлсээр байна.

Австрали улс Науру болон Манус арал дахь төвүүдээ хаахаас татгалзсан бөгөөд тэнд гацаад байгаа хүмүүст Австралийн виз олгохоос бүрмөсөн татгалзах тухай хууль батлахаар төлөвлөж байгаа нь олон улсын эрх зүйг зөрчсөн шударга бус үйлдэл юм.

Австрали улс уг тохиролцоог үргэлжлүүлэхээ татгалзсан ч Шинэ Зеланд тус улстай 2013 онд хийсэн, жил бүр 150 дүрвэгчийг Науру болон Манус арлаас шилжүүлэн суурьшуулах гэрээгээ олон нийтэд хандан дахин нотолсон.

Малайзад даац нь хэтэрсэн цагаачдыг хорих төвүүдийн нөхцөл маш муу байна. 2015 оны 5 дугаар сард эрх баригчид тэднийг хүлээж авахыг зөвшөөрөхөөс өмнө 1000 хүн, түүний дотор 400 гаруй рохингя иргэд Малайз улсын эрэг дагуу хаягдаж, маш хүнд нөхцөлд бүтэн жил гаруй хоригдоод байв. 6 дугаар сард рохингя иргэдийн дийлэнх хувийг сулласан ба зарим нь шилжин суурьшаад байна.

Тайланд улсад дүрвэгсэд ба орогнол эрэгчдийг хүлээн авах хууль тогтоомж, дүрэм журам байхгүйгээс олон хүнийг дур зоргоор хорьж, хүний эрхийг нь зөрчихөд хүргэж байна. Тус улсын хуульд тодорхой зохицуулалт байхгүйгээс дүрвэгсэд болон орогнол эрэгчид, түүний дотор хүүхдүүдийг Цагаачлалын тухай хуулийн дагуу хууль бус цагаачид хэмээн тооцож, олон улсын стандартыг тэр бүр хангаж чадахгүй цагаачдыг хорих төвүүдэд тодорхойгүй хугацаагаар хорьж байна.

Мьянмар улсаас завиар дүрвэн ирсэн олон тооны рохингя хүмүүс цагаачдыг хорих төвүүдэд 2015 оноос хойш хоригдсоор байгаа юм.

Индонезийн эрх баригчид Аче мужид хүмүүсийг сүрдүүлэх бүдүүлэг тактик хэрэглэж Шри Ланкаас ирсэн 40 гаруй Тамил орогнол эрэгчдийн амь насанд аюул учруулсан. Тэнд төрөх дөхсөн жирэмсэн эмэгтэйдээс гадна 9 хүүхэд байсан бөгөөд тэдэн рүү олон улсын эрх зүйг зөрчин хий буудаж, тэнгис рүү буцаана хэмээн заналхийлсэн байна.

### **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

10 дугаар сард Мьянмар улсын хилийн харуулын 3 цэгт халдлага үйлдэж, 9 цагдаагийн албан хаагчийн амь насыг хөнөөсөн хэргийн хариу болгож аюулгүйн хүчнийхний явуулсан залхаан цээрлүүлэх ажиллагаанаас зугтсан олон мянган рохингя хүмүүс хойд Ракине мужаас дүрвэлээ. Армийн толгойлсон аюулгүйн хүчнийхэн тосгоны иргэд руу гал нээж, олон зуун гэр байшинг шатааж, хүмүүсийг дур зоргоор баривчилж, охид эмэгтэйчүүдийг хүчирхийлжээ. Иргэдийг шөнийн цагаар гадагш гарахыг болон хүмүүнлэгийн байгууллагуудыг тус бүс нутагт нэвтрэхийг хориглосон. Энэ нь хойд Ракине мужид амьдран суудаг рохингя хүмүүсийг бүхэлд нь шийтгэж байгаа бөгөөд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгтэй дүйцэж магадгүй юм. Бангладеш улс руу хүмүүнлэгийн тусламж горилон очсон олон рохингя дүрвэгсэд ба орогнол эрэгчдийг Мьянмар улс руу буцаан хөөжээ.

Энэ нь рохингя хүмүүсийг системтэйгээр ялгаварлаж, хүний эрх, эрх чөлөө, тэр дундаа чөлөөтэй зорчих эрх чөлөөг нь хязгаарлаж байснаас үүдэлтэй юм. Түүнчлэн

өөр шашныг үл хүлцэх явдал байгаа бөгөөд өмнөх Засгийн газар сүүлийн хэдэн жил хүчирхийллийн гэмт хэргүүд, ялангуяа хэт үндэсний үзэлт буддист бүлэглэлүүдийн дэвэргэсэн мусулманчуудын эсрэг чиглэсэн хүчирхийллийг үр дүнтэй мөрдөн шалгаагүйн алдаа болсон.

Индонезийн эрх баригчид хүний эрхийг хамгаалахаас илүүтэй хатуу чиг шугам баримталсан шашны бүлгүүдэд илүүтэй санаа тавьж буй нь харагдсаар байна. Тухайлбал, нийслэл Жакарта хотын захирагч, Христийн шашинт, тус улсын хятад гаралтай цөөнхөөс анх удаа уг албан тушаалд томилогдсон хүнийг “Аллахыг доромжилсон” хэргээр мөрдөн шалгасан. Албан тушаалтнуудын өдөөн хатгасан, буруу ташаа бөгөөд төөрөгдүүлсэн мэдэгдлүүдээс болж ЛГБТИ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалт өссөн.

Папуа Шинэ Гвинейд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл газар авсан бөгөөд секс ажилчдыг зодох, хүчиндэх, шударгаар шүүлгэх боломж олголгүйгээр дур зоргоор баривчлах, хороох явдал их байна. Секс ажлыг хуулиар гэмт хэрэгт тооцдог, нийгмээс гадуурхдаг нийгэм, соёлын хэм хэмжээ зэрэгтэй холбоотойгоор тэд бараг хамгаалагдах боломжгүй байдаг.

НҮБ-ын Хүний эрхийн хороо болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо Шинэ Зеланд улс уугуул маори иргэдийн дунд эзлэх хоригдлуудын тоо болон хүүхдийн ядуурал, гэр бүлийн хүчирхийллийн түвшин өндөр байгааг шүүмжилсэн. Түүнчлэн тус улсад асуудлыг хүлээн зөвшөөрч, түүнийг шийдвэрлэх талаар хүчин чармайлт тавьж байгаа хэдий ч охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байна.

# ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2016 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Унгарын нийслэл Будапешт хотод Кипрт амьдардаг Сирийн иргэн Ахмед Х-г терроризмын хэрэгт буруутгаж шүүв. 2015 оны 9 дүгээр сард Унгарын хилийг гэнэт хаасны дараа цагдаа, дүрвэгсдийн хооронд үүссэн мөргөлдөөнийг зохион байгуулсан гэх ялыг түүнд тулгасан. Түүнийг шүүсэн явдал исламын шашинт орогнол эрэгсдийг терроризмын аюултай адилтган үзэж буй Засгийн газрын байр суурийг харууллаа. Дайны хөлд нэрвэгдсэн улс орноосоо дайжин ирсэн тэрээр настай эцэг эхдээ туслахаар хэрэг болсон газарт байсан юм. Мөргөлдөөний үеэр цагдаа руу чулуу авч шидсэн боловч олон гэрчийн мэдүүлснээр тэрээр ихэнхдээ цугласан олныг намжаахыг оролдож байсан аж. Үүнийг үл харгалзан, түүнд ял оноосон нь хүний эрхийг хамгаалах үйл хэрэгт Европ тив ухралт хийсний эмгэнэлтэй бөгөөд жихүүцэм дохио боллоо.

2016 онд популист хөдөлгөөн, санаа бодол ихээхэн дэлгэрэв. Бүс нутгийн улс төрчид гадаадын иргэдээс жийрхэх, аюулгүй байдал хангагдахгүй байна гэх нийтийг хамарсан сэтгэлгээнд хүлэгдэх боллоо. Улс төрийн элитүүд, Европын холбоо, цагаачлал, либерал мэдээллийн хэрэгсэл, ислам шашинтай хүмүүс, гадаадын иргэд, даяаршил, хүйсийн тэгш байдал, хэзээ хэзээнээс илүү терроризмын аюул зэрэг олон асуудал үүний бай болов. Польш,

Унгар зэрэг орнуудад популист улс төрчид ихэнхдээ засгийн эрхэнд гарсан боловч Европын баруун хэсэгт ийм улс төрчид түгшүүрт автсан улс төрийн намууд популист үзэл хандлагыг зээлдэн авч, бодлогодоо тусгахыг шахах болжээ. Үр дүнд нь эрх зүйт ёс доройтож, дүрвэгсэд, терроризмын хэрэгт сэжиглэгсэд, цаашлаад хүн бүрийн эрхийг хамгаалах явдал суларлаа.

Удаан хугацаанд эрх мэдлээ хадгалж буй хүчтэй удирдагчид эрх мэдлээ улам бэхжүүлэв. Тажикстан, Азербайжан, Туркменистанд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг сунгалаа. Оросын Украйнд явуулсан ажиллагаа, олон улсын тавцанд нөлөөгөө сэргээснээс үүдсэн нэр хүнддээ ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин дөрөөлж тухайлбал, дотооддоо иргэний нийгмийг боомилж байна. Өөр үзэл бодолтой хэсэг, улс төрийн сөрөг хүчнийг нухчин дарах явдал хуучин ЗХУ даяар амь бөхтэй оршоор байна.

Бүс нутагт хамгийн их үймээн дагуулсан үйл явдал Турк улсад өрнөлөө. Туркийн зүүн өмнөд хэсэгт хямрал мөргөлдөөн тасралтгүй гарч, хэд хэдэн удаа бөмбөг дэлбэрч, буудалцаан болж, 7 дугаар сард хүч түрэмгийлэн цэргийн эргэлт хийх оролдлого гарав. Эдгээрээс үүдэн Засгийн газар хүний эрхийг хамгаалахаас татгалздаг болов. Нэгэн цагт анд нөхөр байгаад эвлэршгүй дайсан болсон Фетхулла Гуленд бурууг

тохож, түүний үндэслэн байгуулсан хөдөлгөөнийг нухчн дарах ажиллагааг эрчимтэй явуулав. Ихэнх нь Гулений хөдөлгөөний гишүүд гэгдэх 90 000 орчим төрийн албан хаагчийг Засгийн газрын шийдвэрээр ажлаас нь халав. Дор хаяж 40 мянган хүн хоригдож байгаа бөгөөд тэднийг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцсан гэх мэдээлэл байна. Олон зуун хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагыг хааж, сэтгүүлч, эрдэмтэн, парламентын гишүүдийг барьснаар төрийн эргэлтийг дарах үйл ажиллагаа хэмжээ хязгаараасаа хальж, өөр үзэл бодолтой бусад хүн, Курдыг дэмжигчдийг ч хамрах болов.

### **ДҮРВЭЖ БҮЙ ХҮМҮҮС**

2015 онд нэг сая дүрвэгч, цагаач далайгаар ирсний дараагаас Европын холбооны гишүүн орнууд дүрвэгсдийн тоог 2016 онд бууруулахаар шийдвэрлэсэн. Тэд үүнийгээ амжилттай хэрэгжүүлсэн ч нэлээд хэмжээгээр хүний эрхийг зөрчиж, аж амьдралыг нь алдагдуулсан юм.

12 дугаар сарын эцэст 358 000 дүрвэгч, цагаач Европт хүрч очсон. Газар дундын тэнгисийг гатлан ирэгсдийн тоо бага зэрэг (170 000 хүртэл) нэмэгдсэн боловч Европын холбоо(ЕХ), Туркийн 3 дугаар сард тохиролцоонд хүрч байгуулсан цагаачлалыг хянах гэрээний улмаас Грекийн арлуудад ирдэг дүрвэгсдийн тоо (854 000-гаас 173 000 хүртэл) огцом буурав. Олон улсын цагаачлалын байгууллагын тооцоолсноор 5000 хүн далайд үйж амь насаа алдсан бол өнгөрсөн онд энэ тоо 3700 байжээ.

ЕХ, Туркийн байгуулсан уг гэрээ

нь ЕХ-ноос “дүрвэгсдийн хямрал” хэмээн нэрлэгдсэн асуудлыг шийдвэрлэх талаар авсан арга хэмжээ юм. Эрэг орчмын газраа цагдаагийн хүчээр хамгаалах, Грекийн арлуудаар дамжин ирсэн орогнол хүсэгчдийг буцаахад зориулж тус улсад 6 тэрбум евро олгохоор болсон. Турк улс орогнол хүсэгчдэд ЕХ-нд олгодог бүх хамгаалалтыг олгоно гэсэн үнэнд нийцэхгүй зүйлийг гэрээнийхээ урьдач нөхцөл болгосон. Улс төрийн зорилгодоо нийцүүлэн дүрвэгсдийн эрх, аж амьдралыг үл тоомсорлож буй ЕХ-ны хүсэл зорилгын тод илэрхийлэл нь ор нэрийн төдий ажиллаж буй орогнол эрэгсдэд зориулсан систем, Сирийн бараг 3 сая цагаач өдөр хоногийг дөнгөн данган өнгөрөөж буй явдал юм.

Хэдийгээр сард дунджаар шинээр ирдэг хүмүүсийн урсгал татарсан боловч Грекийн арлуудын хүн хүлээн авах боломж нэлээд хомс байсаар байна. Оны эцсийн байдлаар дүрвэгсдийн хуарангуудад хүмүүс зайгүй чихсэн, ариун цэврийн нөхцөл хангагдаагүй, аюултай нөхцөлд 12 000 дүрвэгч, орогнол эрэгч тарчигхан өдөр хоногийг өнгөрөөж байна. Ядуу тарчиг байдлаас дүрвэгсдийн хуаранд үймээн самуун үе үе гарсны зэрэгцээ хэт баруун бүлэглэлүүдтэй холбоотой гэгдэх орон нутгийнхан дүрвэгсэд рүү халдсаар байна. Грекийн эх газарт 50 000 дүрвэгч, цагаачийн нөхцөл харьцангуй сайн байв. Оны эцсийн байдлаар ихэнх цагаач албан ёсны хүлээн авах төвүүдэд толгой хоргодох боломжтой болсон. Гэвч эдгээр хүлээн авах төв майхан, орхигдсон агуулахуудаас бүрддэг бөгөөд цөөн хэдэн

хоногоос илүү хугацаагаар төвхнөж, ашиглах боломжгүй байдаг.

Оны эцсээр ЕХ, Туркийн гэрээ хүчин төгөлдөр үйчилж эхэлсэн боловч нэлээд хэврэг байдалтай байна. Тухайн үедээ тодорхой байсан ч энэ гэрээ эхний ээлжинд батлан хамгаалах зорилготой байв. Грекээр дамжин Балкан хүрэх замыг 3 дугаар сард хаах явдал Европт ирж буй хүмүүсийн урсгалыг зогсоох дараагийн арга хэмжээ болов. Македони болон Балканы хойгийн бусад орон хилээ хааж, тэдний энэ үйлдэлд европын бусад орны хил хамгаалах хүчин туслалцаа үзүүлэв. Унгарын Ерөнхий сайд Виктор Орбан үүнийг эхлүүлж, Австри улс үргэлжлүүлэв. ЕХ-ны олон удирдагчийн хувьд ирэхийг нь болиулж чадаагүйн төлөөс бол Грект түгжигдсэн дүрвэгсдийн зовлон юм.

Дүрвэгсэд болон ЕХ-ны гишүүн улсуудтай эв санааны нэгдэлгүй байгаа нь орж ирэхийг хязгаарлах, нутаг буцаах асуудалд л санаа нэгддэг ЕХ-ны ихэнх улсуудын цагаачлалын бодлогод түгээмэл ажиглагдав. ЕХ-ны нүүлгэн суурьшуулах үлгэрчилсэн төлөвлөгөө бүтэлгүйтснээр энэ байдал тодорхой боллоо. Цөөн тооны улсад дүрвэгсэд олноор ирж байгаагаас үүрэг хариуцлагыг жигд хуваарилах зорилгоор ЕХ-ны төр засгийн тэргүүн нар 120 000 хүнийг 2 жилийн хугацаанд Итали, Грек, Унгар зэрэг ЕХ-ны улсуудад нүүлгэн суурьшуулах төлөвлөгөөг 9 дүгээр сард баталсан. Зүгээр л бүгд хилээ хаах нь зүйтэй гэж үзэн Унгар улс энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүйгээ мэдэгдсний дараа тус улсад ногдох дүрвэгч хүлээн авах квотыг Грек, Италид хувааж өгчээ. Оны эцсийн байдлаар Грекээс дөнгөж 6000

орчим, Италиас 2000 хүрэхгүй хүнийг нүүлгэн суурьшуулсан байна. 2015 оноос хэрэгжиж буй ЕХ-ны “халуун цэгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ” хэмээх нэртэй санаачилгатай уг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө хавсран хэрэгжсэн юм. ЕХ-ны комиссоос санаачилсан дээрх арга хэмжээ нь шинээр ирэгсдийг тодорхойлох, хурууны хээ авах, хамгаалал хүртэх хэрэгцээ шаардлагыг аажмаар тодорхойлох, орогнол хүсэгчдийн өргөдлийг хянан үзэх, улмаар тэднийг ЕХ-ны бусад орон руу нүүлгэн шилжүүлэх эсвэл ирсэн орнуудад нь буцаах(Грек, Туркт ирсэн ирсэн дүрвэгсдийн хувьд хамаарахгүй) асуудлыг хариуцах төвүүдийг Итали, Грект байгуулахаар төлөвлөж байв. Энэ төлөвлөгөөний дүрвэгсэд нүүлгэн суурьшуулах хэсэг бүтэлгүйтснээр хурууны хээ авах, өргөдөл хянан үзэх, аль болох олон дүрвэгчийг буцаах гэсэн ихээхэн дарамттай Итали, Грек улс нүүр тулав. Хурууны хээ авах, дүрвэгсдийг дур зоргоороо саатуулах, бөөнөөр нь хөөн гаргахын тулд зүй бусаар хандсан тохиолдлууд гарч байв. Итали, Суданы цагдаагийн албад харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсны дараахан ихэнх нь Дарфураас ирсэн 40 хүнийг 8 дугаар сард Судан руу буцаажээ. Суданд ирмэгц нь эдгээр дүрвэгчийг тус улсын Үндэсний тагнуулийн газар болон Аюулгүй байдлыг хангах албанаас байцааж, хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн байна.

Аль болох олон дүрвэгчийг буцаах нь ЕХ болон түүний гишүүн орнуудын гадаад бодлогын гол зорилт болов. ЕХ болон Афганистан улс байгуулсан “Урагшлах хамтын

зам” хэмээх хамтын ажиллагааны гэрээнд 10 дугаар сард гарын үсэг зурав. Хандивлагчдын бага хурлын үеэр гарын үсэг зурсан гэрээгээр орогнол авч чадаагүй Афганчууд, түүний дотор харгалзах хүнгүй бага насны хүүхдүүдийг буцаахад нь Афганистан улс хамтран ажиллах үүрэг хүлээх болжээ (Хэдийгээр тус улсад аюул занал нэмэгдэж байгаа ч Афганчуудад олгох орогнолын түвшин буурсан).

ЕХ-ны гадаад бодлого дахь цагаачлалын асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны гол цөм нь 6 дугаар сард баталсан “Хамтын ажиллагааны үндэс” хэмээх өөр нэгэн баримт бичигт тусгалаа олсон. ЕХ-ны эрэгт хүрэх гэсэн цагаачдын тоог бууруулахын тулд тусламж, худалдаа, бусад эх үүсвэрийг ашиглан улс орнуудад шахалт үзүүлэх тухай энэхүү төлөвлөгөөнд заажээ. Мөн хүний эрхийг удаа дараалан зөрчдөг улсуудтай хилийн хяналтын хамтын ажиллагаа хөгжүүлэх, иргэдийг буцаан авах гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийж байна.

Гадаад бодлогоор дамжуулан цагаачлалын асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ Европ дотооддоо орогнол эрэгсдэд олгох боломж болон бусад хангамжийг хязгаарлах арга хэмжээ авч эхэлсэн. Ялангуяа өмнө нь өгөөмөр туслалцаа үзүүлдэг байсан Хойд Европын орнуудад энэ хандлага ажиглагдаж байна. Тухайлбал Финлянд, Швед, Дани, Норвеги улс бүгд цагаачлалын талаарх хууль тогтоомждоо ухралт хийсэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Норвегийн тухайд “Европт хамгийн хатуу дүрвэгчийн бодлого”-той болох зорилгоор ийм өөрчлөлтийг хийжээ. Финлянд, Швед, Дани

болон Герман улс бүх дүрвэгчдийг гэр бүлтэйгээ эргэн уулзах боломжийг хязгаарласан эсвэл хойшлуулах арга хэмжээ авав.

ЕХ-ны гадаад хилтэй хамгийн ойр орших улсууд хамгийн хатуу арга хэмжээ авчээ. 1-р сард Австрийн Засгийн газар 1 жилд 37500 орогнол хүсэгчийг хүлээн авах хязгаар тогтоосноо зарлав. Орогнол олгох тухай хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулснаар орогнол хүсэгчид их хэмжээгээр ирсэн тохиолдолд тус улсын Засгийн газар онцгой байдал зарлах эрхтэй болсон бөгөөд ингэснээр хил дээр орогнол хүссэн өргөдлийг хянан үзэх хугацаа хурдасч, орогнол авч чадаагүй хүмүүсийг тодорхой шалтгаангүйгээр шууд буцаах болсон.

Европын орогнол олгох тогтолцоо үр нөлөөтэй ажиллаж чадахгүй байгаа нь Унгар улсад хамгийн хүндээр тусав. Сербитэй хиллэдэг хэсгийнхээ ихэнхид нь 2015 оны 9 дүгээр сард хашаа барьж, орогнол олгох хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулсны дараа Унгарын Засгийн газар Сербийн хил дээрээс хүч хэрэглэн буцаах, улс дотроо хууль бусаар хорих, хил дээр хүлээж буй хүмүүст ядуу тарчиг нөхцөл олгох зэргээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Түүнчлэн, ЕХ-ны нүүлгэн суурьшуулах төлөвлөгөөнөөс татгалзах тухай бүх нийтийн асуулгад дэмжлэг үзүүлэх зорилгоор гадныхныг үзэн ядах үзлийг сурталчилсан аянд сая сая евро зарцуулж байхад дүрвэгчид хэцүү хүнд нөхцөлд амьдарч байв. Европын комиссын санаачилсан ЕХ болон олон улсын орогнолын эрх зүйг хэд хэдэн удаа зөрчсөн асуудал шийдвэрлэгдэлгүй нээлттэй үлдэв.

Европын нөгөө хэсэг Францад



Калай хотын “Ширэнгэн ой” хуаранд орогнол хүсэгч, дүрвэгсдэд зориулан хорогдох байр байгуулсан ч 10 дугаар сард татан буулгасан явдал хүнээ багтааж ядан буй Грекийн Лесвос, Чиос арлын хуарангууд, Унгарын өргөст торон хашааны урд байрлах орогнох байруудын нэгэн адил Европын цагаачлалын бодлого бүтэлгүйтсний бэлэг тэмдэг болж байна.

Жилийн өмнө ирсэн 1 сая орчим хүнийг хорогдох байраар хангаж, орогнох хүсэлтийг нь хянан үзсэн Германы сэтгэл хөдөлгөм хүчин чармайлт нь Европт “дүрвэгсдийн хямрал”-ын талаар Засгийн газраас авсан цорын ганц эерэг арга хэмжээ байж болох юм. Бүхэлд нь авч үзвэл, эв санааны нэгдэлгүй улс төрчдөд иргэд нь эв санааны нэгдэлтэй гэдгээ харуулах хэрэгтэй байна. Дүрвэгч, цагаачдыг найрсагаар угтаж, дэмжлэг үзүүлснээр цагаачлалын талаар хор нөлөө дагуулсан хэлэлцүүлэгт өөр нэгэн тал байж болохыг Европ дахь тоо томшгүй дүрвэгч хүлээн авах төвүүдэд буй хэдэн арван мянган хүн дахин, дахин харуулж байна.

### **ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Франц, Бельги, Герман улсад болсон балмад халдлагуудад 100 гаруй хүн амь насаа алагдаж, түүнээс олон хүн гэмтэж бэртэв. Энэ хүмүүс зэвсэгт этгээдүүдийн сум, амиа золиослогчдын бөмбөгөнд өртөхийн зэрэгцээ гудамжинд явж байхад нь зориудаар дайрсан халдлагын золиос болсон юм. Иргэдийнхээ амьд явах эрхийг хамгаалах, амьдрах, чөлөөтэй зорчих, сэтгэн бодох нөхцөлөөр хангах явдал Европын засгийн газруудын хувьд тулгамдсан

асуудал болоод байна. Гэвч хүний эрх, үнэт зүйлийг дордуулсан терроризмтай тэмцэх арга хэмжээг яаравчлан авах замаар эдгээр зайлшгүй эрх, эрх чөлөөг хангах асуудалд хандаж байна.

2016 онд парадигмын шилжилт сууриараа эргэлээ. Төр иргэдийнхээ аюулгүй байдлыг хангаснаар иргэд эрхээ эдлэх боломжтой болно гэсэн үзэл өөрчлөгдөж, аюулгүй байдлыг хангахын тулд төр иргэдийнхээ эрхийг хязгаарлах ёстой гэж үзэх боллоо. Үр дүнд нь төрийн эрх мэдэл, хувь хүний эрхийн хоорондох хил хязгаарыг аюултайгаар өөрчиллөө.

Улс орнууд “онцгой байдал” зарлах, түүнийг сунгах шийдвэрийг хялбархан гаргах болсон нь хамгийн их айдас төрүүлж байна. Үүнийг Унгар улс тэргүүлэн, олон нийтийг эвлэлдэн нэгдэхийг хориглох, чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах, шүүхийн хяналтгүйгээр хувийн хөрөнгийг царцаах зэргээр онцгой байдал зарласан үед гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг нэмэгдүүлсэн хууль тогтоомж батлан гаргалаа.

Болгарын парламент үүнтэй адил цогц арга хэмжээг батлав. Франц 2015 оны 1 дүгээр сард болсон халдлагын дараа тогтоосон онцгой байдлын хугацааг 12 дугаар сард 5 дахь удаагаа сунгалаа. Шүүхийн зөвшөөрөлгүй орон байранд нэгжлэг хийх эрхийг дахин сэргээх (эхний удаа сунгахад ийм эрхийг хүчин болгосон), эсэргүүцлийн хөдөлгөөнийг хориглох зорилгоор олон нийтийн аюулгүй байдал гэх шалтгаанаар нийтийг хамарсан үйл ажиллагааг таслан зогсоох байдлаар шинэ эрх мэдлийг бий болгох зэргээр онцгой байдлын үед төрд олгогдох эрх мэдлийг 7 дугаар

сард нэлээд нэмэгдүүлсэн. Францын Засгийн газраас 2016 оны 12 дугаар сард гаргасан тоо баримтаас үзэхэд 2015 оны 11 дүгээр сараас хойш 4292 айлын орон байранд нэгж хийж, 612 хүнийг хүчээр гэрийн хорионд оруулсан нь онцгой байдлын үед олгогдсон эрхийг зүй бусаар ашиглах вий гэж санаа зовоож байна.

Европын хэд хэдэн оронд, онцгой байдлын гэж үзэх арга хэмжээнүүдийн талаар ердийн эрүүгийн хуульд тусгасан байдаг. Словак, Польшид терроризмтай холбоотой гэмт хэргийн сэжигтний урьдчилан хорих хугацааг сунгахаар заасан байдаг бол Бельгид бүх төрлийн ял шийтгэлд хорих хугацааг сунгах тухай санал гарсан. Нидерланд, Болгарт иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах шүүхийн зөвшөөрөлгүй захиргааны хяналтын арга хэмжээг нэмэгдүүлэх саналыг парламентад өргөн бариад байна.

Их Британи, Францад аюулгүй байдлын нууц материалд үндэслэн ийм хяналт тогтоож, зарим тохиолдолд гэрийн хорионд оруулж байна. Ингэснээр амьдрал, гэр бүлд нь аюултайгаар нөлөөлөх учраас хүмүүс эдгээр арга хэмжээг эсэргүүцэж чадахгүй байна.

Терроризмийг дэмжсэн эсхүл түүнийг хамгаалсан явдалд ял тулгахаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь зөрчин, олон зуун хүнийг мөрдөн шалгав. Ялангуяа, олон нийтийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлсний төлөө Францад олон хүнийг мөрдөн шалгасан бол Испанид энэ байдал бага байлаа. Оны эцэст батлагдахаар хүлээгдэж байсан ЕХ-ны терроризмтай тэмцэх удирдамж мөрдөгдөж эхэлбэл ийм хуулиуд

олноор гарах болно.

Бүрхэг тодорхойлсон “терроризмыг дэмжих”-ийг хориглох тухай хуулийн санал Германд гарсан бол Бельги, Нидерландын парламент үүнтэй ижил ял тулгасан хуулийн төслийг хэлэлцсэн.

Европ даяар улс орнууд мөшгин хянах эрх мэдлийг ихээхэн нэмэгдүүлсэн. Энэ нь ноцтой гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл бүрдсэн, ийм үйл ажиллагаатай тэмцэхэд үр нөлөө үзүүлэхүйц хувь нэмэр оруулахад шаардлагатайгаас бусад тохиолдолд өгөгдлийг нууцаар тандан хянах, замаас нь барих, хадгалах нь хувь хүний нууцаа хадгалах эрхийг зөрчинө гэсэн ЕХ-ны шүүх, Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийг зөрчиж байгаа юм. Мөшгин хянах тухай үндэсний хууль тогтоомжууд шүүх эсвэл бусад бие даасан эрх бүхий байгууллагаас урьдчилан олгосон шийдвэрийг үндэслэх зэрэг буруугаар ашиглахаас сэргийлэх хангалттай баталгааг бий болгох шаардлагатай гэж эдгээр шүүхийн аль аль нь үздэг. Их Британи улс Мөрдөн шалгах эрхийн тухай хуулийг 11 дүгээр сард баталснаар хамгийн өргөн хүрээг хамарсан мөшгин хянах эрх мэдлийг бий болгосон. Ихэнхдээ “мөрдөгчийн дүрэм” гэж нэрлэгддэг энэ хуулиар өгөгдлийг замаас нь барих, түүнд саад учруулах, хадгалах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах эрх олгож, харилцаа холбооны өгөгдлийг хадгалахад нь хувийн компаниудад шинэ шаардлага тавих болсон. Ихэнх тохиолдолд хянан үзсэний дараа Ерөнхий сайдын томилсон, эсвэл Засгийн газрын гишүүдээс бүрдэх хагас шүүхийн байгууллага энэ хуулийн дагуу олгогдсон эрх мэдлийг

хэрэгжүүлэх шийдвэрийг гаргана. Их Британи мөшгин хянах тухай хууль тогтоомж хувь хүний нууцаа хадгалах эрхийг зөрчсөн гэсэн дүгнэлтийг ЕХ-ны шүүх 12 дугаар сард гаргасан.

Их Британиас гадна, Австри, Швейцарь, Бельги, Герман, Орос, Польш улс мөшгин хянахтай холбоотой шинэ хуулийг батлан гаргасан. Хоорондоо бага зэрэг ялгаатай боловч эдгээр хуулиуд бүгд электрон өгөгдлийг цуглуулан, хадгалах, шүүхийн болон бусад эрх бүхий байгууллагын бага хяналттай эсвэл огт хяналтгүйгээр нарийн тодорхойлоогүй зорилтот бүлгүүд эсвэл сэжигтэй этгээдүүдийг онилсон мөшгин хянах үйл ажиллагаа явуулах өргөн эрх мэдлийг олгосон. Нидерланд, Финлянд улсын аль алинд нь оны эцэст ийм хуулийн төсөл хэлэлцэгдэхээр хүлээгдэж байв.

### **ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ**

Терроризмтай тэмцэх эрх мэдлийнхээ хүрээнд болон биеийн байцаалт шалгах зэрэг хууль сахиулах ердийн үйл ажиллагааны үеэр цагдаагаас ислам шашинтай иргэд, цагаачдын талаар яв, үндэстэй нь холбогдуулан мэдээлэл цуглуулах, ялгаварлан гадуурхах явдал түгээмэл байна.

Хүч хэрэглэсэн хэт даврах үзэлтэй тэмцэх санал санаачлагуудад олон нийтийн байгууллагуудын мэдээлэх үүргийн талаар тусгасан явдал ислам шашинтай иргэдийг нийгмээс тусгаарлан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь боогдуулж байна. Болгар, Швейцарийн парламент нүүрээ бүрэн хаасан гивлүүрийг олон нийтийн газар зүүхийг хориглосон хууль батлав.

Нидерландын парламент нүүрээ бүрэн халхалсан гивлүүр зүүхийг хориглох тухай хуулийн төслийг оны эцэст хэлэлцэхээр хүлээж байсан бол Германд үүнтэй адил хуулийн төсөл өргөн баригдсан. Францын эрэг орчмын хэд хэдэн хотын захиргаа далайн эрэг дээр “ислам шашинт эмэгтэйчүүдэд зориулсан усны хувцас” өмсөхийг хорилгохоор төлөвлөж байна. Төрийн зөвлөлөөс ялгаварлан гадуурхах хуулийн заалтуудыг хууль бус гэж үзсэн боловч үүнийг эс харгалзан олон хотын захиргаа эдгээр заалтыг хэвээр үлдээсэн.

Европын хэд хэдэн улсад орогнол эрэгч, ислам шашинтан, гадаадын иргэдийн эсрэг чиглэсэн үзэн ядах гэмт хэргийн тоо нэмэгджээ. Германд орогнол эрэгчдийн хорогдох байруудад халдах гэмт хэргийн тоо огцом өссөн бол Их Британид 6 дугаар сард болсон ЕХ-ноос гарах бүх нийтийн санал асуулгын дараа 3 сарын хугацаанд өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад үзэн ядах гэмт хэрэг 14 хувиар нэмэгдсэн.

Европ даяар цыган иргэд орон сууц, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэх боломжийг хүртэхдээ ялгаварлан гадуурхалттай нүүр тулгарах нь элбэг байна. Төв Европ даяар болон Франц, Италид Цыган иргэд хүчээр албадан гаргах үйл ажиллагаанд өртөмтгий байна. Албадан гаргагдсан иргэд шүүхэд хандах явдал нэмэгдэх хандлагатай байгаа боловч шүүхийн шийдвэр хохирсон иргэдийн нөхцөлийг сайжруулахад туйлын бага нөлөөлж байна. Чех улсад олон эерэг өөрчлөлт гарч байна. ЕХ-ны зөрчлийг шийдвэрлэх үйл ажиллагааны үрээр тусгай сургуульд Цыган хүүхдүүд

түлхүү суралцаж буйг бууруулах зорилготой цуврал шинэчлэх арга хэмжээ 9 дүгээр сард эхэлсэн хичээлийн жилээс хүчин төгөлдөр мөрдөгдөх болов.

Хэдийгээр жигд бус байгаа ч лесбиян, гей, бисексуал, транжендэр, интерсекс хүмүүсийн эрхийн асуудлаар ахиц дэвшил гарлаа. Францад хууль ёсны дагуу хүйсийг тодорхойлохдоо эрүүл мэндийн шаардлага тавьдгийг хүчингүй болгосон шинэ хууль баталсан бол Норвеги улс өөрөө хүйсээ тодорхойлох эрхийг олгов. Грек, Данид үүнтэй ижил алхам хийгдэж байна. Ижил хүйстэн хосын эрхийг хүндэтгэх, тэднийг хүүхэд үрчлэн авах боломжийг хангах талаар олон улс орон тодорхой алхам хийж байна. Итали, Словенид ижил хүйстнүүд хамтран амьдрахыг хүлээн зөвшөөрсөн хууль батлав. Украйны нийслэл Киев хотод 6 -р сард болсон Лесбиян, гей, бисексуал, транжендэр, интерсекс хүмүүсийн бахархлын жагсаалыг засаг захиргааны зүгээс дэмжиж, цагдаагийн хүчээр чанд хамгаалсны дүнд ямар нэг хэрэг гарсангүй. 2000 орчим хүн оролцсон энэ жагсаал нь Украйнд болсон ийм төрлийн хамгийн том арга хэмжээ болов.

Асуудлын нөгөө талд ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх явдлыг Узбекистан, Тажикстанд гэмт хэрэгт тооцсон хэвээр байна. Киргизстанд “бэлгийн уламжлалт харилцаа”-ны талаар “ээрэг хандлагыг дэмжих явдал”-ыг гэмт хэрэгт тооцох хуулийн төсөл Парламентаар хэлэлцэгдэж байгаа ба 12 дугаар сард болсон бүх нийтийн санал хураалтаар ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хориглох

үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсан. Мөн улам бүр зохион байгуулалтад ороод байгаа, зарим тохиолдолд төрийн дэмжлэгтэй консерватив бүлгүүд ахиц дэвшлийг хойш нь чангаах явдал гаргалаа. Гэрлэлт, гэр бүлийн тухай үндсэн хуулийн ойлголтод ижил хүйстнүүдийн гэрлэлтийн асуудлыг илэрхий багтахгүй байхаар өөрчлөлт оруулах зорилготой бүх нийтийн санал асуулга явуулах саналыг Гүржийн парламент батлаагүй боловч Румынд энэ асуудлыг хэлэлцэхийг Үндсэн хуулийн шүүх парламентад зөвшөөрөв. Нийслэл Вильнюс хотод болсон 2016 оны Балтийн бахархлыг тэмдэглэх “Тэгш эрхийн жагсаал”-д 3000 хүн оролцсноос хэдхэн хоногийн дараа энэ асуудлаар Литвийн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал парламентын 2 шаардлагатай санал хураалтын эхнийх нь батлагдлаа.

Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар дорвитой ахиц дэвшил гарахгүй байна. Хүчтэй хуулийн хамгаалалт улам бүр сайжирч байгаа ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл газар сайгүй байсаар байна. Болгар, Чех, Латви улс Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай Европын зөвлөлийн конвенц (Истанбулын конвенц)-д гарын үсэг зурав. Румын, Бельги улс энэ конвенцийг соёрхон баталлаа. Гэсэн хэдий ч ихээхэн ухралт болсон алхам гарч байна. Жилд 1 сая хүртэл эмэгтэй хохирогч болж байгааг үл харгалзан Польшийн Засгийн газар дээрх конвенцийг батлаад нэг л жил болоод тус конвенцоос гаргах болсноо зарлав. Түүнчлэн эрх баригч нам бэлгийн болон нөхөн

үржихүйн эрхийг хязгаарлалаа. Эмэгтэйчүүд бүх нийтийн ажил хаялт зохион байгуулсны дараа үр хөндөх эрхийг бараг бүрэн хориглох, үр хөндүүлсэн эмэгтэйчүүд, охид болон тэднийг үр хөндөлт хийлгэхэд тусласан эсвэл дэмжсэн этгээдэд ял ногдуулах хуулийн төслийг баталсангүй. Ирландад үр хөндөлтийг ихээхэн хязгаарласан хууль тогтоомжийг батлахыг дэмжсэн байр суурь ихээхэн дэмжлэг авсан бол НҮБ-ын Хүүхдийн эрхийн асуудлаарх комисс үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байхыг Ирландад уриалав. Мальтад бүх тохиолдолд үр хөндөлт гэмт хэрэгт тооцогдсон хэвээр байна.

### **ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Өөр үзэл бодол илэрхийлсэн, шүүмжлэлтэй хандсан иргэд болон сөрөг хүчнийг нухчин дарах явдал хуучин ЗХУ даяар хэвээр байна. Ялангуяа, өмнөх жилүүдээс илэрхий дордоогүй боловч Узбекистан, Туркменистан, Беларусьт ноцтой түвшинд байна. Тажикстан, Казахстанд байдал илэрхий дордсон бол Орос, Азербайжанд доошоо уруудсан хандлага урт хугацаанд үргэлжилж байна. Украинд Оросын талыг дэмжигч мэдээллийн хэрэгсэлд хэзээ хэзээнээс илүү халдах болсон бол Крым болон Оросын дотоодод Украин болон Татарыг дэмжсэн дуу хоолойг ихээр нухчин дарлаа. Амжилт олоогүй төрийн эргэлт хийх оролдлогын дараа Туркт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг түрэмгийлэн хязгаарласан. Балканы орнууд эрэн сурвалжлах сэтгүүлчдэд аюултай газар хэвээр

байгаа бөгөөд зөрчил, асуудлыг ил болгосныхоо төлөө 12 сэтгүүлч мөрдөн шалгагдаж, зодуулж нүдүүлсэн бол ЕХ-ны дотор Польш, Унгар, Хорватад олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг хаажээ.

ОХУ хэвлэл мэдээллийн хэрэгслээр гутаан доромжлох аян явуулах, хамгийн чухал байгууллагуудыг “Гадаадын агентуудын тухай хууль”-ийг ашиглан онилох зэргээр ТББ-уудын талаарх уургаа улам бүр чангалсаар байна. Гадаадаас санхүүждэг боловч бие даасан үйл ажиллагаа явуулдаг 12 төрийн бус байгууллагыг “гадаадын агент”-ын жагсаалтад нэмж оруулснаар нийт 146 төрийн бус байгууллага энэ жагсаалтад багтах болсноос 35 нь үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоожээ. Эмэгтэйчүүдийн Доны холбооны үндэслэгч, тэргүүн Валентина Череватенкогийн эсрэг “хуулиар ногдуулсан үүргийг системчлэн зөрчсөн” гэх үндэслэлээр прокорураас анх удаа ял тулгав. Түүнчлэн тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хатуу хянасан хэвээр байна.

Казахстан улс эрүүгийн хуулийн заалтыг ТББ-ын удирдагчдын эсрэг анх удаа хэрэглэлээ. Газрын тухай шинэ хуулийг эсэргүүцсэн 4, 5 дугаар сард болсон эсэргүүцлийн хөдөлгөөнийг “зохион байгуулсан” 12 иргэн, оролцсон олон зуун хүнийг хорьж саатуулав. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчин олон нийтийн сүлжээнд нийтэлсэн зүйлүүдийг мөрдөн шалгах явдал нэмэгдсний зэрэгцээ нэр хүнд бүхий сэтгүүлчдэд “зориудаар хуурамч мэдээлэл тараасан”, өмч хөрөнгө шамшигдуулсан гэх ял тулгав. Харилцаа холбооны хуульд

оруулсан өөрчлөлт 1 дүгээр сард хэрэгжиж эхэлснээр интернет хэрэглэгчид “үндэсний аюулгүй байдлын сертификатыг”-ыг суулгах үүрэгтэй болсон. Ингэснээр засаг захиргааны зүгээс иргэдийн харилцаа холбоог шалгах, хууль бус гэж үзсэн мэдээллийг үзэх боломжийг нь хаах эрх мэдэлтэй болсон.

Тажикстан улс хориглогдсон сөрөг хүчний Исламын сэргэн мандлын намыг нухчин дарах ажиллагааг эрчимтэй явуулж, тэргүүлэгч 14 гишүүнийг нь нууц шүүхээр терроризмтай холбоотой ял тулган урт хугацаагаар хорих ял оноов. Засгийн газраас Төрийн нэвтрүүлгийн хороогоор дамжуулан бүх телевиз, радио сүлжээний агуулгыг “зохицуулан, хянах” эрхийг олгох 5 жилийн зарлиг гаргасан. Хүний эрхийн хамгаалагчдыг хатуу хянан шалгах болсон бол цагдаа, аюулгүй байдлын албанаас бие даасан мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг айлган сүрдүүлж, заналхийлсэн. Засаг захиргааны зүгээс тодорхой мэдээний эсвэл нийгмийн сүлжээний сайтуудад нэвтрэх боломжийг хязгаарлахыг интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад үүрэг болгосон хэвээр байгаа бол Тажик телекомп хэмээх төрийн өмчит компаний харьяа шинээр байгуулсан харилцаа холбооны цорын ганц төвөөр дамжуулан үйлчилгээгээ үзүүлэхийг харилцаа холбооны операторуудад үүрэг болгосон шинэ зарлигийг гаргажээ.

Азербайжанд сөрөг хүчний идэвхтэн дэмжигч, хүний эрхийн төрийн бус байгууллага, бие даасан хэвлэл мэдээллийг нухчин дарсаар байна. 12 үзэл санааны хоригдлыг сулласан боловч оны

эцсийн байдлаар 14 хоригдол шоронд ял эдэлж байгаагийн дотор Европын хүний эрхийн шүүхээс суллахыг шаардсаныг үл харгалзан Дээд шүүхээс 11 дүгээр сард ял оноосон Илгар Маммадов байна. Узбекистан, Туркменистаны адилаар Азарбайжан улс олон улсын Эмнести Интернэшнлийг улс орондоо нэвтрүүлэхээс татгалзав. Олон нийтийн эсэргүүцэл хөдөлгөөнийг хатуу хязгаарлаж байна. Цөөн хэдэн жагсаал цуглааныг цагдаагийн ихээхэн хүч хэрэглэн тарааж, зохион байгуулсных нь төлөө улс төрийн идэвхтнүүдийг баривчилж байна.

Украинд мэдээллийн хэрэгсэл ерөнхийдөө чөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг боловч Оросыг дэмжигч эсвэл салан тусгаарлах үзэлтэй гэгдэх болон засаг захиргааныхаа талаар шүүмжлэлтэй ханддаг мэдээллийн байгууллагууд заналхийлэлд өртдөг. Эзэлж авсан Оросын засаг захиргаа үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг ихээхэн хязгаарладаг Крымд бие даасан сэтгүүлчид ажиллах боломжгүй болов. Крымын татарууд тодорхой хавчлагад өртсөн байна.

Туркт, ялангуяа 7 дугаар сард болсон төрийн эргэлт хийх оролдлогоос үүдэн онцгой байдал зарласны дараа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэсэн явдал ихээхэн суларсан. 118 сэтгүүлчийг урьдчилсан саатуулах төвд хорьж, гүйцэтгэх зарлиг, журмын дагуу 184 мэдээллийн байгууллагыг хууль бусаар, бүрэн мөсөн хаажээ. Интернетийн цензур нэмэгдэж, 375 төрийн бус байгууллага, түүний дотор эмэгтэйчүүдийн эрхийн бүлгүүд,

хуульчдын холбоо, хүмүүнлэгийн байгууллагуудыг хаасан.

### **ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭХ БА ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ**

Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бусаар харьцах явдал хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд байсан улсууд түгээмэл байна. Зарим улсад хууль тогтоомжийг ор нэрийн төдий сайжруулж, ял шийтгэлгүй үлдэх нь түгээмэл байна. 2013-2014 онд Евромайданы бослого хөдөлгөөн, 2013 онд Гези цэцэрлэгт хүрээлэнгийн бослого, Киргизстаны өмнөд хэсэг болсон үндэстэн хоорондын мөргөлдөөний үеэр хууль сахиулах ажилтнууд хүний эрхийг ихээр зөрчсөн явдалд хариуцлага хүлээх боломж 2010 онд Украйнд бүдгэрч, Туркт орон нутгийн хэмжээнээс халилгүй үлдэж, Киргизстанд бүдгэрэн ач холбогдлоо алдаж байна.

Европын хүний эрхийн шүүх эрх зүйн арга хэмжээ авсаар байгаа ч ЕХ-нд АНУ-ын тэргүүлсэн хөтөлбөрт хамтран оролцож, хариуцлагатай байдал харуулах явдал хэрэгжихэд хол байна. Оны эцсийн байдлаар, Польш, Литви эсвэл Румынд терроризмын хэргийн сэжигтнийг хууль бусаар хорьж саатуулж, эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр зүй бус харьцсан асуудалд нэг ч хүн гэм буруутайд тооцогдон шийтгэгдээгүй юм.

Сүүлийн арван жилд хорих газруудад эрүүдэн шүүх явдлыг устгах талаар илэрхий ахиц дэвшил гарсан ч Туркт болсон төрийн эргэлт хийх оролдлогын үеэр ийм хэрэг түгшүүр төрүүлэхүйц хэмжээгээр бүртгэгдсэн байна. Цагдаагийн албан болон албан бус хорих газруудад олон мянган хүн хоригдож, тэднийг хэрцгийгээр

зодож нүдэх, бэлгийн дарамт үзүүлэх, хүчиндэхээр айлган сүрдүүлэх, хүчиндсэн тухай мэдээллийг Туркийн засаг захиргаа тогтмол гэхдээ итгэмээргүй байдлаар үгүйсгэж байв.

### **ЦААЗААР АВАХ ЯЛ**

Оны сүүлээр, олон улсын хамтын нийгэмлэг зэмлэн буруушааж буйг болон Европын зөвлөлийн гишүүний хувиар хүлээсэн үүргээ үл харгалзан Туркийн Ерөнхийлөгч цаазаар авах ялыг сэргээх бодолтой байгаагаа парламентынхаа өмнө зарлалаа. Хэдийгээр анх удаагаа биш боловч ойрын хугацаанд цаазаар авах ялыг халах зарим нэг нааштай хандлагыг илэрхийлж байсан, Европт цаазаар ялыг гүйцэтгэж буй сүүлийн орон болох Беларусь энэ жил 4 хүнд цаазаар ял оноосон. Казахстанд терроризмтай холбоотой гэх үндэслэлээр нэг хүнийг цаазаар авах ялаар шийтгэжээ.

### **ХЯМРАЛ МӨРГӨЛДӨӨН БА ЗЭВСЭГТ ХҮЧИРХИЙЛЭЛ**

Олон улсын Эрүүгийн шүүх Украйны зүүн хэсэгт болж буй байлдааныг эхний байдлаар хянаад, олон улсын зэвсэгт тэмцлийн шинжтэй байна гэсэн дүгнэлтийг 11 дүгээр сард гаргалаа. Үе үе зөрчил тэмцэл үргэлжилж, цэрэг, улс төрийн байдал мухардмал шинжтэй байв. Донбас дахь Оросын дэмжлэгтэй засаг захиргаа бараг бие даасан байдалтай болсон. Украйн дахь НҮБ-ын Хүний эрхийн ажиглалтын багийн тооцоогоор оны эцсийн байдлаар 10 000 хүн амь насаа алдсаны дотор 2000 энгийн номхон иргэн байв. Зүүн Украйны засаг захиргаа, салан тусгаарлах

хүчнийхний аль аль нь нэг талынхаа дэмжигч гэж үзсэн энгийн иргэдийг “шоронгийн хоригдол солилцох” хэрэгсэл болгон хууль бусаар саатуулдаг. Украйны хүчнийхэн нууцаар саатуулсан бүх хүмүүсээ оны эцсээр сулласан байна.

Армены дэмждэг, салан тусгаарласан Нагорно-Карабахын бүс нутагт Азербайжан, Армен улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн 4 дүгээр сард болсон боловч удаан үргэлжилсэнгүй. Дөрвөн өдрийн байлдаанд цөөн тооны цэргийн албан хаагч, иргэд амь насаа алдаж, харилцан бие биенээ буруушааж, Азербайжан бага хэмжээний газар нутаг эзлэн авав.

Курдистаны ажилчдын намтай холбоотой бүлэглэлүүд нуувч ухаж, хаалт босгосны хариуд 2015 оны эцсээр Туркийн засаг захиргаа тус улсын зүүн өмнөд хэсгийн хэд хэдэн газар цэргийн ажиллагаа явууллаа. Хөл хорио тогтоож, хүнд зэвсэг ашиглах зэргээр хүч хэт хэрэглэсний улмаас цэргийн ажиллагаа 6 дугаар сар гэхэд ерөнхийдөө дуусгавар болж, олон зуун энгийн иргэн амь насаа алдаж, иргэдийн оршин суух газрыг ихээр эвдэн сүйтгэж, хагас сая орчим хүнийг хүчээр нүүн суурьшихад хүргэв.

Хот суурин газраас гадна Курдистаны ажилчны нам, Туркийн хүчнийхний хооронд мөргөлдөөн үүсч, Курдистаны ажилчны намын зүгээс Засгийн газрын барилга байшингуудад үе үе халдлага үйлдэж байснаас үзэхэд 2015 онд зогссон энхийн үйл явц дахин сэргэх шинж тэмдэг харагдахгүй байна.



# ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2016 оны туршид Ойрх Дорнод ба Хойд Африкийн бүс нутагт засгийн газруудын харгислал болон оролцогч бүх талууд нь аймшигт гэмт хэрэг үйлдэж, хүний эрхийг зөрчиж байгаа ужгирсан хямрал мөргөлдөөний улмаас сая сая хүмүүс үймээн самуунд өртөж, амь насаа алдан, орон гэр, аж амьдрал нь сүйрлээ. Улс төрийн болон хүний эрхийн хямрал гүнзгийрсний улмаас олон мянган хүн тус бүс нутагт үлдэхийн оронд Газрын дундад тэнгисийг гатлах аюултай аялалд гарч, амь насаа эрсдэлд оруулж байна. Сири улсад 5 жил гаруй үргэлжилж буй дайн тулаан өнөө цагийн хамгийн том хүмүүнлэгийн хямралыг бий болгосон бөгөөд Ирак, Ливи, Йемен улс дахь зэвсэгт мөргөлдөөн энгийн номхон иргэдэд асар их гарз хохирол авчирлаа. Зэвсэгт мөргөлдөөн ба хүмүүсийн талцлыг улам гүнзгийрүүлж, улс төрийн болон шашны туйлшралыг нэмэгдүүлж, хүний эрх улам их зөрчигдөхөд хүргэж байна.

## **ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН**

Сири улсад 5 жил гаруй үргэлжилж буй хямрал мөргөлдөөнөөс үүдэн хүмүүст учирсан хохирлыг үнэндээ хэмжих боломжгүй юм. Сирийн ард түмэнд учирсан зовлон зүдгүүрийн цар хүрээ, алагдсан, шархадсан хүмүүсийн тоо, гэр бүл, аж амьдрал нь сүйрсэн хүмүүс болон сүйтгэгдэж үгүй болсон гэр орон, эд хөрөнгө, түүхэн дурсгал, шашны болон соёлын эд өлгийн зүйлсийг

бодитойгоор үнэлж, дүгнэх тодорхой томъёолол алга байна. Алагдсан, шархадсан хүмүүсийн тоо болон Алеппо зэрэг хотуудын сүйдсэн дүр төрх уг хямрал ямар өргөн цар хүрээг хамарч байгаагийн зарим нэг үзүүлэлт юм. Оны төгсгөл гэхэд хямрал мөргөлдөөний улмаас 300 000 хүн амь насаа алдаж, 11 сая хүн хүчээр нүүн шилжихэд хүрсний 6,6 сая нь дотооддоо шилжин суурьшсан бол 4,8 сая нь гадаад улсууд руу орогнол эрэн дүрвэжээ. Хямрал мөргөлдөөнд оролцож байгаа бүх хүчнүүд олон улсын хүмүүнлэгийн хуулийг зөрчин дайны гэмт хэрэг болон бусад зөрчлийг үйлдсээр байгаа бөгөөд бүх талууд энгийн номхон иргэдийг хамгаалах үүргээ хөсөрдүүлсээр байна.

Сирийн Засгийн газрын зэвсэгт хүчин энгийн номхон иргэд оршин суудаг сөрөг хүчний хяналтад байгаа газрууд руу удаа дараа дайралт хийж, торхон бөмбөг болон бусад тэсрэх хэрэгслээр бөмбөгдөж, их буугаар буудсан. Түүнчлэн тэдгээр газрыг бүсэлсээр байгаа нь хоол хүнс, эм тарианы хомсдолд оруулж, энгийн номхон иргэд амь насаа алдахад хүргэлээ. Засгийн газрын зэвсэгт хүчин энгийн номхон иргэд болон иргэний байгууламжуудын эсрэг шууд дайралт хийж, эмнэлэг болон эрүүл мэндийн бусад байгууламжуудыг хайр найргүй бөмбөгдсөн ба нэг удаа НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн цуваанд халдлаа. Сирийн Засгийн газартай

эвссэн Оросын зэвсэгт хүчин сөрөг хүчний хяналтад байгаа газруудад агаарын цохилт өгсөн нь олон мянган энгийн иргэдийг алж, шархдуулсан бөгөөд тэдний орон гэр, дэд бүтэц сүйдсэн. Оны төгсгөлийн байдлаар Засгийн газар ба эвслийн хүчин Алеппо хотыг сөрөг хүчний гараас булаан авсан нь хямрал мөргөлдөөнийг шийдвэрлэх үе шат болсон. 12 дугаар сард Орос болон Туркийн ивээл дор Засгийн газар ба зарим сөрөг хүчнийхэн гал зогсоох хэлэлцээр байгуулсан нь шинэ энхийн хэлэлцээ хийх замыг нээсэн бөгөөд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл хямрал мөргөлдөөнд оролцож буй талуудад хандан Сири улсын нутаг дэвсгэрээр хүмүүнлэгийн тусламжийг “хурдан, аюулгүй, саад учруулалгүйгээр” нэвтрүүлэхийг дахин уриалсан юм.

Сирийн Засгийн газрын хяналтад байгаа буюу эзлэн авсан газруудад аюулгүй байдлын хүчнийхэн бүх сөрөг хүчнийг нухчин дарж, олон мянган хүнийг хорьсон бөгөөд хүмүүсийг хүчээр сураггүй алга болгож, гэр бүлийнхэнд нь тэдний хаана, ямар нөхцөлд байгаа, хувь заяа нь хэрхсэн талаар мэдээлэл өгөхөөс татгалзсан. Хоригдлуудыг эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал өргөн тархсан бөгөөд түүний улмаас олон хүн амь насаа алдсан.

Сирийн Засгийн газартай болон өөр хоорондоо тулалдаж буй зэвсэгт бүлэглэлүүд дайны гэмт хэрэг болон олон улсын эрх зүйн бусад ноцтой зөрчил үйлдсээр байна. Өөрсдийгөө Исламын улс хэмээн нэрлэдэг зэвсэгт бүлэглэл нийслэл хот Дамаскийн Засгийн газрын мэдэлд байгаа хэсэгт амиа

золиослогчдыг ашиглан энгийн иргэдийн эсрэг шууд халдлага үйлдэж байгаагаас гадна химийн хорт бодис ашигласан ба хааж бүслэн, өөрийн хяналтад байгаа газар нутаг дахь хүмүүсийг хууль бусаар егүүтгэж байна. Бусад зэвсэгт бүлэглэлүүд Сирийн Засгийн газар болон Курдын зэвсэгт хүчний хяналтад байгаа газруудыг хаа сайгүй бөмбөгдөж энгийн номхон иргэдийг алж, шархдуулсан.

Ойрх Дорнодын хамгийн ядуу улс болох Йеменд тус улсын болон гадаадын зэвсэгт хүчнүүдийн хооронд зэвсэгт мөргөлдөөн үргэлжилсээр байгаа бөгөөд энгийн иргэдийн амь насыг огтхон ч хайхрахгүйгээр бөмбөг, их буу болон бусад зэвсэг ашиглан иргэд болон иргэний байгууламжуудын эсрэг шууд дайралт хийж байгаагаас гадна хүн ам оршин суудаг газраас буудалцаж, иргэдийн амь насыг аюулд учруулж байна.

Хутхи зэвсэгт бүлэглэл болон Йемений ерөнхийлөгч асан Али Абдуллах Салехт үнэнч армийн анги нэгтгэлүүд Та'из хотыг хайр найргүй бөмбөгдөн энгийн иргэдийг алж, шархдуулснаас гадна хүнс, амин чухал хэрэгцээтэй эм тариаг оруулахыг хориглосон нь хүмүүнлэгийн онцгой нөхцөл байдал үүсэхэд хүргэсэн. Түүнчлэн Хутхичүүд Саудын Арабын иргэд оршин суудаг газрууд руу хил давуулан бөмбөгдсөн. Йемений олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн Засгийн газрыг сэргээн байгуулах зорилготой Саудын Арабын толгойлсон Арабын улсуудын цэргийн эвсэл Хутхичүүд болон тэдний холбоотнуудын хяналтад байгаа буюу маргаантай газар нутагт ширүүн агаарын

цохилт өгснөөс үүдэн мянга мянган энгийн иргэд алагдаж, шархадсан юм. Тэдгээр довтолгоонуудын олонх нь хүч хэтрүүлсэн бол зарим нь энгийн иргэд, сургууль, зах зэрэг иргэний байгууламжуудыг зориудаар онилсон шинжтэй байв. Эмнэлгүүдийг агаараас олон дахин бөмбөгдөж байв. Эвслийнхний зарим довтолгоо дайны гэмт хэргийн шинжтэй байв. НҮБ-ын гаргасан тайланд дурдсанаар Йемен улсад 2 сая гаруй хүүхэд архаг тэжээлийн дутгадалд орсон бөгөөд оны эцсийн байдлаар 18,8 сая хүн хүмүүнлэгийн тусламж буюу хамгаалалт авах шаардлагатай байв.

Түүний зэрэгцээгээр, олон зуун мянган энгийн иргэд Ирак дахь зэвсэгт мөргөлдөөний галын дунд хашигдаад байна. Ихэвчлэн Шийт зэвсэгт бүлэглэлүүд болон Суннит овгийн дайчдаас бүрдсэн Иракийн Засгийн газрын зэвсэгт хүчин болон АНУ-ын толгойлсон олон улсын эвслийн агаарын цохилт, цэргийн бусад дэмжлэгээр туслуулсан Курд мужийн Засгийн газрын зэвсэгт хүчин Исламын улсын хяналтад байсан Фаллужа болон бусад хотуудыг эргүүлэн авсан. Оны төгсгөлд тэд Исламын улсын зэвсэгт хүчнийг Иракийн хоёр дахь том хот Мосулаас хөөн гаргах тулалдаан хийж байв. Оролцогч бүх талууд харгислал үйлдсэн. Засгийн газрын зэвсэгт хүчин болон тэдэнтэй эвссэн партизанууд дайны гэмт хэрэг болон олон улсын хүмүүнлэгийн хууль, хүний эрхийн хуулийг зөрчсөн бусад зөрчлийг үйлдсэн бөгөөд ихэнх тохиолдолд Суннит урсгалыг шүтэгч Арабуудыг шүүхээс гадуур цаазлах буюу бусад байдлаар хууль бусаар хөнөөж, эрүүдэн шүүж, энгийн номхон

иргэдийн гэр орныг зориудаар устгаж байв. Тэд олон зуун эрчүүд, хөвгүүдийг хүчээр сураггүй болгосон ба өмнөх жилүүдэд Засгийн газрын зэвсэгт хүчин ба тэдэнтэй эвссэн партизануудыг баривчлан авч явснаас хойш сураггүй болсон мянга мянган хүний хувь заяа хэрхэн эргэснийг тодруулах талаар ямар ч алхам хийгээгүй.

Исламын улс бүлэглэл өөрийн хяналтад байгаа газарт тэднийг эсэргүүцсэн буюу засгийн газрын зэвсэгт хүчинтэй хамтран ажилласан хэмээн сэжиглэн нутгийн иргэдийг цаазалсаар байна. Исламын улс бүлэглэлийн дайчид тэдний тогтоосон хувцаслах болон биеэ авч явах жишгийг дагаагүй хүмүүсийг шийтгэж, хулгайлж, эрүүдэн шүүж, ташуурдах болон бусад харгис шийтгэлийг ашиглаж байгаагийн зэрэгцээ Язиди охид эмэгтэйчүүдийг хүчирхийлэлж, бэлгийн боолчлолд өртүүлж, хөвгүүд, түүний дотор баригдсан Язиди хөвгүүдийн тархийг угааж, цэрэгтээ элсүүлэн тулалдаанд ашиглаж байна. Засгийн газрын зэвсэгт хүчин амжилттай урагшлахын хэрээр Исламын улсын зэвсэгт хүчин энгийн иргэдийг хямрал мөргөлдөөнтэй газраас дүрвэхэд саад хийж, тэднийг хүн-бамбай болгон ашиглаж, зугтахыг оролдсон хүмүүсийг буудан хороож, гэр бүлийнхнийг нь шийтгэж байв. Бусад газар, түүний дотор нийслэл Багдад хотод Исламын улс амиа золиослогчдыг ашиглан бөмбөг дэлбэлэх буюу бусад халдлагыг хаа ч хамаагүй, эсхүл энгийн номхон иргэдийг зориуд онилон хүн ихтэй зах, Шийт шашны мөргөлийн газрууд болон олон нийтийн бусад газруудад халдлага үйлдэж, олон

зуун хүнийг алж, шархдуулсан.

Хуучин удирдагч Хурандаа Муаммар аль-Гаддафийн засаглал нуран унаснаас хойш 5 жил өнгөрсөн хэдий ч Ливи улс зэвсэгт мөргөлдөөний улмаас хуваагдмал байдалтай байсаар байна. НҮБ-ын дэмжлэгтэй яриа хэлэлцээний дүнд байгуулсан Үндэсний Эвлэрлийн Засгийн газрын Ерөнхийлөгчийн зөвлөл эрх мэдлээ бэхжүүлж чадаагүй. Уг зөвлөлийн бүрэн эрхийг Ливийн парламент болон Триполид байрлаж байсан хуучин өрсөлдөгч засгийн газруудыг дэмждэг хүчнүүд, нөгөө талаас Тобрук, аль-Байда зэрэг хүчнүүд хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Исламын улс Сирте хот дахь бэхлэлтээ олон сар дайцсаны эцэст Үндэсний Эвлэрлийн Засгийн газрын зэвсэгт хүчинд алдсан нь дүрвэгсдийн нэг шинэ давалгааг үүсгэсэн. Хямрал мөргөлдөөнд оролцогч бүх талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтойгоор зөрчиж, тэр дундаа дайны гэмт хэрэг үйлдсээр байна. Янз бүрийн зэвсэгт хүчнүүд эмнэлгүүд рүү довтолж, агаарын цохилт өгч, их буугаар галлаж байгаагийн улмаас энгийн номхон иргэд олноор алагдаж, шархадлаа. 6-р сард Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын гаргасан тайланд дурдсанаар хямрал мөргөлдөөнтэй нутаг дэсвэрт байгаа эмнэлгүүдийн 60% үйл ажиллагаагаа зогсоосон буюу хүрч очих боломжгүй байна.

Ливи улс дахь зэвсэгт бүлэглэлүүд болон партизанууд хүмүүсийг хулгайлж, барьцааны хүмүүсийг хоригдлуудаар солих буюу мөнгөөр солих зорилгоор хорихын зэрэгцээ энгийн номхон иргэдийг угсаа гарал, үзэл бодол, улс төрийн болон овгийн

харьяаллаар нь ялгаварлан цагдан хорьж байна. Исламын улсын зэвсэгт хүчин өөрсдийн хяналтад байгаа буюу хяналтдаа авахаар тулалдаж байгаа нутаг дэвсгэрт баригдсан сөрөг хүчний дайчид болон энгийн номхон иргэдийг дур зоргоор алж байна. Бусад хүчнүүд, түүний дотор Үндэсний эвлэрлийн засгийн газартай эвссэн хүчнүүд Триполи, Бенгази болон бусад газарт хууль бус аллага үйлдсэн.

Зэвсэгт мөргөлдөөнд автсан бусад улсын нэгэн адил Ливи улсад олон жил өрнөж буй цуст тэмцлийн улмаас хүмүүсийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг асар ихээр хохироож байгаа бөгөөд хоол хүнс, цахилгаан, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол болон бусад үйлчилгээ авах боломж ихээр хумигдсан.

## **ОЛОН УЛСЫН ОРОЛЦОО**

Сири, Йемен, Ирак, Ливи зэрэг улс дахь зэвсэгт мөргөлдөөн бүгд ямар нэг байдлаар гадаад орны хөндлөнгийн оролцооны улмаас илүү хүндэрсэн. Европчууд болон бусад орны иргэд тус бүс нутагт Исламын улсын төлөө дайтахаар ирж байгаа бол Орос, АНУ, Турк, Саудын Араб болон тус бүс нутгийн бусад улсын зэвсэгт хүчин үхлийн ул мөрөө үлдээсэн.

Сирийн Засгийн газрын зэвсэгт хүчин 2016 онд Ливан, Ирак, Иранаас ирсэн Шийт партизанууд болон сөрөг хүчний хяналтад байгаа газруудад мянга мянган энгийн номхон иргэдийг алж, шархдуулсан Оросын бөмбөгдөлтийн дараа сөрөг хүчний зэвсэгт бүлэглэлүүдээс ихээхэн хэмжээний нутаг дэвсгэр булаан авсан юм. АНУ-ын тэргүүлсэн цэргийн эвсэл Сири ба Ирак дахь

Исламын улсын эсрэг агаарын цохилт өгөх явцдаа энгийн иргэдийг алж, шархдуулсан. Түүнчлэн АНУ-ын зэвсэгт хүчин Ливи болон Йеменд цохилт өгсөн. Саудын Арабын тэргүүлсэн цэргийн эвсэл Йемен улсад АНУ, Их Британи болон бусад улсаас авсан, олон улсад хориглосон кластер байлдааны хэрэгсэл болон бусад зэвсгийг Хутхи болон тэдний холбоотнуудын хяналтад байгаа газарт ялгаварлалгүйгээр хэрэглэсний улмаас энгийн иргэд алагдсан.

Түүний зэрэгцээгээр, байнгын гишүүн орнуудын санал хуваагдлаас үүдэн хүч чадал нь сулраад байгаа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл олон улсын энх тайван, аюулгүй байдалд учирч буй аюул заналын эсрэг, энгийн номхон иргэдийг хамгаалах үүргээ гүйцэтгэж чадахгүй байна. Энхийн хэлэлцээг дэмжих НҮБ-ын хүчин чармайлт олигтой ахиц авчирч чадахгүй байгаагаас гадна НҮБ-ын системийн байгууллагууд хямрал мөргөлдөөнөөс үүдэн мянга мянган энгийн номхон иргэд бүслэлтэд амьдрахаас аргагүйд хүрч, олон сая хүн орон гэрээ орхин шилжин суурьших буюу аюулгүй газар хайн дүрвэхээс аргагүйд хүрээд байгаа хүмүүнлэгийн нөхцөл байдлыг шийдвэрлэхэд хүчин мөхөстөж байна

### **ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ**

Бүс нутаг даяар төрийн эрх баригчид үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан хийх эрх чөлөөг ямар нэг байдлаар хязгаарлаж, саад тотгор учруулсаар байна. Олонх Засгийн газар өөрсдөд нь шүүмжлэлтэй хандсан, эрх

мэдэлтнүүд, шашныг болон шашны бэлэгдлийг гутаан доромжилсон, нууцлахыг хүссэн мэдээллийг нь задруулсан зэрэг тохиолдолд тайван замаар үг хэлэх, бичих буюу бусад байдлаар үзэл бодлоо илэрхийлэх, тэр дундаа нийгмийн сүлжээнд болон онлайнаар сэтгэгдэл үлдээх зэргийг эрүүгийн гэмт хэрэг хэмээн үзэх хуулийг мөрдсөөр байна. Бахрейн улсын эрх баригчид хүний эрхийн хамгаалагчдыг “дэглэмийн эсрэг үзэн ядалтыг дэвэргэсэн”, Саудын Арабын Йемен дэх бөмбөгдөлтийг шүүмжилсэн зэрэг хэрэгт холбогдуулан мөрдөн байцааж, шоронд хорьсон бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг Бахрейн болон Булангийн бусад орнуудыг “доромжилсон” сэтгүүлчдийг ажил авахыг хориглосон.

Ираны эрх баригчид тайван замаар шүүмжлэгч олон хүнийг үндэсний аюулгүй байдалд харшилсан гэх тодорхой бус, хуурамч хэрэг үүсгэн мөрдөн байцааж, шоронд хийсэн. Тэдний дунд хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид, хуульчид, үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтнүүд, кино найруулагчид, хөгжимчид, эмэгтэйчүүдийн эрхийн идэвхтнүүд, угсаатны ба шашны цөөнхийн эрхийн идэвхтнүүд, цаазаар авах ялын эсрэг тэмцэгчид байв. Кувейт улсын кибер гэмт хэргийн эсрэг шинэ хуулиар засгийн газар ба шүүхийн байгууллагыг онлайнаар, тайван замаар шүүмжилсэн хүмүүсийг 10 хүртэл жил хорих ялаар шийтгэх боломжтой болсон бол өөр нэг хуулиар Эмир, Бурхан болон Исламын шашны зөнчдийг доромжилсон хэргээр ял сонсож байсан хэн ч болов парламентийн

сонгуульд нэр дэвших эрхгүй болсон. Түүнчлэн Оман улсад Засгийн газрыг шүүмжлэгчид болон сэтгүүлчдийг шоронд хорьсон бөгөөд эрх баригчид албаны хүмүүсийн авлигын талаар мэдээлсэн сонинг хаасан бол Саудын Араб улсын шүүх “удирдагчаас урвасан” гэх мэт маш тодорхойгүй хэрэгт хүмүүсийг буруутган урт хугацаагаар хорих ял оноосон. Йордан улсад зэвсэглэсэн этгээд шог зураачийг хөнөөсөн бөгөөд эрх баригчид тэрхүү зураачийг Исламыг “доромжилсон” зураг нийтэлсэн хэмээн буруутгаж байсан юм. Алуурчныг дараа нь хүн амины хэрэгт татсан.

Тус бүс нутагт эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг ихээхэн боомилдог. Иран, Кувейт, Катар, Саудын Араб зэрэг улс бие даасан улс төрийн намыг хүлээн зөвшөөрдөггүй. Олон оронд эрх баригчид хүний эрхийн бүлгүүд, түүний дотор эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчдийг онилсоор байна. Египет улсын эрх баригчид эрүү шүүлт болон улс төрийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилдэг нэр хүндтэй төвийг хаах тушаал гаргасан бөгөөд бусад хүний эрхийн бүлгүүдийн хөрөнгийг царцааж, ТББ хараат бус үйл ажиллагаа явуулах боломжийг хаасан шинэ хуулийн төслийг танилцуулсан. Алжирын засгийн газар орон нутгийн хүний эрхийн бүлгүүд түүний дотор Алжирын Эмнести Интернэшнлийг хуулийн дагуу бүргүүлэхэд саад тотгор учруулсаар байна. Морокко улсын эрх баригчид мөн адил хэд хэдэн хүний эрхийн бүлгүүдийг хуулийн дагуу бүртгүүлэхэд нь саад тотгор учруулсаар байна. Бахрейн улсын эрх баригчид б

дугаар сард удирдагчийг нь 2014 онд шоронд хийж, хөрөнгийг нь хураан аваад байсан сөрөг хүчний гол нийгэмлэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн бөгөөд 7 дугаар сард шүүхээс уг байгууллагыг татан буулгах шийдвэр гаргуулж чадсан. Ираний Сэтгүүлчдийн Холбоо Ираны Ерөнхийлөгчид хандан 2013 оны сонгуулиар өгсөн амлалтаа биелүүлж, үйл ажиллагааг нь түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлахыг шаардсан боловч амжилтад хүрээгүй. Түүнчлэн эрх баригчид Ираны Багш нарын Үйлдвэрчний эвлэлийн тусгай зөвшөөрлийг сунгахаас татгалзсан бөгөөд “хууль бус бүлгийн гишүүнээр элссэн” хэргээр зарим нэг гишүүдийг нь шоронд хорьсон байна. Ираны Хувьсгалт Гвард эмэгтэйчүүдийн хүний эрхийн хамгаалагчдыг дарамталсан.

Алжирын эрх баригчид нийслэл Алжир хотод жагсаал цуглаан хийхийг хориглосон 15 жилийн настай хоригийг хадгалсаар байгаа бөгөөд бусад газарт жагсаал цуглааныг хүчээр тарааж, тайван замаар жагсагчдыг шоронд хорьсоор байна. Бахрейны Засгийн газар нийслэл Манама хотод бүх төрлийн жагсаал цуглаан хийхийг хориглосон хэвээр байгаа бөгөөд аюулгүй байдлын хүчнийхэн Шийт шүтлэгтнүүд голлон амьдардаг тосгон сууринд гарсан жагсаал цуглааныг тараахдаа хүч хэтрүүлэн хэрэглэж байна.

Ирак, Ливи, Сири, Йемен зэрэг улсад зэвсэгт бүлэглэлүүд өөрсдийн хяналтад байгаа нутаг дэвсгэрт үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлаж байна. Иракт Исламын улс бүлэглэлийн шүүхүүд “завхайрсан” хэрэг үйлдсэн хүмүүст

чулуугаар шидэж цаазлах ял оногдуулж байгаагаас гадна тамхи татсан, Исламын улсын тогтоосон хувцаслах жишгийг дагаагүй буюу бусад дүрмийг биелүүлээгүй хэрэгт ташуурдах болон бусад төрлийн бие махбодийн шийтгэл ногдуулж байна. Ливи улсад зэвсэгт бүлэглэлүүд хүний эрхийн хамгаалагчид болон сэтгүүлчдийг дарамталж, хулгайлж, эрүүдэн шүүж, амь насыг нь хөнөөж байна.

### **ШҮҮХ ТОГТОЛЦОО**

Тус бүс нутаг даяар аюулгүй байдлын хүчнийхэн Засгийн газрыг шүүмжлэгчид болон өрсөлдөгчдийг олонх тохиолдолд тодорхой бус, өргөн хүрээтэй хуулийн заалт ашиглан дур зоргоор баривчлах буюу цагдан хорьж байна. Сири улсад Засгийн газрын зэвсэгт хүчний баривчилсан олон хоригдол хүчээр сураггүй алга болсон. Египет болон Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ)-д хоригдлуудыг хүчээр сураггүй болгох нь түгээмэл бөгөөд хоригдлуудыг гадаад ертөнцөөс тусгаарлаж, эрх зүйн туслалцаа авах боломжийг нь хааж, эрүүдэн шүүх замаар “гэм буруугаа хүлээсэн мэдүүлэг” гаргуулж, түүнийг нь шүүх хуралд ял оноохдоо ашигладаг. Шүүх хурал хийлгүйгээр хорих явдал өргөн хэрэглэгддэг бөгөөд Израйлын эрх баригчид олон зуун Палестинчуудыг хугацаагүйгээр сунгаж болдог захиргааны шийдвэрээр хорьж байгаа бол Йорданы эрх баригчид олон мянган хүнийг шүүх хуралгүйгээр 1 жил хүртэл хугацаагаар хорихыг зөвшөөрдөг 1954 оны хуулиар хорьж байна.

Ялангуяа Бахрейн, Египет, Иран, Ирак, Израйл, Палестиний Эзлэгдсэн нутаг дэвсгэр, Ливи,

Саудын Араб, Сири, АНЭУ зэрэг улсад хоригдлуудыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал ихээхэн тархсан. Түгээмэл хэрэглэгддэг эрүү шүүлтийн аргууд нь зодох, цахилгаанд цохиулах, унтуулахгүй байх, эвгүй байрлалд удаан байлгах, бугуй болон шагайнаас нь олон цагаар дүүжлэх, хоригдлуудыг өөрсдийг нь буюу ойр дотны хүмүүсийг нь заналхийлэх зэрэг болно. Хэдийгээр Тунис улс хоригдлуудын (терроризмын хэрэгт сэжиглэгдсэнээс бусад) аюулгүй байдлыг сайжруулсан шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хууль баталсан боловч эрүүдэн шүүсэн тохиолдол гарсаар байгаа бөгөөд 2013 онд байгуулагдсан үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага бэхжиж амжаагүй байна.

Египет, Иран, Ирак, Саудын Араб, Сири, АНЭУ-ын шүүхүүд ялангуяа яллагдагчид нь үндэсний аюулгүй байдал буюу терроризмын хэргээр, тэр дундаа цаазаар авах ялтай хэрэгт шүүгдэж байгаа тохиолдолд шударгаар хэргийг нь шүүж чадахгүй байх явдал гарсаар байна. Бахрейн улсын эрх баригчид шүүмжлэлтэй ханддаг шашны зүтгэлтнүүд болон терроризмын хэрэгт ял сонссон олон хүний иргэний харьяаллыг цуцлах шийдвэр шүүхийг ашиглан гаргуулснаар тэдний заримыг тус улсаас албадан гаргасны зэрэгцээ олон хүнийг харьяалалгүй болгосон.

Саудын Арабын шүүхүүд олон зуун удаа ташуурдах зэрэг харгис шийтгэл оноосоор байгаа бол Иран улсын шүүх ялтнуудыг ташуурдах, хурууг нь тайрах, сохлох зэрэг ял оноосоор байна.

## **ДҮРВЭГСЭД, ДОТООДДОО ШИЛЖИН СУУРЬШИГСАД БОЛОН ЦАГААЧИД**

Бүс нутаг даяар сая сая хүмүүс зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл, улс төрийн хэлмэгдүүлэлт, эдийн засгийн доройтлоос зугтан дүрвэж байна. Тэдний дунд дүрвэгсэд болон орогнол эрэгчид, улс дотроо шилжин суурьшигчид, бүс нутгаас болон бусад газраас ирсэн цагаачид байдаг. Мөн маш олон хүүхэд байдаг бөгөөд зарим нь асран хамгаалагчгүй байгаа нь хүний наймаа, бэлгийн болон бусад хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байгаа юм.

Сирийн болон бусад зэвсэгт мөргөлдөөнүүд бүс нутгийн болон бусад улс орнуудад ноцтой үр дагавар авчирсаар байна. НҮБ-ын Дүрвэгсдийн агентлагийн мэдээлснээр Ливан улс Сирийн 1 сая гаруй дүрвэгсэд, Йордан улс 650 000 дүрвэгсдийг хүлээн аваад байна. Эдгээр голлох хүлээн авагч улс орнууд ийм олон тооны дүрвэгсэд орж ирсний улмаас өсөн нэмэгдсэн эдийн засаг, нийгмийн болон бусад хэрэгцээ шаардлагыг хангахын тулд бүх хүчээ дайчилж байгаа бөгөөд олон улсын хүмүүнлэгийн тусламж хангалтгүй, Европын болон бусад орнуудын дүрвэгсдийг дахин суурьшуулах тогтолцоо маш хангалтгүй байна. Голлох хүлээн авагч орнууд шинээр ирэгчдийг оруулахгүй байх үүднээс хилийн хяналтаа чангатгаж байгаа нь хямрал мөргөлдөөнөөс зугтахыг хичээсэн олон мянган хүнийг Сирийн хил дээр, амь насанд аюултай нөхцөлд хашигдахад хүргээд байна. Ливаны эрх баригчид зарим орогнол эрэгчдийг Сири улс руу буцаасан бол Туркийн

эрх баригчид орогнол эрэгчдийг нийтээр нь хүчээр буцаах, хууль бусаар буцаан хөөх арга хэмжээ авсан. Олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэл зовниж байгааг эс харгалзан Булангийн хамтын ажилагааны зөвлөлийн гишүүн орнууд тус бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөнөөс дүрвэсэн маш цөөхөн хүнийг хүлээн авсан бөгөөд зарим улс нь олон улсын хүмүүнлэгийн тусламжид зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүлээн авагч орнуудад дүрвэгсэд болон орогнол эрэгчид аюулгүй байдлыг хангаагүй, ядуу буурай нөхцөлд амьдрах нь олонтаа бөгөөд ажил эрхлэх боломжгүй, бичиг баримтгүй гэдэг шалтгаанаар баривчлагдах эрсдэлтэй байдаг. Ливи улсад хууль бусаар орж ирсэн гадаадын харьяат иргэд, түүний дотор орогнол эрэгчид, дүрвэгсэд болон Африкийн Сахарын бүсээс ирсэн цагаачид олон төрлийн дарамт шахалт, дарангуйлалд өртдөг. Мянга мянган хүмүүсийг шалган нэвтрүүлэх цэг дээрээс баривчлан засгийн газрын мэдлийн болон зэвсэгт бүлэглэлүүдийн хяналтад байдаг хорих газруудад тодорхойгүй хугацаагаар, маш хүнд нөхцөлд хорьдог. Хүний наймаачид хүмүүсийг барьцааны мөнгө авах зорилгоор хулгайлах, мөлжих, бэлгийн хүчирхийллийн золиос болгодог. Эдгээр болон бусад “цааш түлхэх” хүчин зүйлсийн нөлөөгөөр олон арван мянган хүмүүс бусад газраас орогнол эрэхэд хүрдэг бөгөөд олонх тохиолдолд хүний наймаачдад мөнгө төлж, чанаргүй, даац нь хэтэрсэн хөлгөөр Турк, Ливаны болон бусад эргээс гарч Газрын дундад тэнгисийг гатлах амь өрсөн алхам хийхэд хүрдэг. Мянга мянган



хүн Европт хүрдэг ч ирээдүй нь бүрхэг байдаг бөгөөд олон мянган хүн, түүний дотор хүүхдүүд далайд живж амь насаа алддаг.

Бүс нутгийн бусад улс орнуудад олонх нь Азиас ирсэн цагаач ажилчид мөлжлөг, хүчирхийллийн золиос болсоор байна. Кувейт, Катар, АНЭУ зэрэг хүн амын дийлэнх хувийг цагаач ажилчид бүрдүүлж, үндэсний эдийн засаг нь тэдний хөдөлмөр дээр тулгуурладаг улс орнуудад ивээн тэтгэгчтэй байх хатуу бодлого нь ажилчдыг ажил олгогчтой нь уяж, цагаач ажилчдын нөхцөл байдлыг илүү эмзэг болгосоор байна. Саудын Араб улсын Засгийн газар барилгын болон бусад төслүүдийн санхүүжилтыг танасны улмаас олон цагаачид ажил, орлогогүй үлдсэн. Олонх нь эмэгтэйчүүд байдаг цагаач гэрийн үйлчлэгчид ажил олгогчдын зүгээс бэлгийн, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, албадан хөдөлмөр эрхлэх эрсдэлд хамгийн их өртдөг бөгөөд энэ нь тус улсын эрх баригчид хөдөлмөрийн үндсэн хууль тогтоомжоор олгогдсон хамгаалалтыг гэрийн үйлчилгээний салбарт нэврүүлэхээс татгалзсаар байгаатай холбоотой юм. Йордан улсад 80 000 орчим эмэгтэй цагаачид гэрийн ажилтнаар ажилладаг бөгөөд хөдөлмөрийн хуулийн хамгаалалтад хамаардаггүй учраас хүчирхийлэл, мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй байдаг талаар орон нутгийн хөдөлмөрчдийн эрхийг хамгаалах бүлгийнхэн дурдсан.

### **ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ**

Бүс нутаг даяар охид эмэгтэйчүүдэд хуулиар болон практикт эрчүүдтэй эрх тэгш статус олгохыг эсэргүүцсээр

байгаа бөгөөд тэд хүйст суурилсан хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийлэл болон “нэр төрөө хамгаалах” аллагын золиос болсоор байна. Эрэгтэй “асран хамгаалагчтай байх” дүрэм журам Саудын Араб улсад эмэгтэйчүүдийн чөлөөтэй зорчих эрх чөлөө болон дээд боловсрол эзэмших, ажилд орох боломжийг хязгаарладаг. Тус улсын эрх баригчид эмэгтэйчүүдийг тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглосоор байна.

Гэрлэлт, салалт, хүүхэд асран хамгаалах, өв залгамжлалын асуудлаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан гэр бүлийн хууль тогтоомж өргөн хэрэглэгдсээр байгаа бөгөөд олон оронд хууль тогтоомж нь эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байна. Тухайлбал, эрт буюу хүчээр гэрлүүлэх явдлыг хориглох, гэр бүлийн хүрээний хүчингийн гэмт хэрэг, хүчингийн хэргийн хохирогчтойгоо гэрлэх замаар хуулийн хариуцлагаас зайлсхийх явдлыг хориглох зохицуулалт байхгүй байна. Бахрейн ба Йорданы эрх баригчид хүчингийн хэргийн хохирогчтойгоо гэрлэх замаар хуулийн хариуцлагаас зайлсхийх явдлыг эрүүгийн хуулиасаа хасах буюу бууруулах талаар зохих алхам хийсэн бөгөөд Морокко болон Тунис улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг батлах талаар ахиц гарсан. Гэвч бусад улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний дотор аллагыг “гэр бүлийн нэр төрөө хамгаалах” үүднээс үйлдсэн бол бага ял оноох, эмэгтэйчүүд хүчингийн гэмт хэргийн талаар мэдээлсэн

бол тэднийг мөрдөн шалгах хууль үйлчилсээр байгаа зэрэг нь охид эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл гарах, гарсан хүчирхийллийг нуун дарагдуулах нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

Иран улсын Тагнуулын яам болон Хувьсгалт Гвардын албан тушаалтнууд эмэгтэйчүүдийн эрхийн идэвхтнүүдийг баривчлах, шоронд хийх, дарамтлах зэргээр сүрдүүлж байгаагаас гадна эрх баригчид “ёс суртахууны цагдаа”-д эмэгтэйчүүд нүүрээ гивлүүрээр заавал хаах хуулийг хэрэгжүүлэх үүрэг өгсөн. Эмэгтэйчүүд өмссөн хувцаснаасаа болж доромжлол, хүчирхийлэл, дур зоргоор баривчлах, хорих эрсдэлд байнга өртдөг. Түүний зэрэгцээгээр, хуулийн төсөлд Дээд удирдагчийн эмэгтэйчүүд орон гэрээ авч явах, үр хүүдээ өсгөх “уламжлал” үүргээ илүү сайн гүйцэтгэх ёстой бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг бууруулахаар заналхийлсэн уриалгыг онцлон дурдсан.

Зэвсэгт мөргөлдөөн өрнөж, бүслэлт, агаараас бөмбөгдөлт болон Засгийн газар болон сөрөг хүчнийхний бусад төрлийн дайралт болж байгаа нутаг дэвсгэрт охид эмэгтэйчүүд амь өрсөн нөхцөлд амьдарч байна. Эр нөхөр болон эрэгтэй хамаатнууд нь алагдсан буюу сураггүй алга болсны улмаас хүний наймаа болон бусад хүчирхийлэлд илүү их өртөх магадлал өсдөг. Исламын улсын зэвсэгт хүчин Ирак, Сири дэх өөрсдийн хяналтад байгаа нутаг дэвсгэрт мянга мянган Язди охид эмэгтэйчүүдийг хорионд байлгаж байгаа бөгөөд бэлгийн хүчирхийлэл, боолчлол, бэлгийн боолчлолын золиос болгож, Исламын шашинд хүчээр оруулж байна.

## **ЦӨӨНХИЙН ЭРХ**

Угсаатны, шашны болон бусад цөөнхийн гишүүд хэд хэдэн оронд дарангуйлал, хүчирхийлэлд өртсөөр байгаа бөгөөд бүс нутагт эрчимжээд байгаа зэвсэгт мөргөлдөөний улмаас улс төрийн туйлшрал гүнзгийрч байгаа нь байдлыг улам хурцатгаж байна. Саудын Араб улсын эрх баригчид Шийт цөөнхийг нухчин дарсаар байгаа бөгөөд Шийт идэвхтнүүдийг баривчлан хорьсноос гадна Шийтийн тэргүүлэх шашны зүтгэлтнийг цаазаар авсан. Ираны эрх баригчид үндэстний цөөнхөд хамаарах олон тооны идэвхтнүүдийг барьж хорьсон бөгөөд шашны цөөнхийн хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших, улс төрийн албан тушаал хаших эрх болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ хэрэгжүүлэхэд нь ялгаварлан гадуурхсан хязгаарлалт тавьдаг. Египет улсад Коптик Христийн шашинтнууд, Шийт урсгалыг дагагчид болон Бахайчүүд хуулиар болон практикт ялгаварлан гадуурхалтад өртсөөр байгаа бөгөөд шинэ хуулиар сүм хийд барих, засварлахад хязгаарлалт тогтоосон. Кувейтын эрх баригчид удаан хугацаагаар оршин суусан 100 000 орчим Бидунчуудад иргэний харьяалал олгохоос татгалзсаар байгаа бөгөөд тэд харьяалалгүйн улмаас төрийн үйлчилгээ авах боломжгүй байдаг.

## **ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЕР БОЛОН ИНТЕРСЕКС ХҮМҮҮСИЙН ЭРХ**

ЛГБТИ хүмүүс “завхайрсан”, “биеэ зохисгүй авч явсан” хэргээр баривчлагдах буюу хоригдох эрсдэлтэй байдаг ба Бахрейн, Египет, Иран, Морокко, Тунис зэрэг

улсад харилцан зөвшөөрсөн ижил хүйсийн бэлгийн харилцааг хуулиар гэмт хэрэгт тооцож шийтгэдэг.

## **ЯЛ ЗАВШИХ**

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд дайны гэмт хэрэг үйлдсэн, олон улсын эрх зүйг бүдүүлгээр зөрчсөн, хүний эрхийг ноцтой зөрчсөн хэрэгтээ ямар ч ял шийтгэл хүлээхгүй байна. Түүнчлэн хууль бус аллага, эрүү шүүлт болон хүний эрхийн зөрчил үйлдсэн улс орнуудын эрх баригчид хариуцлага хүлээхгүй өнгөрсөөр байна.

Зарим тохиолдолд олон арван жилийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт ч ял завшсаар байна. Алжир улсын эрх баригчид 1990-ээд онд ноцтой гэмт хэрэг үйлдсэн зэвсэгт хүчнийхнийг хамгаалсан хэвээр байна. Морокко улсад Үнэн ба Эрх тэгш байдлын Комисс олон арван жилийн турш үйлдэгдсэн зөрчлийн талаар тайлагнаснаас хойш 10 жил өнгөрсөн хэдий ч төрийн бодлого гэм буруутай этгээдүүдийг хамгаалсан хэвээр байна. Израйл улсын засгийн газар 2010 онд Израйлын цэргүүдэд алагдсан Турк иргэдийн гэр бүлийнхэнд нөхөн олговор өгсөн боловч Газа болон Ливанд саяхан болсон зэвсэгт мөргөлдөөний үеэр Израйлын зэвсэгт хүчний үйлдсэн дайны гэмт хэрэг болон олон улсын эрх зүйн бусад ноцтой зөрчил болон Вест Банк болон Гакад Палестинчуудын эсрэг үйлдсэн хууль бус аллага, эрүү шүүлт болон бусад зөрчлийн гэм буруутанд хариуцлага хүлээлгэх талаар ямар ч арга хэмжээ аваагүй. Палестиний Засгийн газар Ромын дүрмийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан нь ОУЭШ-ийн “түрэмгийллийн гэмт хэрэг”-ийг шүүх эрхийг хүлээн зөвшөөрсөн

хэрэг юм. Палестиний Засгийн газар ч тэр Гака дахь де факто Хамасын Засгийн газар ч тэр өмнөх хямрал мөргөлдөөнүүдийн үеэр Палестиний зэвсэгт бүлэглэлүүдийн үйлдсэн гэмт хэрэг, тэр дундаа Израйл улс руу пуужин харвасан болон “хамтран ажиллагчдыг” дур зоргоор алсан хэрэгт гэм буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх талаар ямар ч алхам хийгээгүй.

Египет улсын аюулгүй байдлын хүчнийхэн үйл ажиллагааг нь хориглосон Исламын ахан дүүс байгууллагын дэмжигчид болон бусад шүүмжлэгчид, сөрөг хүчнийхнийг онилон дур зоргоор баривчлах, хүчээр сураггүй болгох, эрүү шүүлт тулгах зэрэг ноцтой зөрчлийг ямар ч ял шийтгэл хүлээлгүй үйлдсэн байна. Цагдаагийн эрх мэдлийн тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр аюулгүй байдлын хүчнийхэн “иргэдтэй зүй бусаар харьцахыг” хориглосон боловч эрх баригчид 2011 оны бослогоос хойших жилүүдэд хууль бус аллага болон бусад ноцтой зөрчлийг үйлдсэн хүчний байгууллагын ажилтнуудад хариуцлага тооцох чиглэлээр дорвитой алхам хийгээгүй.

Бахрейн улсад 2011 онд гарсан нийтийн жагсаал цуглааныг эрх мэдэлтнүүд хүч хэрэглэн дарсныг олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс зэмлэн буруушаасан бөгөөд тус улсын засгийн газар хүчний байгууллагын үйлдсэн хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах, хариуцлага тооцох албан ёсны байгууллагыг байгуулахад хүрсэн. Уг байгууллага 2016 оныг хүртэл ажилласан бөгөөд хэдийгээр хангалттай үр дүнтэй ажиллаж чадаагүй ч хүчний байгууллагын

цөөн тооны доогуур албан тушаалтныг мөрдөн шалгасан. Гэвч оны эцэст 2011 онд эрүү шүүлт, хууль бус аллага үйлдсэн болон хүч хэтрүүлэн хэрэглэсэн гэм буруутай дээд тушаалын нэг ч офицерт хариуцлага хүлээлгээгүй.

Тунис улс тус бүс нутагт шилжилтийн шүүхийн процессыг хэрэгжүүлж буй цорын ганц улс бөгөөд Үнэн, ба нэр төрийг сэргээн тогтоох комисс 1955-2013 он хүртэл үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийн талаар олон мянган гомдол хүлээн авсан бөгөөд комиссын хурлуудыг нээлттэйгээр, телевизээр дамжуулан хийж байсан. Гэвч өмнөх жилүүдэд авсан авлигаа буцаан төлсөн тохиолдолд төрийн өндөр алба хашиж байсан болон бизнес эрхлэж байсан хүмүүсийг ялаас чөлөөлөх хуулийн төслийг Засгийн газраас оруулж ирсэн нь тус комиссын үйл ажиллагааг үгүйсгэж байна.

12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей Сири улсад 2011 оны 3 дугаар сараас хойш үйлдэгдсэн дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх хараат бус олон улсын механизм бий болгосон нь ихээхэн найдвар төрүүлсэн юм. Мөн 12-р сард НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл ховор тохиолдох нэгдмэл байр сууриа илэрхийлж, Израйл улс 1967 оноос хойш эзлэн авсан Палестиний нутаг дэвсгэрт суурьших нь хууль зүйн үндэсгүй бөгөөд олон улсын эрх зүйг зөрчиж, энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байна хэмээн үзсэн. АНУ хориг тавих эрхээ эдлэхийн оронд түтгэлзсэн бөгөөд Зөвлөлийн бусад 14 гишүүн уг тогтоолыг дэмжсэн санал өгсөн. Эдгээр нааштай өөрчлөлтийн хажуугаар НҮБ-ын Аюулгүйн

Зөвлөлийн байнгын 5 гишүүний дөрөв нь буюу Франц, ОХУ, Их Британи болон АНУ Сири, Ирак, Йемен, Ливи зэрэг улсад дайны гэмт хэрэг болон олон улсын эрх зүйг зөрчсөөр байгаа хүчнийг идэвхтэй дэмжиж байгаагийн зэрэгцээ өөрсдөө ч ноцтой хүний эрхийн зөрчил үйлдсээр байгаа нь олон улсын түвшинд шударга ёс, хариуцлагын тогтолцоог бий болгох ирээдүйг бүдгэрүүлж байна.

### **ЦААЗААР АВАХ ЯЛ**

Тус бүс нутгийн бүх улс цаазаар авах ялыг хадгалж үлдсэн ч энэ ялыг оногдуулж, хэрэглэх гэмт хэргийн хүрээ харилцан адилгүй байна. Цаазаар авах ялыг энгийн гэмт хэрэгт халсан Бахрайн, Оман, Израйль улс цаазаар авах ял оногдуулаагүй байна. Харин Алжир, Морокко, Тунис улсын шүүхээс цаазаар авах ялыг үргэлжлүүлэн оногдуулсаар байгаа ч эрх баригчид нь гүйцэтгэл явуулахаас татгалзах урт хугацааны бодлого баримталсан хэвээр байна. Эсрэгээр Иран, Саудын Араб, Иракийн Засгийн газар цаазаар авах ял гүйцэтгэдэгээрээ дэлхийд тэргүүлэгч орон хэвээр үлдсэн ба олноор нь шударга бусаар шүүх ажиллагаа явуулж энэ ялыг оногдуулсаар байна. Иран улс ихэнхдээ хүчирхийллийн бус гэмт хэрэг, насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах ял хэрэглэсээр байна. 1 дүгээр сарын 2-нд Саудын Арабын эрх баригчид 12 газарт 47 хоригдлыг цаазалсан бол 8 дугаар сарын 21-нд Иракийн эрх баригчид 36 эрэгтэйг эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэснийг үл харгалзан цаазалжээ. Египет улсад 2013 оноос хойш шударга бус цэргийн болон бусад шүүхээс

олон зуун хүнд цаазаар авах ял оногдуулж гүйцэтгэжээ.

### **ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧИД**

2016 онд бид хүний зан араншингийн хамгийн муу муухай чанараас гадна хүмүүсийн ёс зүйн хамгийн сайн сайхныг олж харлаа. Хохирогчид, хүний эрхийг хамгаалахаар сөрөн зогссон олон хүмүүс өөрсдийн амь нас, эрх чөлөөгөө эрсдэлд оруулсан. Энд эмнэлгийн ажилтнууд, хуульчид, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, эмэгтэйчүүд, цөөнхийн эрхийг хамгаалагчид, нийгмийн идэвхтнүүд болон бусад нэрлэж, жагсааж барахааргүй олон хүн багтаж байна. Хүчирхийлэл, заналхийллийг сөрөн зогссон тэдний эр зориг шийдэмгий байдал Ойрх Дорнод болон Хойд Африкийн бүс нутгийн хүмүүст сайхан ирээдүйн итгэлийг бадраасан.

# ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ТАЙЛАН 2016/17 ДЭЛХИЙ ДАХИНЫ ХҮНИЙ ЭРХИЙН БАЙДАЛ

Эмнести Интернэшнлийн Тайлан 2016/17 нь 159 улс орон, газар нутаг дахь 2016 оны хүний эрхийн төлөв байдлыг оруулсан.

2016 онд засгийн газар, зэвсэгт бүлэглэлүүд хүний эрхийг олон янзаар тоо томшгүй зөрчсөнөөс болж, сая сая хүний хувьд ёроолгүй зовлон, хэмжээлшгүй айдсаар дүүрэн жил болж өнгөрөв. Дүрвэгсдийн нүүдэл, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хамгаалалтгүй байдал, засгийн газруудын мөшгин хяналт, ял шийтгэлгүй үлдэх явдал ихэссэн нь санаа зовоосон гол асуудал байлаа.

Мөн энэ тайланд ихэвчлэн хүнд, аюултай байдалд ч хүний эрхийн төлөө дэлхий дахинаа дуу хоолойгоо хүргэсэн хүмүүсийг онцолж байна. Тайлан Эмнести Интернэшнлийн санаа зовж буй гол асуудлууд, үйл ажиллагаа явуулах шаардлагыг багтаасан. Хүний эрхийн талаар сонирхож буй хэн ч бай, мөн идэвхтнүүд, бодлого боловсруулагчийн зайлшгүй унших ёстой зүйл бол энэ тайлан юм.

[www.amnesty.org](http://www.amnesty.org)  
[www.amnesty.mn](http://www.amnesty.mn)



Бид хэвлэл тутмаасаа 1 төгрөгийг Монголын Эмнести Интернэшнл-д хандивладаг бөгөөд бидний энэ хандив ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ үйлсэд зориулагддаг.